- Мандах, Сайхандулаан сумуудын доогуур хад ихтэй тул дулааны шугамд орж чаддаггүй. Бусад нь нийтийн дулааны шугамд холбогдсон. Дэд бүтэц сайжирч байгаа. Дулаанаа яаж шийдэхэд тогоор шийдэх боломжтой.

АХЛАХ МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН, ЦАГДААГИЙН ХОШУУЧ Б.ХУЛАН	2025 оны 6-р сарын 23

Танай аймаг/суманд гарч буй гэмт хэргийн (хүний амьд явах эрх; хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг; хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг; хүн худалдаалах болон хулгайлах; хүүхдийн эсрэг; өмчлөх эрхийн эсрэг , хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, биеэ үнэлэх, амиа хорлох, бусад нийгмийн дэг журам зөрчих зэрэг) түвшин ямар байна вэ?

- Аймаг түвшинд гэмт хэргийн түвшин нэмэгдэж байна. Голлох шалтгаануудыг тухайн чиглэл хариуцсан цагдаа гаргаж ирнэ.
- Гол нөлөөлөх хүчин зүйлс нь салалт, хардалт, согтуурал, хувь хүний тааламжгүй харьцаа зэргээс шалтгаалдаг.
- Нутгийн хүмүүс гэмт хэрэг үйлдэх нь харьцангүй бага. Гаднаас ирсэн хүмүүс ихэвчлэн гэмт хэрэгт холбогддог. Ихэвчлэн хүний халдашгүй байдал, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн тохиолдол гардаг. Үүнээс гадна өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг дотроо цахим залилан, хулгайлах зэрэг нь дийлэнхийг эзэлдэг.
- Өмчийн эсрэг гэмт хэрэг нэмэгдэж байна, ялангуяа луйвар, хулгай. Кибер гэмт хэрэгт дараах тохиолдлууд багтдаг:
    - Facebook дансыг хакердах, дараа нь зөвшөөрөлгүй мөнгө шилжүүлсэн.
    - Telegram-тэй холбоотой залилангийн өсөлт.
    - Улс даяар өргөн тархсан ч ийм гэмт хэрэг мөн адил хөдөө орон нутагт гарч байна.
- Мал хулгай ба хувийн аюулгүй байдал: Малын хулгай, хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг их гарч байна. Малын хулгай бүртгэгдэхэд холбогдогч нь тогтоогдсон эсэхийг авч үзнэ. Эзэн холбогдогч нь Дорноговь аймгийн нутагт эсвэл, гаднаас үйлдэгдсэн эсэхээс хамаарч янз бүр байдаг.

Замын аюулгүй байдал ба тээврийн хэрэгслийн хэрэглээний дүрмийн зөрчил

- Зам тээврийн шалтгаан нөхцлийг замын цагдаагийн тасгийн даргаас авна. Зам тээврийн осол тоон дээр тулгуурладаггүй.
- Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-д өөрчлөлт ороод 27.10 дугаар зүйлд гэмт хэрэг рүү шинэчлэгдэж орсонтой холбоотойгоор хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг өсөлттэй байна.

Орон нутгийн цагдаагийн байгууллагад тулгарч буй гол бэрхшээл, саад бэрхшээлүүд юу вэ?

- Хүндрэл бэрхшээлүүд байдаг. Замын цагдаагийн тасаг орон тоо цөөтэй, ажлын ачаалалтай нөхцөлд нэг албан хаагч олон хүнд үйлчлэх тохиолдол гардаг. Нэг нь ээлжийн амралт эдэлж байх давхар алба хаших байдал гардаг.
- Урьдчилсан сэргийлэх чиглэлээр ажлаа хийж явдаг. Суманд нэг төлөөлөгч, нэг цагдаагийн орон тоотойгоор ажил үүргээ гүйцэтгэдэг. Зарим сум төлөөлөгчгүй, шилжилт хөдөлгөөн их хийдэг, эсвэл ямар нэг шалтгаанаар гарвал ойролцоо сумын төлөөлөгч хариуцаж ажилладаг.
- Суманд нутаг дэвсгэрт гарснаар бүртгэгдэж явдаг. Нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн бол тухайн сумын төлөөлөгч хариуцаж авах гэх зэрэг. Иймд дийлэнхдээ төлөөлөгч бие дааж ганцаараа хэргүүдийг шалгадаг. Цагдаагийн хувьд зөрчил шалган шийдвэрлэх, үндсэн материалжуулах ажил хийдэг.
- Гаднаас ирсэн хүмүүс ихэвчлэн хүндрэл гаргадаг.

Төслийн хүрээнд гэмт хэрэг болон нийгмийн дэг журмын талаар ямар хүлээлт, санаа зовнил байна вэ?

- Урьдчилан таамаглах хэцүү.
- Бүтээн байгуулалттай холбоотой хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нэлээдгүй их гардаг. Энэ нь тухайн хувь хүний ухамсартай холбоотой болж байгаа юм. Жишээ нь: архи согтууруулах ундаа их хэрэглэх, гадны гэх байдлаар хандах зэрэг. Орон нутаг бол тайван, амгалан газар. Ихэвчлэн гадны хүмүүс хоорондоо архидан согтуурснаас маргаан үүсэх, бие биеэ цохих, зодох болдог.
- Хулгайлах гэмт хэрэг цөөнгүй гардаг. Эсвэл хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдэх магадлалтай тул урьдчилан сэргийлэхэд анхаарах шаардлагатай.

Биеэ үнэлэх болон амиа хорлох тухайд:

- Биеэ үнэлэлтийн талаар эрүүгийн цагдаагийн тасгаас мэдээ авна. Одоогоор аймгийн хэмжээнд биеэ үнэлсэн тохиолдол бүртгэгдээгүй. Биеэ үнэлэлт гэх шууд тусгасан зүйл анги байхгүй, нуцлалтай байдаг. Эрүүгийн цагдаагийн тасаг/алба хариуцдаг тул тэднээс нарийвчилж асуух шаардлагатай.

Төслийн талаар мэдээлэл авсан уу?

- Ерөнхий мэдээлэл авсан, гэхдээ нарийвчилсан мэдээлэл аваагүй.

Дорноговь аймагт энэ төсөл ямар эерэг, сөрөг нөлөө үзүүлэх бол?

- Сум, орон нутгийн иргэд шууд ашиглах боломжгүй учраас давуу тал гэдэг зүйл харагдахгүй байна. Аялал жуулчлалын холбоо талаас ач холбогдол харагдахгүй байна. Амьтдын нүүдэллэх боломж дээр сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг хэлж мэдэхгүй байна. Эдийн засаг талаас бол ач холбогдолтой байх. Байгалийн баялгийг үр ашигтай ашиглаж эдийн засгийн үр өгөөжийг хүртэх ийм зорилготой төслүүд хэрэгжиж байгаа. Гэхдээ орон нутгийн иргэдтэй уялдсан бодлого энэ төсөл дээр заавал оруулах хэрэгтэй. Өндөр хүчдэлийн шугамын нөлөөллийг мэдэхгүй. Уул уурхайн хувьд тухайн бүс нутагт амьдарч байгаа малчдад бэлчээрийн усан хангамжийг тодорхой хэмжээнд шийдэж байгааг тооцоолох хэрэгтэй. Галав, Өөш, Долойдын говийн 3 сав газар байгаа. Энэ сав газар дээр үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад иргэд, малчид усны асуудал их ярьдаг. Худгуудыг уул уурхайн компаниуд эзэмшиж, хашдаг. Усан хангамжийг нутгийн иргэдтэй хамтарч зөв зохистой ашиглах хамгаалах хэрэгтэй. Уул уурхайн компаниуд дээр өгч байгаа санал зөвлөмж бол худаг гаргаж болно. Гол нь худгаа малчдад ашиглах боломжтой байлгах гэх санаа. Гадаргын ус ашиглаад уул уурхайн компаниуд орон нутагт эдийн засгийн өгөөж оруулж байгаа бол дургүйцэхгүй.

Дорноговигийн аялал жуулчлалын онцлог ямар вэ? Төсөл аялал жуулчлалын үйл ажиллагаа, компаниудад хэрхэн нөлөөлж болох вэ? Аймагт аялал жуулчлал хэр хөгжсөн бэ?

- Аялал жуулчлалын холбоо шинэчлэгдэж байгуулагдсан. Бидний барьж ажиллаж байгаа бодлого бол Дорноговь аймгийн хэмжээнд аялал жуулчлалын цэгүүд асар хол зайтай байдаг. Зайтай болохоор хуьийн хэвшил хөрөнгө оруулахад өндөр зардалтай учраас аялал жуулчлалыг хөгжүүлж чадахгүй одоог хүртэл явсан. Зам, цахилгаан очсоноороо тодорхой хэмжээнд хөрөнгө оруулалт хийх боломж гарч болох юм. Цахилгаан очсон газруудаа хөгжүүлэх, сувилал, кэмп зэрэг барьж болох юм байна гэж харж байна.

Аймаг болон Сайншанд сумд хэдэн иргэний нийгмийн байгууллага байдаг вэ?

- Өнгөрсөн жил Дорноговигийн ТББ-уудын чадамжийн үнэлгээ хийгдсэн. Би тэр мэдээллийг "Говийн хөх салхи" ТТБ-аас өгч болно. Ерөнхийдөө ТББ-ийн үйл ажиллагаа сул байна. Залуучуудад чиглэсэн иргэний оролцооны ТББ-ууд идэвхтэй ажиллаж байна. Байгаль орчны ТББ нь хааяа үйл ажиллагаа явуулж, ихэвчлэн нэг хүний эргэн тойронд төвлөрдөг, институцийн бүтэцгүй. Чадавхийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Энэ төслийг хэрэгжүүлэхэд ТББ-ууд ямар үүрэг гүйцэтгэх вэ?

- Аялал жуулчлалын салбарын эрх ашиг хөндөгдөх юм бол бид дуу хоолой болж ажиллана. Дэмжиж болохоор төсөл бол дэмжээд ажиллана. Ашиг сонирхлын гэдэг байр суурьтай.

Нэмэх зүйл байна уу?

- Говийн бүс дийлэнх нь уул уурхай дагасан эдийн засгийн загвар. Уул уурхайн компаниуд орон нутгийн иргэдтэй хамтарч ажиллах аргаа олохгүй байгаа. Орон нутгийг эдийн засаг талаас нь дэмжих. Ханган нийлүүлэлт, бүтээгдэхүүн үйлчилгээ тал дээр орон нутгийн иргэдийн бүтээгдэхүүн үйлчилгээг авах хэрэгтэй. Энэ тал дээр шүүмжлэлтэй ханддаг.

Аймаг дахь нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ хэр хөгжсөн бэ?

- Манай аймаг говийн бүс болон зүүн бүсийн аймгуудын хүний нөөцийг бэлтгэж байгаа томоохон Анагаах Ухааны сургуультай. Зэргэлдээ аймгууд хүний нөөцөө авдаг. Эмнэлэгийн үйлчилгээний хувьд төрөөс дэмжээд тоног төхөөрөмж сүүлийн 2-3 жилд сайжирсан. Гэхдээ суурь асуудлууд хэвээрээ. Ялангуяа устай холбоотой хүмүүсийн ходоод, гэдэсны өвчлөл байгаа.

Танай аймаг, сумд палеонтологийн бүртгэл байдаг уу?

- Бүртгэлийг төрийн байгууллагууд хийж байгаа. Биет бус өвийн судалгааг жил болгон музей, сургалт судалгааны төв, соёлын төв хамтарч хийдэг. Аялал жуулчлалын холбоо бол хийгдсэн судалгаа дээр суурилаад төлөвлөгөөгөө гаргадаг. Палеонтологийн судалгааны санхүүжилт хэцүү. Хийх ёстой хэдэ н газрын нөөц байна.

Төслийн мэдээллийг цаашид хэрхэн дамжуулах вэ?

- Иргэний нийгэм гэхээсээ илүү сүүлийн үед идэвхтэй нөлөө бүхий иргэдээр дамжуулж хүргэх нь богин охугацаандаа үр дүнтэй. Дунд болон урт хугацаандаа Иргэний нийгмийг бэхжүүлж мэдээлэл өгөх. Иргэний нийтийн багийн хурлаар дамжуулж мэдээлэл өгөх

ДАЛАЙШАНДЫН 1-Р БАГЫН ЗАСАГ ДАРГА МӨНХБАЯР	2025 оны 6-р сарын 23

Орон нутгийн захиргааны үндсэн бүтэц, үүрэг, үүрэг нь юу вэ?

- Төрийн анхан шатны нэгж бол баг. Төрийн бодлого шийдвэр, хэрэгжиж буй хууль тогтоомж, төрд ямар үйл ажиллагаа явж байна тэр болгоныг иргэдэд мэдээлэл өгч байдаг. Төр иргэний гүүр. Манай баг 1346 өрхтэй, 4000 гаруй хүн амтай. Төв дээр бүртгэлтэй хэр нь хөдөө малтай иргэд маань хөдөө малаа маллаад байж байдаг. Манай баг тогтмол долоо хоног бүрийн 3 дахь өдөр малчидтайгаа манай ажилчид холбогдож одоогийн байдлыг шалгадаг:
    - Малчдад тулгамдсан асуудал,
    - Мал төллөлт
    - Хорогдол гарсан эсэх
- Малчдын групп чаттай. Малчид бүгдээрээ интернэттэй болсон. Малчид руу чиглэсэн мэдээллүүдээ группээрээ дамжуулж хүргэдэг. Мэдээллийг хараагүй хүмүүс рүү залгаж хэлдэг.
- Баг 7 ажилтантай:
    - Багийн дарга
    - Бүртгэл олон нийттэй харилцах ажилтан /багийн статистик мэдээллийг хариуцдаг/.
    - Нийгмийн ажилтан /иргэдийн нийгмийн халамж хариуцсан ажилтан/,
    - 4 хэсгийн ахлагч /нэг хэсгийн ахлагч дунджаар 900 гаруй хүнтэй харьцдаг/

Танай захиргааны бүсийн гол суурингууд юу вэ?

- Төв болон баруун хойд хэсгийг эзэлдэг. Хойно засмал зам төмөр замаас орж ирж байгаа замын баруун тал гэдэг нь 1-р багийн нутаг дэвсгэр гэсэн үг. Ер нь бол манай баг том баг байж байгаад 1992 онд Үндсэн хууль батлагдсанаас хойш 1, 6-р баг /Хайрхан баг/ гэж хоёр хуваагдсан. Би бол 9 дэх жилдээ ажиллаж байна. Энэ багтаа 2016 оноос хойш ажиллаж байна. Бусад багтай харьцуулахад манай баг арай бага нутаг дэвсгэртэй. Хөдөөд бага нутаг дэвсгэртэй.

Хүн амын бүтцэд ямар томоохон өөрчлөлтүүд гарсан бэ?

- Шилжилт хөдөлгөөний 30 хувь нь хаягтаа амьдардаггүй иргэд байдаг. Учир нь хүн амын шилжилт хийсвэр болчихсон. Сургууль, цэцэрлэг орох болоход манай багийн нутаг дэвсгэр дээр 2-р сургууль байдаг, төв газар болохоор ч тэр үү хүмүүс хүүхдээ шилжүүлж байдаг. Ажилдаа ойрхон байх зэрэг

хөдөө орон нутаг, сумдаас шилжиж ирдэг. Хүүхдээ сургуульд өгөх гэж шилжиж ирээд 4, 5 сарын дараа гэрийнхэндээ хүүхдээ үлдээгээр өөрсдийнхөө ажилд явдаг. Үүнээс хийсвэр шилжилт бий болдог. Манайд бүртгэлтэй боловч багийн үйл ажиллагаанд оролцдоггүй.

Хүн амын нас, хүйсийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөн бэ? Эдгээр өөрчлөлт нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой юу?

- Нас хүйсийн бүтэц ер нь дундаж байна. Залуу хүмүүс бараг байдаггүй. Ихэнх нь дундаж насныхан. 45-аас дээш насныхан. Манай баг сардаа нэг удаа заавал иргэддээ зориулж өдөрлөг хийдэг. Иргэдийн ирц муудаж, нийгмийн идэвх суларсан. Сард нэг удаа мэдээллүүдийг цуглуулж байгаад нэг өдөр өгдөг. Төрийн байгууллагуудаас мэргэжилтэнгүүдийг урьж иргэдэд хэрэгтэй мэдээллүүдийг өгдөг. Тухайн сардаа хэрэгжиж буй хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийн талаар мэдээллээр хангагдаж явдаг.

Хүн амын тоо болон бүтцийн өөрчлөлт нь нийгмийн үйлчилгээ эсвэл байгалийн нөөц зэрэгт дарамт үүсгэсэн үү, эсвэл бууруулсан уу?

- Дарамт үүсэж байгаа. Жишээлбэл Сайхандулаан сумаас хүүхдээ сургуульд хүүхдээ өгөх гэзд хүрээд ирлээ. Тэр хүн хүүхдээ өөрийнхөө ах, дүү, хамаатан садан дээрээ үлдээчхээд амьдарч байгаа газар луугаа буцаад явчихна. Ийм хүмүүс багийн үйл ажиллагаа, уулзалтад оролцдоггүй. Орон нутгийн сонгуульд оролцдоггүй, нийгмийн идэвхгүй байдаг.

Орон нутгийн удирдлага хүн амын өөрчлөлтөд хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ?

- Тухайн хаягтаа 180 хоногоос дээш амьдарсан байвал нь автоматаар тэр хүнийг татаж авах талаар улсын бүртгэлийн хуульд байдаг. Тэрийг хэлэхээр иргэд “Миний хаана байх нь миний эрх. Би хаана ч амьдарч болно. Та нар битгий миний эрхийг зөрчөөд бай.” гэж хэлдэг учраас ямар ч арга байхгүй.

Ирэх 5 жилд ямар нэгэн томоохон бүтээн байгуулалт төлөвлөсөн үү (жишээ нь, уурхай, үйлдвэрийн парк, эрчим хүчний хангамж)?

- Багийнхаа нутаг дэвсгэр дээр гэр хороолол дундуур том засмал зам Далай хөтөл рүү холбоно гэзд дэмжигдэзд ирэх онд хийгдэхээр шийдэгдчихсэн байгаа. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бас нэлээн ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн байгаа. Манай баг дээр замын асуудал дээр иргэд их санал тавьж байгаа. Говь болохоор борооны асуудлыг ерөөсөө тоодоггүй. Зогсоолууд үерийн гаргалгаа байхгүй хийгддэг болохоор талбай усанд автах, үер болоход үерийн далан, шуудуу гэзд цогцоор нь шийдэж өгдөггүй. Энэ жил үерийн далантай цогцоор нь шийдсэн зам хийх гэзд төлөвлөж байгаа.

Таны аймаг, сумд палеонтологийн бүртгэл бий юу?

- Манай орон нутгийн музей рүү хандаарай. Сайн мэдэхгүй байна.

Төслийн хэрэгжилтийн явцад сонирхогчдын оролцоонд хамгийн тохиромжтой арга юу гэж бодож байна?

- Малчинтай тодорхой харилцаж, мэдээлэл байнга өгөх нь маш чухал. Тэд шууд төслийн талбайд эсвэл төслийн орчимд байдаг. Малчид яаж хүлээж авахыг мэдэхгүй.

Ялангуяа баг хөгжил, бүтээхтэй холбоотой хүмүүс нүүж ирж байна уу?

- Шилжиж ирэх нь цөөн, явах хүмүүс нь олон. Сүүлийн 4 жил Засаг даргын алба хашиж байна. Нийт 1900 орчим хүн амтай, 2021 онд 567 өрхтэй байснаас 2025 онд 550 өрх болж буурсан. Цаашид багасах хандлагатай байна.
- Хүн амын шилжилт хөдөлгөөний хувьд ирж буй хүн цөөхөн, багасаж байна. Явж буй хүн, нас барсан хүн хасагдаж байна. Түр оршин суугч байдаг боловч багт албан ёсоор бүртгүүлдэггүй.
- Түр оршин суугчддаас дурвал бүх аймгаас томилолтоор ирж цэргийн ангид ажиллаж хуваарилагдсан байранд амьдардаг. Одоогийн байдлаар цэргийн ангид 400 орчим ажилчид ажиллаж байгаагаас 300 нь шилжээгүй ажиллаж байна.
- Төмөр замаас 150 гаруй ажилтан байгаагаас 70-80 нь Зүүнбаянгийн харъяад ордог. Бусад нь Сайншанд, Ховд гэх зэрэг өөр газрын харъяад бүртгэлтэй байдаг.

Эрүүл мэнд, сургууль зэрэг олон нийтийн үйлчилгээний байгууллагуудын талаар юу хэлэх вэ?

- 2 цэцэрлэг, 1 эмнэлэг, 1 соёлын төв, 1 спорт төв, хот тохижилтын албатай.

Бүртгүүлээгүй хүмүүс эрүүл мэнд, боловсрол зэрэг үйлчилгээнд ачаалал учруулдаг уу?

- Ачаалал үүсгэдэг. Шилжиж бүртгээгүй хүний хүүхдийг авдаггүй байсан бол сургууль, цэцэрлэгт хүүхдийн эрхийг хангах үүднээс авдаг болсон. Эмнэлэг үндсэн оршин суугчаар санхүүжилт ирдэг тул их ачаалал ирдэг.

Үүнийг яаж зохицуулж байна?

- Эмнэлэгт ирж үзүүлэхгүй байгаа хүмүүсийн оронд ирж үзүүлдэг хүмүүсээ үзээд, шилжиж ирэх тухай шаардлага тавьж байна.
- Цэргийн анги, төмөр замынхан тус тусдаа дотроо эмнэлэгтэй тул наана нь зохицуулалт хийх боломжтой. Нарийн мэргэжил, эсвэл хүчин чадал хүрэхгүй нөхцөлд Зүүнбаянгийн эмнэлэг рүү явуулдаг.
- Төмөр замынхан нэг эмчийн орон тоо байдаг. Тэндээ төмөр замын ажилчдыг анхан шатны үзлэг хийдэг.
- Цэргийн ангийнхан бэртэж гэмтсэн хүмүүсийг үздэг тул аймаг эсвэл багийн эмнэлэг рүү явуулдаг.

Хотын засвар үйлчилгээ нь хог хаягдал эсвэл бусад асуудлаас үүдэлтэй дарамттай тулгардаг уу?

- Хог хаягдал ихтэй. Тохижилтын алба ажиллаж байгаа учраас хогонд дарагдаагүй. Гэхдээ нэгдсэн хогийн цэг ачааллаас хэтэрсэн.

- Зүүнбаянд Доншинг газрын тос боловсруулах үйлдвэр ажилладаг. Нийт 120 орчим ажилчин байгаагаас 110 нь Зүүнбаянгийн иргэд, бусад нь нарийн мэргэжил шаардлагатай Улаанбаатар хот, Сайншандаас авдаг. Хятад улсын 70 орчим иргэд мөн ажилладаг. Хятад ажилчид Доншинг албаны байранд байрладаг. Ойрхон дэлгүүр орохоор бол Монгол хүнтэй хамт хяналтад байдаг. Зүүнбаян баг жижиг газар нутагтай учир хаана, юу хийж явж байгаа талаар давхар цагдаа хянадаг тул зөрчил гардаггүй.

Архины хэрэглээний түвшин хэд вэ?

- Цэргийн газар, Доншинг гэх зэргээс эхлүүлээд их байдаг. Архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хажууд архи уух зэрэг асуудлууд түгээмэл, буурдаггүй. Бие даасан хамтарсан багтай. Уг хамтарсан багийн гишүүнээр оролцдог.
- Зүүнбаян багт архины гурван дэлгүүр үйл ажиллагаа явуулдаг. Дэлгүүрээ багасгавал архидалт буурах хүчин зүйл болж чадахгүй. Дөрвөн дэлгүүр байснаас нэг дэлгүүрийг хааж байсан. Чанарын ялгаа гараагүй.
- Архи худалдаалах цагийг хязгаарлавал шагийн архины худалдаа гардаг.
- Соён гэгээрүүлэх зүйлс хэрэгтэй. Гаднаас хүн урьж авчирч хор уршигийн талаар ярьж тайлбарлахад тухайн үед ойлгодог ч гэсэн жилдээ ганц хоёр цөөхөн ирдэг тул долоо хоногийн дараа буцаад хуучин хэвэндээ уусаж ордог.

Гадаад хүмүүс энд амьдарч байгаагаас болж гэрлэлт, салалт, ганц бие эхчүүдийн тохиолдол бий юу?

- Байдаг. Доншинг хятад ажилчидтай компанид мэргэжил, боловсролгүй хүмүүс туслах албан тушаалд ажилладаг. Тэд гэр бүлийн харилцаа үүсгэдэг. Хамт амьдрахгүй ч гэсэн хүүхэдтэй болоод, салсан тохиолдол гарна. Гэхдээ тэр хүмүүсийн асуудлыг чимээгүй дарчихдаг. Монгол нь ч гэсэн түр ирээд, гэр бүл зохиогоод, салах тохиолдол гардаг.

Биеэ үнэлэлт байдаг уу?

- Тийм тохиолдол гарч байгаагүй. Дам яриа гардаг боловч хянан шалгахад эзэн холбогдогчгүй, чимээгүй болдог.

Бэлгийн замын халдварт өвчин?

- Сайн мэдэгдээгүй.

Эрүүл мэндийн статистик болон төрсөн бүртгэл багх түвшинд цуглуулдаг уу?

- Тоог багийн эмнэлэг гаргаад аймаг руу өгдөг. Хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, нас баралт, төрөлтийн тоо зэрэг мэдээлэл өгдөг.

Хүн амын бүтэцт ямар томоохон өөрчлөлтүүд гарсан бэ?

- Голдуу залуучууд явдаг. Зүүнбаянд дундаж насныхан, настай хүмүүс, төрийн албанд олон жил тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид үлддэг.

- **Мал аж ахуйн өрхүүд ба мал аж ахуйн тоо:** 65 малчин өрхтэй. Энэ жил 18,000 мал тоолуулсан. 2024 онд зуднаас шалтгаалан малчдын тоо буурсан. Малчдын малын тоо ихсэх тусам маллагаа их шаарддаг тул малын тоо толгойг өсгөх сонирхолгүй байдаг. Мянгат малчин болсны дараа малын тоо толгой жил жилээр цөөрдөг. Дараа нь өөрийн хүүхдээ мянгат малчин болгохоор малаа хүүхдийн нэр дээр шилжүүлж мянгат малчин болгодог. Мянгат малчин болсноор малчид орон нутагтаа нэр хүндтэй болсон гэж үздэгтэй холбоотой гэж таамаглаж байна. Ойролцоогоор 18 мянгат малчин байдаг.

Орон нутгаас малгүй болсон өрхүүдийг малжуулсан, хоршоо байгуулж байгаа зэрэг талаар дурдаж байсан. Үүнд хамрагдсан өрх байгаа юу?

- Манай малчид Зүүнбаянгийн малчдаас нийлэхгүй ч гэсэн Улаанбадрах, өөр сумдын малчидтай хамт нийлж хоршоо байгуулж дэмжлэг авч байна.
- Манай нутгаар дайран өнгөрдөг Бадрах Энержи ХХК-аас жилд хоёр айл тус бүрд малжуулах төсөлд хамруулдаг. Нэг айлд 25 эм ямаа, 25 эр хонь, нийт 50 мал.
- Хөдөлмөр халамжаас жил нэг айлыг малжуулах төсөлд хамруулдаг.

Одоогийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлого, төлөвлөлт

- Баг бүрийн иргэдээс хэрэгжих ажлын санал авдаг. Үүнийг сумын засаг даргын мөрийн хөтөлбөрт орж хэрэгжиж явдаг. 100 хувь хэрэгждэггүй, 30-50 хувь нь хэрэгждэг.

Сонгогдсон төлөөлөгчид бий юу?

- Сайншанд сумын Иргэдийн хурлын төлөөлөгч гурван байдаг. Дорноговь аймагт хоёр төлөөлөгчтэй. Миний бие Сайншанд сумын гурван төлөөлөгчдийн нэг.
- Гурван төлөөлөгч нь иргэдээс санал аваад сумын Засаг даргад дамжуулж мөрийн хөтөлбөрт оруулдаг.

Ямар санал хамгийн их ирдэг вэ?

- Сайншанд – Зүүнбаян хүртэлх засмал автозамын асуудал их хөндөгддөг. 2024 онд 12 км зам яваад Зүүнбаянгийн наана нь дуусдаг. Төмөрзам – Зүүнбаян хооронд 4.8 км шороон замыг засмал зам болгох санал их ирдэг. Хатанбулаг чиглэлийн том машин Зүүнбаянгийн нутгаар дайрч өнгөрдөг. Хуурайшилт, тоосжилт ихтэй, хусчихсан зам байдаг.
- 1992 онд цэргийн хаалттай анги байж байхад том дэд бүтэцтэй байгуулагдаж байсан. Түүнээс хойш цэвэр, дулаан, бохирын шугамд засвар үйлчилгээ ороогүй. Үүнийг засах, солиулах санал гардаг. Төвлөрсөн дулаан хангамжаар хангагдсан байр, уурын зуухтай. Уурын зуух ажилладаг боловч шугам хоолойн засвар үйлчилгээ ордоггүй болохоор өвөлжихөд хүндрэлтэй байдаг. Үүнийг засуулах санал ирж байсан.
- Хуучин байшингуудын гадна пассад, дээврийн ажил засуулах санал ирдэг.

Хүн амын нас ба хүйсийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөн бэ? Эдгээр өөрчлөлтүүд шилжилттэй холбоотой юу?

- Хүн ам буурч байна.

Орон нутагт бий болж байгаа бүтээн байгуулалт, уул уурхай, эрчим хүчний асуудал байна. Цаашид юу нэмэгдэж хийгээсэй, гэж бодож байна вэ? Угуул иргэд байгаа боловч гаднаас их хүн ирж байна. Үүний давуу тал, сул тал юу вэ?

- Уугуул оршин суугчид байдаг ч олон гадаад хүмүүс ирж байна.
- **Давуу талууд:**
    - Нутгийн иргэдийг зохион байгуулахад харьцангүй амар байдаг.
    - Нутгийн иргэд байнга харилцаа холбоотой. Багийн дарга, нутгийн иргэд харилцан дэмжин тусалдаг.
- **Сул талууд:**
    - Гадны хүмүүс ихэвчлэн "гадны" сэтгэлгээгээр хандаж бага анхаарал тавьдаг.
    - Зарим нь хогийн сав ашигладаггүй, орон нутгийн ёс зүйг хүндэлдэггүй.
    - Багийн дарга тодорхой шаардлага тавихад шинэ хүмүүс эсэргүүцэх хандлагатай.
    - Гомдлыг холбогдох байгууллагуудад дамжуулдаг боловч багийн даргад хариуцлага ногдуулах эсвэл сахилгын арга хэмжээ авах хууль эрх зүйн үндэслэлгүй, эрх мэдэл хязгаарладмал байдаг.

Багийн засаг дарга байх 4 жилийн хугацаанд хийсэн гол амжилтууд:

- 2024 онд Зүүнбаянгийн төв дотор 1.6 км төв замыг Доншинг компанийн хөрөнгө оруулалтаар хийлгэсэн. 1.3 тэрбум төгрөг. Доншинг компани жилд 200-300 сая төгрөгөөр суманд ажил хийдэг.
- Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулалттай 250 сая төгрөгөөр төв талбайд ногоон зүлэг, тоглоомын талбай, дугуйн замтай, алхалтын замтай спорт талбай хийлгэсэн. Зун хүүхдүүд тэнд очиж тоглох дуртай байдаг. Анх тэрийг хийх гэж байхад цэцэрлэг дулааны асуудалтай байсан.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 19 гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлсэн.
- 790 гаруй сая төгрөгөөр сургуульд их засвар хийсэн. Зүүнбаян баг 1000 хүүхдийн багтаамжтай 12 жилийн сургууль, дотуур байртай. Дотуур байрны тоног төхөөрөмж, ор, дэвсгэрийг аймаг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинэчилсэн.

Танай аймаг, сумд палеонтологийн бүртгэл бий юу?

- Дуутын Овоо.
- Хуучин цэргийн ангийн үүр байсан учраас хонгио ихтэй. Хонгио малчдад таарах нь элбэг байдаг.

Төсөл болон хүн амын өөрчлөлттэй холбоотой орон нутгийн хүлээлт, санаа зовнил юу вэ?

- Иргэдэд төслийн талаар танилцуулж ойлголттой болгоод, холбогдох байгууллагад заавар зөвлөгөө өгч хамтарч ажиллах саналтай байна.
- Тухайлбал:
  - Агаарын шугамд ямар нэг байдлаар доголдсон, гэмтэл авсан бол яаралтай холбогдож арга хэмжээ авах боломжоор хангагдсан байх шаардлагатай.
  - Төслийн бүтээн байгуулалтын хугацаанд холбогдон гарах хог хаягдлыг шийдвэрлэсэн байх, зориулалтын газар хадгалж, хаях, устгах хэрэгтэй.
- Төмөр зам тавигдахад айлын өвөлжөө, ус хоёрын дундуур нь гарсан байсантай холбоотой малчид их дургүйцэж байсан. Мал нь төмөр замын гармаар гарч хэвшээгүйн малчид гарч чаддаггүй. Үүнтэй холбоотой олон гомдол гарч байсан.
- Цахилгаан дамжуулах агаарын шугамаас малчдад тогоор хангах боломжтой бол худаг, усыг тогоор хангуулах гэх хүлээлт байна.
- Салхи шорооноос цаг агаарын эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх. Дорноговь аймгийн утгаар салхи шуурга ихтэй байдаг.
- Зүүнбаянгийн төвөөс хойд тал руу Сайншанд тал руу иргэдэд газар олгосон боловч тэнд цахилгаанд холбогдоогүй газар тул хүмүүс суурьшдаггүй. Тус газар цахилгаантай болсноор айлууд олноор суурьшина.

Төрийн бус байгууллагууд байдаг уу?

- Малчид нийлж байгуулсан төрийн бус байгууллага байдаг. Бадрах Энержи компанийн үйл ажиллагааг эсэргүүцэж байгуулагдаж байсан. Өөр төрийн бус байгууллага байхгүй.

ХАЙРХАН 6-Р БАГИЙН ЗАСАГ ДАРГА Э.УРАНЧИМЭГ	2025 оны 6-р сарын 23

Сум орон нутгийн засаг захиргааны үндсэн бүтэц, үүрэг, үйл ажиллагаа юу вэ?

- Багийн засаг дарга хийгээд 8 жил болж байна. Сайншанд сумын 6-р багийн ажлын алба нь Аймгийн ИТХ-ын 2014.12.05-ны өдрийн 6/03 тоот тогтоолоор анх үүсгэн байгуулагдсан. 2015 оны 7-р сараас иргэдэд албан ёсоор төрийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Манай баг нь 2825.02 га нутаг дэвсэртэй. 2022 оны байдлаар 1045 өрх, 3483 хүн амтай байсан. Одоогоор 3500 орчим хүн амтай, 1100 өрхтэй.
- Баг нь бүтэц орон тооны хувьд Багийн Засаг дарга, Бүртгэл олон нийттэй харилцах ажилтан, Нийгмийн ажилтан, 4 хэсгийн ахлагч нийт 7 хүний хүний бүрэлдхүүнтэйгээр иргэн бүрт сэтгэл ханамжтай, чанарын менежмэнтийн тогтолцоог бүрдүүлсэн төрийн үйлчилгээг үзүүлхийг эрхэм зорилго болгон ажиллаж байна

Танай захиргааны бүсийн гол суурьшлын бүсүүд юу вэ?

- Шинэ суурьшлийн бүс тул шинэ хар зам, 6-р сургууль, нефтийн үйлдвэрийн орон сууц баригдаж байгаа.

Орон нутгийн өнөөгийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлого, богино, дунд хугацааны төлөвлөгөө, сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр?

- Багийн ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна:
  - ЗГ, ИТХ-ын бодлого шийдвэр, Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
  - Иргэдэд анхан шатны төрийн үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө мэдээлэл өгөх, иргэдийн оролцоог хангах
  - Байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх, уламжлах
  - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
  - Хувь хүн, гэр бүлд нийгмийн ажил үйлчилгээг үзүүлэх
  - Статистик тайлан мэдээ гаргах, хүн амын бүртгэл хөтлөх

Хүн амын бүтцэд ямар өөрчлөлтүүд гарсан бэ?

- Багийн хүн амын бүтэц: 48% эрэгтэй, 51% эмэгтэй, насны бүтэц өөрчлөгддөггүй, ахмад оршин суугчид цөөн, хүн амын ихэнх нь залуучууд буюу 18-аас доош насны 1,370 иргэн, 55-аас дээш насны 473 ахмад байна.

Хүн амын нас, хүйсийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөн бэ? Эдгээр өөрчлөлт нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой юу?

- Шижилт хөдөлгөөн байгаа. Тухайлбал: нас барсан, шилжиж ирэх, шилжиж явах. Шилжилт хөдөлгөөнөөр хүн амын огцом нэмэгдэхгүй. Жилд дунджаар 100 орчим хүн нэмэгддэг. Ажил анх эхлэхэд 2700-2800 хүн амтай байсан. Шилжиж ирсэн иргэд янз бүр байдаг.

Хүн амын тоо болон бүтцийн өөрчлөлт нь нийгмийн үйлчилгээ эсвэл байгалийн нөөц зэрэгт дарамт үүсгэсэн үү, эсвэл бууруулсан уу?

- Шилжилт хөдөлгөөнөөс дарамт үүсээгүй.

Ирэх 5 жилийн хугацаанд төлөвлөгдөж буй томоохон бүтээн байгуулалтууд байгаа юу (жишээлбэл: уурхай, аж үйлдвэрийн парк, эрчим хүчний хангамж гэх мэт)?

- Сонсож байсан, нарийн мэдээлэл байхгүй.

Танай аймаг, суманд палеонтологийн бүртгэл байдаг уу?

- Сайн мэдэхгүй.

Төслийн хэрэгжилтийн явцад оролцогч талуудыг оролцуулах хамгийн тохиромжтой ямар арга барил байна гэж та үзэж байна вэ?

- Айлбаян руу өндөр хүчдэлийн шугам барих явцад өрхүүдэд мэдэгдэх хуудас өгсөн. Айлбаяны өндөр хүчдэлийн шугамын барилгын ажил явагдах үеэр унага ухсан нүхэнд унасан тохиолдол гарч тухайн төсөл хэрэгжүүлэгч компаниас нөхөн төлбөр олгосон. Айлуудаар явж мэдээлэл өгөх, Айлбаянд өндөр хүчдэлийн шугам явахад малчид эсэргүүцээгүй.
- Сайн туршлага:
    - Барилгын ажилын явцад нүхийг хамгаалах
    - Аюулгүй байдлын мэдэгдэх хуудас тараах
    - Байгаль орчны нөлөө, аюултай эсэхийг тодруулах

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ	2025 оны 6-р сарын 23

Тэрээр төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүссэн. Авсан мэдээлэл дээр үндэслэн санал асуулгад хариу өгнө.

Улаанбадрах сумын ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл

УЛААНБАДРАХЫН СУМЫН ЗАСАГ ДАРГА Ц.ЭРХЭМБОЛД	2025 оны 6-р сарын 25

Урт хугацаанд говийн бүсийг хамарсан дугуй хэлбэртэй цахилгаанаар холбох Эрчим хүчний яамны урт хугацааны бодлого явж байгаа юм байна. Үүний нэг хэсэг нь манай төсөл юм. Танай сум бүгд эрчим хүчээр хангагдсан уу?

- Асуудал байдаг. Хөдөөгүүр өндөр хүчдэл байдаггүй, сэргээгдэх янз бүрийн эх үүсвэр ашигладаг. Голдуу нарны панель ашиглаж байна.

Өндөр хүчдэлийн шугамтай холбоотой ямар нэгэн эрсдэл байдаг уу?

- Шувуу үхэх тохиолдол гардаг.

Танай суманд палеонтологийн бүртгэл бий юу?

- Байх магадлал маш өндөр. Үнэгт уулаас зүүн тийш Ширээ гэж байдаг. Тэнд үндсэндээ үлэг гүрвэлийн яс их олдсон газар байсан.

Төслийн хүлээлт, болгоомжлол

- Энэ төсөл манай сумын хойд хязгаараар явж байна. Хойд хязгаарт айлууд их ховор. Баянгаас орж ирж байгаа хэсэгт айлууд байдаг. Улаанбадрах, Сайншанд, Сайхандулаан, Хөвсгөл дээр ч байгаа. Улсын ажил болсон хойно өндөр хүчтэл татахад болохгүй юм байхгүй. Аюулгүй байдлаа хангаж ажиллавал зүгээр байна.
- Бүтээн байгуулалт хийхэд тоос, шороо босно. Хамгийн гол нь тэр орчмын хамаарал бүсэд орсон айл өрхүүдэд мэдээлэл, ойлголт хүргэх хэрэгтэй. Хэрэв гомдол, санал ирвэл арга хэмжээ авахаас өөр аргагүй болно. Үүнээс сэргийлэх үүднээс айлуудтай харилцан ойлголцсон байх ёстой.

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН Ш.ГАНДОЛГОР	2025 оны 6-р сарын 25

Нийгмийн дэд бүтцийн хандалт

- Сүүлийн таван жилд томоохон өөрчлөлт гараагүй. Одоогоор хүн ам нь 1,475 байна.
- 0–18 насны 440 хүүхэд
- 15–35 насны олон залуучууд
- 270 ахмад настнууд
- 115 төрийн албан хаагч, үүнд цэргийн албан хаагчид багтсан

Шилжилтийн чиг хандлага

- Шилжилт байдаг.
- 10-20 хүүхэд 9-р ангиа төгсөж аймгийн төв рүү явдаг.
- Ихэнх нь мэргэжлээ сонгоод цааш суралцдаг. Буцаж ирэх тохиолдол цөөн.
- Жилдээ 2-3 хүн ирж ажилладаг. Энэ жил 5 төгсөгч ирж ажилд орж байна.

Хүний нөөцийн сорилтууд

- Хүний нөөц дутагдалтай байна.
- Хүний нөөц бүрдүүлэх үүднээс бодлого, урамшууллын журам хэрэгжүүлж байна. Бадрах Энержи компани сургалтын төлбөр төлсөн оюутнууд ирж ажилладаг.
- Гаднаас ирж байгаа дутагдалтай мэргэжил, боловсон хүчинд мөнгөн урамшуулал олгох журам хэрэгждэг. Цэцэрлэг, сургуулийн багш нар гаднаас ирж ажилладаг. 5 хүртэлх саяын мөнгөн урамшуулал, төрийн албан хаагчдын байраас олгодог (сарын түрээс 36,000 – 50,000 хүртэлх төгрөг).
- Сүүлийн жилд эмнэлэгт хоёр, цэцэрлэгт хоёр, сургуульд гурван багш, соёлын төвд нэг ажилтан ирж ажиллаж байна.

Боловсролын үйлчилгээ

- **Цэцэрлэг:**

  - 2–6 насны гурван бүлэгтэй нэг байгууламж
  - Багтаамж: 75 хүүхэд
  - Одоогоор 55–66 хүүхэд хамрагдсан.
  - Явуулын багш нарт алслагдмал малчдын хүүхдүүд хамарч орсон.
  - Нийт 115 хүүхэд хамрагдсан. (анги дүүргэлт 88 хувь, нийт хамралт 100 хувь)
  - Цэцэрлэгт 120 хүүхэд суралцдаг бөгөөд анги дүүргэлт 88 хувь байдаг. Танхимын хамралт 88 хувь, нийт хамралт 100 хувь байна. Яслийн бүлэг шаардлагатай.
  - Мэргэжлийн цэцэрлэгийн багш дутагдалтай байдаг.
- **Сургууль:**
  - 9 жилийн сургалттай 270 хүүхдийн багтаамжтай нэг ерөнхий боловсролын сургууль
  - Дотуур байр 60 хүүхдийн багтаамжтай, малчдын хүүхдүүд хамрагддаг.
  - Дотуур байр нь стандартад бүрэн нийцсэн, тохижилт сайтай
  - Сургуулийн төгсөлтийн чанар сайн.
  - 2 жил тутам зохион байгуулагддаг Алтанзул наадмаас “Ерөнхий боловсролын есөн жилийн сургууль”-аар шалгарсан.
  - Багш тэтгэвэрт гарч байгаа тул бага ангийн багш дутагдалтай байдаг.

Тээвэр ба дэд бүтэц

- Эрчим хүчний хүчин чадал муу, хязгаарлагдмал байдаг.
- Зах зээл муу байдаг тул үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшил цөөхөн байдаг.
- Захиргааны буудал байдаг. Хувийн ганц буудал байдаг.

Усны хангамж, бохир цэвэршүүлэх байгууламж

- Зөөврийн усыг унданд хэрэглэдэг. Хүнсэнд хэрэглэхэд тохиромжгүй.
- Ус, худаг, нойлын асуудал их тулгамддаг.
- Ундны усыг жил бүр шинжлүүлэхээр дээж явуулдаг.
- Ус нь заримдаа бужигнасан байдаг.
- Сургууль, цэцэрлэг, дотуур байр стандартын цооног руу ордог. Дотроо нойлтой.
- Бохир, цэвэр шугам холбогдоогүй. Халаалтын шугам холбогдсон байдаг.
- Эмнэлэг дотроо нойлгүй.
- Зориулалтын хогийн цэгтэй. Зориулалтын тээврийн машинаар зөөж булшилдаг.

Эрчим хүчний хангамж, найдвартай байдал

- Өмнө нь цахилгаан хангамж муу, олон залгуур хүчирдэггүй.
- Шинэчлэл хийж байгаа тул айлууд өвөл тень, зундаа сэнс залгадаг болсон.

Дэд бүтцийн байгууламжуудын хүчин чадал, үйлчилгээний чанарын өөрчлөлт

- Орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэх ажлуудыг эрэмбэлдэг.

- Саналаа цаасаар болон цахимаар авдаг.
- Багийн дарга нар хариуцаж ажилладаг тул иргэд идэвхитэй оролцдог.
- Сумын хэмжээнд хийгдэх ажлыг эрэмбийн дагуу хэрэгждэг.

Төслийн нийгмийн дэд бүтцийн хүлээлт, болгоомжлол

- Аюулгүй байдалд анхаарал хандуулах
- Аянга цахилгаан буухад эрсдэл бага, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх.
- Тоосжилт анхаарах.

ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН АЛТАНЧИМЭГ	2025 оны 6-р сарын 25

Тэрээр суманд 11 жил ажиллаж байна.

Ерөнхий байдал

- Бэлчээрийн талбайн даац хэтэрсэн, асуудал тулгарч байгаа ч энэ жил гайгүй.
- Ойрд болоогүй зун болж байна. 2025 оны хавар эрт ногоо гарсан. Бороо орохгүй бол хатах шинжтэй.
- Сүүлийн жилүүдэд бороо орохгүй байна.
- 2024 онд бороо хур их орсон нь ногоо ургахад их нөлөөтэй байна.

Малын тоо

- Малын тоо толгой 2022 онд 198,098 байснаас 2023 онд 144,800, 2024 онд 112,618 болж буурсан. Цаг агаарын байдлын нөхцөл байдлаас шалтгаалж байна.

Үүрэг:

- Хүнс, жижиг дунд, хоршоо
- Хүнсний дэлгүүр эрхэлдэг 5 аж ахуйн нэгж, 7 хүнсний мухлагтай.
- Нэг тамхины цэг шинээр нээгдсэн. Нэг ая тухтай дэлгүүр нээгдсэн.
- Нэг гэр ахуйн барааны дэлгүүртэй, цайны газар нэг байдаг томруулж нээгдэхээр бэлдэж байна.

Хоршоо

- Хоршоо 2017 онд байгуулагдаж байсан. Шинэ хорооны хөдөлгөөнөөр 2024 онд 10 хоршоо шинээр байгуулагдсан. Мал аж ахуй, мах, сүүний чиглэлээр үйл ажиллагаа голлон явуулдаг. Мал үржүүлгийн чиглэлээр байгуулагдсан хоршоод мөн байдаг. 2025 онд 6 хоршоо байгуулагдсан.
- Хоршоодын үйл ажиллагаа сайн явагддаггүй. Үйл ажиллагааг жигдрүүлэхээр Өвөрмонголын Шилийн хот руу 12 хоршооны 17 малчдыг туршлага судлуулааад ирсэн. Дундын хоршоо байгуулахаар мах, сүү, үржлийн чиглэлээр туршлага судалсан. Суманд ашиглах боломжтой тоног төхөөрөмж судалсан.
- Эхний ээлжинд мах, сүү, сүүн бүтээгдэхүүний чиглэлийн хоршоодыг идэвхжүүлэхээр хоршооны гишүүдтэй засаг дарга уулзалт хийсэн. Санхүүгийн бэрхшээл тулгамдаж байна.
- Нэг хоршоонд 50 хүртэлх сая төгрөгийн зээл олгоно. Банк санхүүжүүлэлтийн эх үүсвэр олгож байгаа тул шаардлага өндөр тавьдаг. Төрийн банк, Хаан банк зээл олгож байсан. Энэ жил Төрийн банк зээл олгохгүй байгаа. Хаан банк зээл олгодог боловч зээл авч байгаа нь цөөхөн.
- Үржлийн мал худалдаж авахыг Засгийн газраас 7 сарын 31 хүртэл түр зогсоосон. Малчид үржлийн мал авч өсгөж үржүүлэхээр зээл олгож байсныг зогссон.
- 2025 оны байдлаар шинээр 3 хоршоо байгуулагдаад нийт 18 хоршоо бүртгэлтэй байна.
- Хуучин хоршоод мах, арьс, түүхий эд боловсруулж зах зээлд зардаг. Голдуу хотын зах, төвүүдээр худалдаалдаг.
- Мах нядалгааны чиглэлээр нэг хоршоо байгуулагдсан. Мах нядалгааны цех байгуулах гэж байсан боловч зээл нь тоног төхөөрөмж авахад хүрэлцэхгүй, үр дүнгүй болсон.

Малчдын эрх ашиг, хүндрэл

- Бэлчээрийн хувьд ган, зуд болсон ч тухайн газартаа бие биеэ таньдаг болохоор газраа хуваж хэрэглэхэд асуудал харьцангүй бага асуудал. Усны асуудал их тулгамддаг.
- Жил бүрийн 8-р сарын эхний долоо хоногт бэлчээрийн мониторинг судалгаа хийдэг. Тус судалгааг Газар, Хөдөө аж ахуй, Цаг уур хамтарч хийгээд мэдээллийг газрын мэдээллийн нэгдсэн санд оруулаад, Цаг уураас албан бичиг ирдэг. Ган, зуданд нэрвэгдсэн газар нутаг, бэлчээр хэтрэлттэй байгаа эсэх талаар тусгасан байдаг.

Орон нутгийн хөгжилд нөлөө үзүүлж буй байгалийн нөөц

- Цахим сүлжээнд ураныг амьд амьтан байхын аргагүй гэх зэрэг мэдээлэл тархсан байдаг. Орон нутагт амьдарч байгаа хүмүүст сөрөг нөлөөлөл мэдэгддэггүй.
- Худаг усыг шинжлүүлэхээр явдаг боловч шинжилгээний хариуг авахад удаашралтай байдаг.
- Малчдын мал аж ахуйд цаг агаараас үүдэн хүндрэл гардаг. Тухайлбал ган, зуднаар малаа алдах, хур бороо муу байгаагаас малын бэлчээрт ургамал ургахгүй байх гэх мэт.
- Хэдэн жил дараалаад ган гачиг болоход ихэнх малаа зарсан айл байгаа.
- Цаг агаар муудаад хонь, ямаагаа бүгдийг нь зараад бод малтайгаа үлдэх айл ихэсссэн.

Хүлээлт, санаа зовнил

- Цахилгаан шугам суурилуулж байгаа тул эрсдэл бага гэж тооцогддог.
- Ойрхон айлуудад цахилгаан татаад өгвөл малчдад боломж, амьдрал дээшилнэ.
- Нөхөн сэргээлт хийхгүй бол уул уурхайтай адил болно. Газар ухаад байвал бэлчээрлэх боломжгүй, мал нүхэнд унаж үхэх эрсдэлтэй.

- Агаарын шугам татаж байгаа тул эрсдэл бага гэж үзэж байна.

ТӨСӨВ ТӨРИЙН САН АЛБАНЫ ДАРГА ЭНХЦЭЦЭГ	2025 оны 6-р сар



Улаанбадрах Сумын эдийн засгийн шинж чанарууд

- Уул уурхай манай орон нутгийн онцлог шинж болдог.
- **Идэвхтэй уул уурхайн компаниуд:**
  - *Бадрах Энержи* – нефьт
  - *Ариун хад* – уул уурхай
  - *Тээхийн шонхор* – уул уурхай

Орон нутагт төлөх татвар

- Газрын төлбөр: 80 сая төгрөг
- Хог хаягдлын хураамж: 2.88 сая төгрөг
- Усны төлбөр: 7–8 сая төгрөг (усны тоолуур)
- Орлогын татвар: цалингаас суутгасан татвар

Хөдөө аж ахуй

- Малын хөлийн татвар авдаг байсан. 2023, 2024 онд аваагүй. Цаг агаарын хүндрэл малчдад нөлөөлж байна гэж үзээд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тэглэсэн.
- 2025 онд дараах шалтгаанаар аваагүй:
  - 100 жилийн ой болж байгаатай холбоотой
  - Малчдаас хандив цуглуулж байгаа

Үндсэн эдийн засгийн салбар, бизнесийн талаар?

- Улаанбадрах суманд үйлдвэр байдаггүй. Дэлгүүр, жижиг аж ахуй үйл ажиллагаа явуулдаг. Дэлгүүрүүд орлогоо тайлагнаж 1 хувиар татвар төлдөг.

Орон нутгийн орлогын гол салбар:

- Бадрах Энержигийн газрын төлбөр, цалингаас суутгасан татвар дийлэнх хувийг эзэлдэг.

Сүүлийн арван жилд орон нутгийн эдийн засагт ямар гол өөрчлөлтүүд гарсан бэ?

- Сүүлийн 4 жилд ахицтай байна.
- Өмнө нь 4-5 саяын татварын орлого бүрдүүлдэг байсан.
- 2020 оноос хойш нэмэгдсээр 600 саяын орлого уул уурхайтай холбоотойгоор бүрдүүлж байна.

Орон нутгаас уурхайд ажилд орох тохиолдол бий юу?

- Бадрах Энержид 12 хүн ажиллаж байна. Малчдыг голдуу туслахаар авдаг.

Хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувь нь ажилгүй байна вэ?

- Ажилгүйдлийн түвшин 40 хувьд хүрсэн. Хөдөлмөрийн насны хүн байдаг.
- Ажилгүй хүмүүс ажиллах сонирхолтой байдаг. Сүүлийн 2-3 жилд Бадрах Энержи 40-50 хүн авдаг байсан. Одоо бол ажилчид цөөхөн, цөөн тооны хүн ажилд авсан. Үйл ажиллагаа нь өргөжвөл ажилд оруулах сонирхолтой.

Төслийн хүлээлт, болгоомжлол

- Орон нутаг, ойролцоо амьдардаг иргэдийг ажилд авах боломжтой эсэх
- Малчдын амьжиргаанд нөлөөлөх эсэх
- Төслийн нөлөөлөл бага гэж үзэж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА НАРМАНДАХ	2025 оны 6-р сарын 25

Тэрээр Улаанбадрах сумд шинээр ажиллаж эхэлсэн тул өмнөх жилүүдийн мэдээлэл өгөх боломжгүй мэдэгдэв.

Улаанбадрах сумын ерөнхий тойм

- 2025 он гарснаас хойш буюу эхний хагас жилд осол (том, жижиг) 7-8 тохиолдол бүртгэгдсэн.Үүнд:
    - хүүхэд унаж татах,
    - мотоциклын ослоос үүдсэн гэмтэл, бэртэл,
    - морь малаас унаж бэртэх зэрэг.
- 2025 онд нас баралтын нэг тохиолол бүртгэгдсэн.
- Улаанбадрах сумын өвчлөл өндөр биш.
- Архаг хууч өвчин, халдварт бус өвчин байдаг.
- Орон нутгийн иргэд эмнэлэгт ирж үзүүлэхээс дуудлага өгч үзүүлэхийг илүүд үздэгээс үүдэн дуудлага их ирдэг. Хүнд өвчлөлөөс дуудлага ирэх нь бага. Өдөрт 1-2 дуудлага байдаг.

Голлох өвчлөл:

- Зүрх судасны өвчлөл, даралт ихсэх өвчлөл их байгаа нь ажиглагддаг.
- Өвчлөл улирлын чанартай байдаг.
- Тоосжилтоос үүдэн харшлын өвчлөл нэмэгдэж байна.

Хүртээмж:

- Нутгийн иргэдэд хүртээмжтэй байдаг.
- Орон тооны хувьд дутагдалтай, эмч олддоггүй. Шалтгаан нь цалин муу, алс хол газар явж ажиллах сонирхолгүй байдаг.

Хүндрэл:

- Ирж үзүүлж байгаа хүмүүсийн харилцаа, хандлага хүндрэлтэй байдаг. Эмчийг хүндэлдэггүй. Эрүүл мэндийг өөрөө биш ганцхан эмч хариуцах ёстой гэж үздэг.
- Даатгалын санхүүжилт муу, хязгаар тогтоодог болсон. Гүйцэтгэлээр квот тогтоосон байдаг.
- Хүн хэвтүүлэхэд квот амархан дүүрчихсэн байдаг.

Ариун цэврийн байгууламж:

- Гадаа нойлтой. Ариутгал байнга хийдэг.
- Дотроо нойлыг хийлгэж байгаа.

Амьдралын хэв маягтай холбоотой эрүүл мэндийн чиг хандлага

- Тэжээл муу, дасгал хөдөлгөөн дутагдалтай холбоотой өвчнүүд нэмэгдэж байна.
- Хямд өртгөөр, их хэмжээний бараа авах сонирхолтой байдаг.
- Хүмүүсийн амьжиргааны чадвар муудсантай холбоотойгоор хямд үнэтэйг авахыг зорьдог. Хүнсний чанар алдагдсан.

Ундны ус:

- Усыг худагнаас авдаг.
- Давслагын хэмжээ их байдаг. Олон удаа дүүргэсэн сав суулга цайдаг.

Нүдний өвчлөл

- Нүдний хуурайшилт ихтэй.
- Зарим ахмад настан болор солиулсан.

Төрөлт

- Гэрийн төрөлт, сумын эмнэлэгт төрөлт гараагүй.
- Гарч болох эрсдлийг багасгах үүднээс аймгийн эмнэлэгт эхүүд амарждаг.
- Төрөөд ирсэн хүүхдийг хяналтад оруулдаг.

Бэлгийн замын халдварт өвчин

- 2025 онд тохиолдол бүртгэгдээгүй.

Зам тээврийн осол

- Засмал замгүй тул зам тээврийн осол бага.
- Засмал замтай сумуудад зам тээрийн осол их гардаг.
- Улаанбадрахад бүртгэгдэж буй голлох ослоос дурдвал: мориноос унах, мотоциклтой холбоотой осол байдаг. Хүнд гэмтэл бэртэлтэй осол бараг гардаггүй.

Төслийн хүлээлт, болгоомжлол

- Хүн их ирж ажиллах тохиолдолд хүнсний аюулгүй байдалд анхаарах
- Төслийн бүтээн байгуулалтыг дэмжиж байна.
- Тоосжилтод анхаарах.

УЛААНБАДРАХ СУМ СУМЫН ЦАГДАА ЭНХСАЙХАН	2025 оны 6-р сар



Нийтлэг гэмт хэргийн зөрчил

- Гэмт хэргийн түвшин бага; Энэ бүс тайван байна.
- Мал хулгайтай холбоотой 4 хэрэг гарсан. Малын хулгай тулгамдсан асуудал болдог.
- Хүн амины хэрэг бүртгэгдээгүй.
- 2025 онд 40-аас дээш насны эмэгтэй амиа хорлосон 2 тохиолдол бүртгэгдсэн. Хоёул гэрлэсэн, малчин гэр бүл байсан шалтгааныг сэтгэл зүйн гэмтэл гэж таамаглаж байна.
- Гэр бүлийн хүчирхийлэл байхгүй.

Архи хэрэглэх нь

- Архины хэрэглээ бага байдаг.
- Архины эмчилгээнд хамруулж байсан. Архины хамааралтай хүмүүс бага.

Биеэ үнэлэлт

- Байхгүй. Холбогдох хяналт шалгалт хийдэг.
- Замын-Үүдэд ажиглагдаж байсан.

Замын хөдөлгөөний зөрчил

- Зөрчил цөөн тохиолддог. Ихэнх нь мотоциклтой холбоотой.

Орон нутгийн цагдаагийн байгууллага, эрсдэл, гэмт хэрэг, эмх замбараагүй байдалтай хэрхэн тэмцдэг вэ? Ачаалал хэр байдаг вэ?

- Ачаалал бага. Сард 1-2 дуудлага ирдэг. Улаанбадрах тайван сумд тооцогддог. Дуудлага нь гэр бүлийн маргаан, согтуурсантай холбоотой байдаг.
- Хэв журмыг сайн баримталдаг. Архины хамаарлаас гаргах арга хэмжээ авсан.
- Орой, өдрийн цагаар машинтайгаа эргүүл хийдэг.

Цагдаад тулгарах бэрхшээл

- Хүндрэл бага байдаг.
- Замын-Үүд хөгжил сайтай, асуудал шийдэгдсэн байдаг.

Сургалтын хөтөлбөрүүд

- Засаг дарга нарын хамтарсан баг (цагдаа, багийн засаг дарга, гэр бүлийн хариуцсан мэргэжилтэн, хүүхэд хамгааллын мэргэжилтэн) хамтарч зөрчил, гэмт хэргээс сэргийлэх сургалт багийн иргэдэд ордог.
- Оролцогчид: Баг, сургуулийн багш, сурагчид, цэргийн анги зэрэг хамаардаг.
- Цагдаа, хэсгийн төлөөлөгч 1 цагийн сургалт сард 4-5 удаа ордог. Хамтарсан багаараа орох тохиолдол бий.

Хүүхдийн хамгаалалт

- Хяналт сайн тавьдаг. Зөрчил гарч байгаагүй. Сүүлийн 5 жилийн байдлыг сайн мэдэхгүй.

Төслийн хүлээлт, санаа зовнил

- Гадны бүтээн байгуулалтад иргэд эсэргүүцэх тохиолдол гарч байсан.
- Ирж ажиллах хүмүүсийн талаар мэдээлэлтэй байх бүртгэлд оруулах
- Эргэлт шалгалт хийх шаардлагатай.
- Хяналттай байх.

УЛААНБАДРАХ СУМ, АРГАЛАНТ БАГИЙН ЗАСАГ ДАРГА ОЮУНТУНГАЛАГ	2025 оны 6-р сарын 25

Тэрээр 5 дахь жилдээ ажиллаж байна.

Хүн амын бүтцэд ямар томоохон өөрчлөлтүүд гарсан бэ?

- Аргалант баг 113 өрхтэй, 286 хүн амтай.
- Залуус олонхыг эзэлдэг. 60 орчим хүн ам 0-18 насныхан эзэлдэг. Ахмад настан буюу 55-аас дээш насны иргэд 20 орчим хувийг эзэлдэг.

Мал аж ахуй

- Нийт иргэдийн 80-90 хувийг малчид эзэлдэг.
- Малын ашиг шимээр амьжиргаагаа залгуулж байна.
- Зуднаар их хэмжээгээр мал их хэмжээгээр алдсан. Үхэр, адууг салхи, шороон шуургатай үеэр урагш хил давуулж малаа алдсан тохиолдол гарсан.

Баг дэд бүтэц

- Баг төвд сургууль, цэцэрлэг байхгүй, багийн байр байдаг. Баг иргэдийн нийтийн хурлыг улирал тутамд багийн төвд хийдэг.
- Баг эмч нь сумын төвд байрдаг. Хөдөө айлуудаар тойрч үзлэг хийдэг.
- Хүүхдүүд сумын төвд ирж сургууль, цэцэрлэгт хамрагддаг. Сургуульд завсардсан хүүхэд байхгүй, хүртээмж сайн.

Эрчим хүчний хангамж

- Айлууд нарны панелаар цахилгаан эх үүсвэр ашигладаг.
- Цахилгаангүй өрх бараг байхгүй.

Соёлын өв ба палеонтологи

- Тахилгатай уул: Аргалант уул, Тахиатын уул (аймгийн тусгай хамгаалалттай газарт ордог)

- Хамрын хийдийн урд талаар байдаг. Тусгай хамгаалалттай газар: Хар заг, Шар заг.
- Аймаг, сумын хэмжээний тусгай хэрэгцээний газар байдаг.

Уул уурхайн үйл ажиллагаа

- **Бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй компани:**
  - *Бадрах Энержи* — уул уурхайн газрын ашиглалт хийж байна.
- Бадрах Энержигийн хийсэн нарийвчилсан үнэлгээнд тусгай хамгаалалтын газрын талаар орсон байдаг.
- Бадрах Энежигийн талбай: Дулаан-Уул, Зөөвч-Овоо.
- Бусад уул уурхайн компани:
  - Тээхийн шонхор
  - Эрэл
  - Арвин Хад
  - Уушийн говь

Төслүүдтэй холбоотой хүлээлт, санаа зовнил

- Багт ачаалал үүсэхгүй.
- Өндөр хүчдэл дайрч байгаа.
  - Ойр хавьд амьдардаг хүмүүс, багийн төв цахилгаан авах боломж байгаа эсэхийг мэдмээр байна.
- Багийн нийтийн хуралд ирж мэдээлэл өгөх шаардлагатай.

Мандах сумын ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл

МАНДАХ СУМ ХӨДӨӨ АЖ АХУЙН МЭРГЭЖИЛТЭН ЗОЛБАЯР	2025 оны 6-р сарын 26

Газар ашиглалт (Хөдөө аж ахуй, мал аж ахуй, холимог)?

- Сумын төвөөрөө газар тариалан эрхэлдэг.
- Өрхүүд өөрсдийн хэрэгцээг хангах зроилгоор хүлэмжиндээ тариалдаг.
- Манай сумын газар нутгийн 70 гаруй хувийг бэлчээрийн талбай эзэлдэг.

Газар өмчлөл, эзэмшлийн байдал ямар байдаг вэ? (Богино болон урт хугацааны түрээс, хамтын ашиглалт, хэрэглэгчийн нөхцөлд хамаарах аливаа татаас, хязгаарлалт байгаа эсэх?)

- Өвөлжөө хаваржааны зориулалтаар ашиглаж байгаа газрыг эзэмшилийн эрхээ сунгуулдаг. Хугацааг сунгахдаа багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж сунгадаг.
- Наян хамагны хөндий гэзэд 4-р баг, 1-р багийн заагийг отрын бүс нутаг болгох санал аймаг руу өгсөн. Уг санал 2024 оны 12 сараас яригдаж байгаа. Хариу нь ирээгүй.
- Манай суманд газрын асуудал хариуцсан ажилтан байхгүй. Газрын координатыг тодорхойлох хүнгүй болохоор хэцүү. Газрыг хүнс хөдөө аж ахуй газрын асуудал хариуцсан газар дангаараа хариуцаж ажиллана гэдэг хэцүү. Бэлчээрийн маргаан байхгүй.
- Өвлийн болон хаврын зуслангийн газар нь эзэмшлийн эрхээр өргөждөг. Өргөтгөлийн асуудлыг Баг хотын иргэдийн хуралд хэлэлцдэг.

Бэлчээрийн ашиглалт, эрхийн байдал

- Бэлчээрийн ашиглалт сайн. Сумын хойд хэсгээр хулан, цагаан зээр их явдаг гэзэд хүмүүс бэлчээр талхлаж байна гэзэд санал гомдол өгдөг.
- 2022 оноос хойш худаг нэмж гаргаагүй. Худаг дутагдалтай байгаа. Орон нутгийн хөгжлийн сангаар худаг гаргах боломжгүй байгаа юм шиг байгаа. Юу болохгүй байгааг нь сайн мэдэхгүй байна.

Одоогоор өөр ямар байгалийн нөөцүүдэд тулгуурлаж байна вэ?

- Нүүрс дээр тулгуурлаж байгаа.

Газар болон байгалийн нөөцийн чанарын өөрчлөлтүүд

- Байгалийн нөөцөө ашиглаж байгаа чанар муудаж байгаа. Хүмүүс тэр хавийн газар нутгийн утаа тортог, тоос шороо дийлдэхгүй байна, агаарын бохирдол их байна зэрэг уурхайн талаар гомдол их ирдэг.
- Уурхайн замын дагуу бэлчээр талхагдаж байна гээд хүмүүс гомдол хэлдэг.
- Нүүрсний үнэрээр хордсон малыг борлуулахад хүнсний аюулгүй байдал зөрчигдөж байна гэдэг гомдол ирдэг. Усны хүртээмж муу. Усны асуудлаас болж ах дүү нар хоорондоо муудах тохиолдол ч гардаг.
- Худгийг нэг хүнд хариуцуулж өгөхөөр зарим нэг олон малтай айлууд худгийн усаа шавхахгүй гээд түгжчихдэг, үүнээс болоод хоорондоо муудалцах асуудал гарч байсан.

Дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авч байна?

- Эдгээр асуудлыг шийдэж чадахгүй байна. Миний үүрэг мал аж ахуй, үйлдвэрлэлийн төлөвлөлт менежмент гэж явдаг. Хууль тогтоомжийн шийдвэр, гүйцэтгэл, бодлогын баримт бичгийг малчдад сурталчилж таниулах.
- Малчдад ямар нэгэн урамшуулал олгодог. 2022 оноос хойш урамшуулал олгохоо больсон. Энэ жилээс буцаад урамшуулал олгож эхлэх гэж байгаа гэсэн яриа байсан.

Төслийн газар ашиглалтын хүлээлт, санаа зовнил

- Манай сум цахилгааны хүчдэл муу. Эрчим хүчний хувьд сайжрах юм болов уу гэж харж байна.
- Бэлчээр талхлагдах, тогны асуудал гарах асуудалтай.
- Согтуугаараа жолоо барьж яваад шонгийн мод мөргөж тоггүй болдог тохиолдол гардаг.

МАНДАХ СУМ ТӨХӨМ 5 ДАХЬ БАГИЙН ЗАСАГ ДАРГА СУВДАНЦЭЦЭГ /СУМ ТӨВ БАГИЙН ЗАСАГ ДАРГА /	2025 оны 6-р сарын 26

Төслийн талаар ямар нэгэн мэдээлэл сонссон уу?

- Өнөөдөр Засаг даргын орлогч энэ тухай хэлсэн.

Орон нутгийн засаг захиргааны үндсэн бүтэц, үүрэг, үйл ажиллагаа ямар вэ?

- Багийн дарга хийгээд 5 жил болж байна. Засгийн газрын гол захиргааны нэгж нь баг юм. Бид иргэдэд үйлчилдэг бөгөөд үндэсний бодлого, шийдвэр, батлагдсан хууль болон засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд хүргэдэг.

Танай захиргааны бүсэд байрлах гол суурингууд юу вэ?

- Орон нутгийн өнөөгийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлого, богино, дунд хугацааны төлөвлөгөө, сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр.

Хүн амын бүтцэд ямар гол өөрчлөлтүүд гарсан бэ?

- 2021 онд 90 гаруй өрх, 212 өрхтэй байсан. Одоо 114 өрх, 272 хүнтэй. Үлдсэн 4 багийн сумын төв дээр амьдардаг 200 орчим өрх амьдардаг. 2023 онд төрөлт нэмэгдсэн. 114 өрхөөс хаяг дээрээ амьдардаггүй 10 гаран өрх байдаг. Сумын хэмжээнд 1580 хүн амтай болсон. Өмнөх жилүүдээс өссөн.

Хүн амын нас, хүйсийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөн бэ? Эдгээр өөрчлөлт нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой юу?

- Залуучууд ихэвчлэн шилжиж ирдэг, шилжиж явдаг. МАК анх ашиглалтанд орж байхад Мандах сумын харьяалалтай иргэдийг ажилд авдаг байсан. Энэтэй холбоотойгоор залуучууд шилжиж ирээд өрх болчихсон. МАК-ийн ажил зогссон үед шилжиж ирсэн залуучууд нутаг буцсан. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд дийлэнхийг эзэлж байна.

Хүн амын тоо болон бүтцийн өөрчлөлт нь нийгмийн үйлчилгээ эсвэл байгалийн нөөц зэрэгт дарамт үүсгэсэн үү, эсвэл бууруулсан уу?

- Амьдралын түвшин доогуур иргэдээ ажилд зуучлах гэхээр хаана байгаа нь мэдэгдэхгүй алга болдог. Айл айлд мал маллаад дамжаад явдаг 2, 3 хүн байна. Өвөрхангайд 1 багш, Сайншандад 1 хүн байна.

Хүн ам зүйн өөрчлөлтөд орон нутгийн удирдлага ямар арга хэмжээ авсан бэ?

- Шилжиж ирээд хаяг дээрээ амьдрахгүй хуучин хаяг дээрээ амьдарч байгаа иргэдтэй эргэж холбогдоод хаяг руу нь буцааж шилжүүлсэн.

Төсөлтэй холбоотой орон нутагт болон орон нутгийн хүн ам зүйн тал дээрх хүлээлт, болгоомжлол юу байна вэ?

- Агаарын шугам явахад тог булаацалдах асуудал үүсэх эсэхэд санаа зовж байна. Манай сум тогны асуудалтай. 220 ирэхээс 160 орчим ирдэг. Тог тасрах асуудал бага. Байгалийн үзэгдлээс шалтгаалан шон унах үед эсвэл засвар хийх шаардлагатай бол урьдчилж мэдээллэж тасалдаг. Бага хүчдэлтэй холбоотойгоор цахилгаан найдвартай биш байдаг. Цахилгаан тогоо ч зөв ажиллуулж чадахгүй байна.

Ирэх 5 жилийн хугацаанд төлөвлөгдөж буй томоохон бүтээн байгуулалтууд байгаа юу (жишээлбэл: уурхай, аж үйлдвэрийн парк, эрчим хүчний хангамж гэх мэт)?

- Энэ жил орон нутгийн хөгжлийн салбараар модон шонгуудыг цутгамал шонгоор сольж өгөх ёстой. Төмөр зам дагуу дэд станц барих талаар сонссон. Уул уурхайн компани соёлын цогцолбор барьж өгнө гэж хэлээд 2 жил болж байна. Цэвэр бохирын шугамтай холбох ажил эхэлчихсэн.

Танай суманд хичнээн уурхай байгаа вэ?

- Их түмэн хүрд- нүүрсний уурхай, Мандах нуур, Түмэн говь гэх мэт туслах компаниуд. Сум орон нутгаас ажилчид ав гэхээр нарийн мэргэжлийн ажиллах хүч шаарддаг. Манай багаас 12 хүн ажилладаг. Өвлийн улиралд Их түмэн хүрд, Түмэн айл гээд 2 уурхай хамтраад өрх бүрт 2 тонн нүүрс үнэгүй өгдөг.

Танай аймаг/суманд палеонтологийн бүртгэл байдаг уу?

- Сүг зурагтай хад, Сүүхэнтийн чулуужсан ой, Өлгий хийд

Төслийн хэрэгжилтийн явцад оролцогч талуудыг оролцуулах хамгийн тохиромжтой ямар арга барил байна гэж та үзэж байна вэ?

- Иргэдэд мэдээлэл зөвөөр өгөх ёстой. Цахилгаан дамжуулах шугам гайгүй тул иргэдийн эсэргүүцэл бага гэж үзэж байна. Эрэл хайгуул хийхгээд зэс гэх мэт зүйлс гаргавал иргэд шууд уул уурхай гэж хүлээж авах байх.

МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Б.БАТ-ЭРДЭНЭ	2025 оны 6-р сарын 25

Орон нутгийн засаг захиргааны бүтэц ба үүрэг

- Энэ төсөл манай мөрийн хөтөлбөрт орсон байдаг.
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт орсон.
- Сумын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт орчихсон учраас мэдээлэлтэй байна.
- Энэхүү төсөл нь орон нутгийн бодлогын хөтөлбөрт багтдаг бөгөөд дараах хэсэгт багтсан:

Танай сумын орон нутгийн засаг захиргааны үүрэг

- Төрийн үйлчилгээг иргэдэд хүрэх
- Засгийн газраас болон аймгаас хэрэгжүүлж байгаа бодлогыг сумынханд хэрэгжүүлэх
- Бодлого шийдвэрийг иргэдэд танилцуулах.

Засаг даргын тамгийн газрын бүтэц, хэлтэс

- Засаг даргын тамгын газар дараахаас бүрдэнэ:
    - Засаг дарга
    - Засаг даргын орлогч
    - Тамгын газрын дарга
    - Санхүүгийн алба
    - Хөдөө аж ахуйн тасаг
    - Мал аж ахуйн тасаг
    - Мал эмнэлэгийн тасаг
    - Нийгэм, бодлогын мэргэжилтэн
    - Багийн дарга - 5

Босоо удирдлагыг орон нутгаас томилдоггүй, улсаас томилдог. Үүнд:

- Газрын захиргаа
- Нийгмийн даатгал
- Улсын бүртгэл
- Нийгмийн халамж
- Орон нутгийн нийгмийн ажилтан

Бусад орон нутгийн гол байгууллагууд:

- Орон нутгийн захиргаа
- Эмнэлэг
- Цагдаа
- Хувийн мал эмнэлгийн үйлчилгээ
- Сургууль ба цэцэрлэгүүд
- Иргэдийн төлөөлөгчдийн хурал
- Соёлын төв

- Сум нь 5 багтай, нийт 1500 орчим хүнтай

Хүн амын бүтэц өөрчлөгдсөн үү?

- Сүүлийн жилүүдэд хүн амын бүтэцэд өөрчлөлт гараагүй.
- 1500 орчим хүн амтай, тоо өөрчлөгддөггүй.

Сургуулийн элсэлтийн чиг хандлага:

- Сурагчдын тоо буурсан
- Зарим хүмүүс Сайншандад орон сууц худалдаж аваад хүүхдээ авчирч суулгадаг боловч шилжүүллэгээ хийдэггүй.
- 2015 онд сургуулийн хүүхдийн тоо 240-250 байсан бол 2022 онд 210 орчим болж байсан.

Сумын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал

- Мал аж ахуйгаар голлодог.
- Нийт 510 гаруй өрхтэйгөөс 310 буюу 80 хувь орчим нь малтай эсвэл малчин өрх байдаг. Үлдсэн 15-20 хувь нь төрийн албан хаагч, ахмадууд байдаг.
- Уул уурхай эдийн засгийн хувьд хоёрт явдаг.
- Мандах суманд нүүрсний 5 уурхай байдаг.
    - Цагаан суварга – зэс, малидин
    - Их говь – 2015 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй нүүрсний уурхай, ковидын үед үйл ажиллагаа зогссон байсан боловч явуулж байгаа сурагтай.
- Уул уурхайд ажиллаж байгаа хүний тоо тогтворгүй байдаг. Тогтмол ажилладаг 50-60 хүн байдаг. Бусад нь түр ажлын байр тул орж гардаг. Уурхайн ажилчид 14/14-өөр ажилладаг.
- Төмөр замын 2 том тоочик – Номгон өртөө, Бор хошуу

Гаднаас хүн их ирж ажиллаж байгаа нөхцөлд сургууль, цэцэрлэг, эмнэлэгт их ачаалал их ирдэг үү?

- Сургууль, цэцэрлэгт ачаалал байхгүй.
- Гэмтэж бэртэх, дуудлага өгөх зэргээр эмчийн хамгийн их ачаалал ирдэг.

Уурхайн хөгжил орон нутагт хэр дэмтэй байна вэ?

- Сумын түвшинд уурхайн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд бий.
- Байгаль орчин талдаа хүмүүс их бухимдлалтай байдаг. Нүүрсний тоосжилт, үнэр зэрэг нь хамгийн их асуудал дагуулдаг.
- Иргэд нутгийн удирдлагад гомдол их ирдэг.
- Гэрээгээр бүтээн байгуулалт хийх үүрэг хүлээдэг боловч биелүүлдэггүй, ямар нэг шалтгаанаар бултдаг.
- Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор газар, усны төлбөр, цалингаас суутгасан хүн амын орлогын албан татварын орлогыг суманд төвлөрүүлдэг.
- Сум өөрөө санхүүжүүлдэг болсон. Сумаас төсөл санаачлахад хангалттай хэмжээний орлого олдог.
- Улсаас татаас авдаггүй, аймгийн улсын төсвийг санхүүжүүлдэг цөөхөн сумдын нэг.
- Жилийн 1.8 тэрбумын төсөв баталдаг.
- Шороо тоос суманд их асуудал дагуулдаг.
- Аймгийн засаг даргын захирамжаар ажлын хэсэг гараад уурхайг хаасан. Холын тээвэр гол асуудал дагуулдаг.
- Тусгай тээвэр батлах тухай Засаг даргын батламж ирдэг.
- Төмөр замаар уурхайн тээвэр явуулбал тоосжилт бага гэж үзэж байна. Нэг нүүрсний ам төмөр замаар нүүрсний тээврийг туршилт хийсэн. Асуудал гараагүй.
- Бусад уул уурхайг Засаг даргын захирамжаар зогсоосон.
- Зэсийн уурхай 2025 оны 12 сараас ашиглалтад орох төлөвлөгөөтэй. Үндэсний компани учраас кэмпд хяналттай байдаг. Сумын төвөөс 60 гаруй км зайд кэмп байрладаг.
- Тоос шороо их татуулдгаас осол их гардаг.

Эрчим хүчний хүчин чадал

- 2017 онд байнгын эрчим хүчний шугамд холбогдсон. Тухайн үеийн айлууд цахилгааны хэрэглээ бага байсантай холбоотой тохируулж цахилгаан өгсөн. Одоо бол айл өрхүүдийн цахилгааны хэрэглээ ихэссэнийг дагаад ачаалал ихээхэн нэмэгдсэн.
- Суманд дэд станц хоёр байдаг. Түүнийг нэмэгдүүлэхээр орон нутгийн хөгжлийн сангаар зураг хийлгэж байгаа.

Ирэх 5 жилийн хугацаанд төлөвлөгдөж буй томоохон бүтээн байгуулалтууд

- **110 МВт-ын цахилгаан станц:** 100 мВ-ын цахилгаан станц барихаар төлөвлөсөн. Түмэн Айл Энержи ХХК хувийн хөрөнгөөр барина. Аймаг, сумаас тус бүтээн байгууллалтыг дэмждэг. Үүнд Бор хошуу гэж нэрлэдэг төмөр замын хойд талд 100 га газар авсан. Малчдын хувьд бэлчээр тахлагдах болгоомжлол байна. Нүүрсний том ордыг түшиглэж барина. Уг цахилгаан станц нь говийн бүсийн цахилгаан эрчим хүч нийлүүлэх тухай суманд танилцуулсан.

- Шинэ сургууль, цэцэрлэг, эмнэлэг барихаар төлөвлөж байгаа боловч шийдэгдээгүй. Мандах сумын сургууль, цэцэрлэгийн барилга нь 1970-аад онд баригдсан хуучин барилга байдаг. Шинэ дотуур байр 2018 онд шинээр ашиглалтад орсон. Соёлын төв, сургууль, эмнэлэг гурвыг шинэчлэхээр төлөвлөсөн.
- Мандах суманд Гэрэлт говь аж үйлдвэрийн цогцолбор барихаар төлөвлөж байсан боловч Хөвсгөл суманд барихаар болсон.
- Цогтцэций Эрдэнэс таван толгой руу усны хоолой барих төсөл хэрэгжүүлэхээр суманд ирж мэдээлэл аваад явсан. Сум, удирдлагууд эсэргүүцэж байна. Захиалагч нь Эрдэнэс тавантолгой ТӨХК-ийн захиалгатай.
- **Палеонтологийн бүртгэл:** Мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай.

Төслийн хүрээнд олон нийтийн хүлээлт, санаа зовнил

- Хөгжлийн явцад янз бүрийн хэлбэрийн газар нутгийн саад тотгор үүсч болно.
- Бүтээн байгуулалт хийхэд янз бүрээр газар хөндөх, уул уурхайгаас болж бухимддаг болсон иргэд гомдол мэдүүлэх магадлалтай. Гэхдээ сум, багийн иргэдийн нийтийн хуралд ач холбодлын талаар мэдээлэл хүргэвэл эсэргүүцэл үзүүлэхгүй.

Төслийн хэрэгжилтийн явцад оролцогчдын оролцооны хамгийн сайн арга

- Багийн нийтийн хуралд мэдээлэл өгвөл хамгийн тохиромжтой. Уг хуралд иргэд бүгд цугладаг. 8-р сард зохион байгуулдаг.

МАНДАХ СУМ ТӨСӨВ БА САНГИЙН МЭРГЭЖИЛТЭН О.АГИЙМАА	2025 оны 6-р сарын 26

Танай сумын гол эдийн засгийн шинж чанарууд юу вэ?

- Уул уурхай, төмөр зам, мал аж ахуй.

Танай орон нутгийн гол эдийн засгийн салбарууд, бизнесүүд юу вэ?

- Эдийн засгийн гол салбарууд уул уурхай, төмөр зам, мал аж ахуй. Уул уурхайтай болсон болохоор малчид мах, цагаан идээгээ гэрээгээр борлуулж байгаа. Малчдад үр өгөөжтэй. Малчдын амьдрал дээшилсэн. Малчид ээлжээр уурхайд мах, цагаан идээгээ борлуулдаг. Яг нарийн тоо байхгүй. Манай суманд ингэний сүү, цагаан идээний ферм байгаа. 2024 онд ХХААХҮЯ-аас 91 сая төгрөгний санрүүжилт аваад үйл ажиллагаагаа явуулж байна. Ойролцоо сум болон дотуур байр, аж ахуй нэгжүүдэд сүү цагаан идээг борлуулж байна. Сумаас хойшаа 50-60 км-ын зайд байдаг. Сум болон зэргэлдээх сум /Өндөршил, Манлай, Ханбогд/-д ингэний сүү, ааруул, хоормог нийлүүлж байна. Манай сумын брэнд бүтээгдэхүүн ингэний хоормог. Суманд оёдол, ногоон тэжээл, блок үйлдвэрлэл, ингэний сүү, кофе шоп, хоолны газар, дэлгүүр эсгий урлал гэх мэт бизнес эрхлэгчид бий.

Сүүлийн арван жилд орон нутгийн эдийн засагт ямар томоохон өөрчлөлтүүд гарсан бэ?

- 2020 онд Түмэн айл гэдэг нүүрсний уурхай нээгдсэнээс хойш уурхай руу мал болон сүү цагаан идээгээ нийлүүлж малчдын орлогын түвшин дээшилсэн. Малчид үйлдвэрлэл үйлчилгээ явуулах сэтгэхүйтэй болсон.

Танай бүс нутагт эдийн засгийн салбаруудын ажлын байрны хуваарилалт ямар байдаг вэ?

- Хөдөлмөрийн насны иргэд дунджаар 750 орчим хүн байна. Уул уурхайд 60-70 хувь нь ажилладаг. Үлдсэн нь төр, хөдөө аж ахуйн салбарт ажилладаг.

Ажилтан насны хүн амын хэдэн хувь ажилгүй вэ?

- Ажилгүй иргэд цөөн. 2 хувь нь ажилгүй.

Орон нутагт ямар нэгэн томоохон эдийн засгийн хөгжлийн төсөл төлөвлөгдсөн үү?

- Засгийн газраас хэрэгжүүлж буй Шинэ хоршоо хөдөлгөөн. Тэрний дагуу малчид хамтдаа хоршоолж зээл авах. Одоогоор манай суманд Шинэ хоршоо хөдөлгөөнөөр 9 хоршоо байгуулагдсан. 3-4 хоршоо байгуулагдах гээд хүмүүс материалаа бүрдүүлээд явж байна. Мэдээ, судалгаа авахад хүмүүс малаа

авсан, хөлдөөгч авсан гэх мэтчилэн уул уурхайд махаа нийлүүлэх гэзэд бэлтгэл ажлаа хийж байна. Цагаан идээгээ хийж бэлдэж байна. Борлуулалтаа эхлэж явж байгаа.

Энэ төслийн орон нутгийн эдийн засаг болон ажлын байр бий болгох нөлөөтэй холбоотой таны хүлээлт, санаа зовнил юу вэ?

- Энэхүү төсөл нь дэд бүтцийг сайжруулахыг хүлээгдэж байна. Хэрэгжих эсэх нь тодорхойгүй ч, аймаг нь 1-р ба 4-р багуудын хооронд тэмээний ферм байгуулахаар төлөвлөж байна. Ажлын байр бий болгох, амьжиргаагаа сайжруулах боломжийг харж байна. Сөрөг тал илрээгүй.

МАНДАХ СУМ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА	2025 оны 6-р сарын 26

Тоосжилттой холбоотойгоор эсэргүүцдэг хүмүүс байгаа юу?

- Цэвэрсамбуу тоос шороо, орон нутгийн асуудалд дуу хоолойгоо хүргэдэг, иргэний нийгмийн байгууллагатай. Төсөл хэрэгжихэд асуудал гарахгүй гэж үзэж байна.

Уурхай нь мал амьтдыг алдаж, мал аж ахуй устгах эсвэл мал аж ахуйд сөрөг нөлөө үзүүлсэн үү?

- Нөлөөлөлд орсон айлууд олон байдаг. Уул уурхайн нөлөөлөлд орсон айлуудад сар бүр урамшуулал олгодог. Одоогоор уул уурхайгаас шалтгаалж малгүй болох, мал өвчлөх тохиолдол гараагүй.

Соёлын өв ба палеонтологи

- Хуучин шугамаа дагаж явж байгаа бол соёлын өв, палеонтологитой холбохдох зүйл гарахгүй гэж үзэж байна.

Танай суманд хэдэн үйлчилгээний байгууллага байдаг вэ? Хэдэн бизнес болон хувь хүн үйлдвэрлэлд оролцож байна вэ?

- Жижиг дунд үйлдвэр олон байдаг. Янз бүрийн шалтгаанаас үүдэн 3-4 нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг.
- Жижиг дунд үйлдвэр үйл ажиллагаа явуулахаар сум орон нутгаас янз бүрийн төсөл хөтөлбөрөөр явуулсан зээлийн төсөл 17-18 байдаг. Зарим нь үйл ажиллагаа эхлээгүй, эсвэл доголдсон нь илүү байдаг.
- 2024 онд засгийн газраас хэрэгжүүлсэн малын хоршооны зээлээс их хэмжээний мөнгө авсан. 10 хүн нийлж авсан зээлийг хуваагаад авчихдаг болохоор багийн ажиллагаа сул. Үүнээс үүдэн малчид малгүй болох сөрөг үр дүнд хүрнэ.

Цахилгаан эрчим хүчний хандалт, жижиг, дунд аж ахуйн аж ахуйн үйлдвэрлэлд үзүүлсэн нөлөө

- 2016 онд цахилгаан доголдолтой байх үед цахилгаанаас шалтгаалаад талхны цехийн үйл ажиллагаа зогсонги болсон. Үйл ажиллагаагаа сэргээж чадахгүй байна.

- Кофе шоп уг нь ажилладаг боловч тоног төхөөрөмжийг ажиллуулах цахилгаан хүчин чадал хүрэхгүй эвдэрчихсэн.
    - Мандах сум дахин дамжуулалтын эцсийн шугаманд байдаг.
    - МАК дээр ирсэн тогийг дахин дамжуулахаар тогны хүчин чадал ихээхэн буурч суманд хүрдэг.
- Айлууд руу шугамаар хуваахад хэт их тоотой өрхөд цахилгаан ачаалал их ирдэг.
- Хурганы арьс элддэг машин авчрахад дийлэх тог байхгүй байна.
- Эрчим хүчтэй холбоотойгоор үйлчилгээ, худалдаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжид асуудал их тулгамддаг. Иймд төсөл хэрэгжихэд төслийн хүлээлт их байна.

Төслийн хүлээлт, болгоомжлол

- Төслийн талаар мэдээлэл аваагүй.
- Мандах сум нь цахилгаан сүлжээнд холбогдоогүй хоёр сумын нэг байсан. Эрчим хүчтэй холбоотой төслийг нааштай дэмжиж байгаа. Ард иргэдэд мэдээлэл өгвөл эерэгээр хүлээж авна.
- Эерэг нөлөө: найдвартай тасралтгүй ажиллагаа явуулдаг эрчим хүчид холбогдоно. Одоогийн байдлаар Цагаан суваргаас дахин дамжуулалтаар цахилгаан ирж байна.
- Эрчим хүчний асуудалд эсэргүүцэх хүн байхгүй.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Э.ЧУЛУУНЦЭЦЭГ	2025 оны 6-р сарын 26

Тэрээр сумын эмнэлэгт 16 жил ажилласан.

Төрөх түвшин, нас баралт, амьдралын дундаж хугацаа, нүд, амьсгалын замын халдвар, ходоодны өвчин, сэтгэцийн өвчин, халдварт өвчин, бэлгийн замаар дамждаг өвчин, замын хөдөлгөөн болон бусад ослын үзүүлэлтүүд юу вэ?

- Сүүлийн 10 жилийн байдлаар нийт үзлэг өсөж байна. 10 жилийн өмнө давхацсан тоогоор жилд 2,000 үзлэг хийдэг байсан бол одоогийн байдлаар давхацсан тоогоор жилд 13,900 орчим үзлэг хийж байна. Түргэн тусламжийн дуудлага эхэн үед өндөр буюу 700 орчим дуудлага бүртгэгддэг байсан бол 2024 оны сүүлээр 400 гаруй дуудлага ирсэн.
- Нийт үзлэгээс өвчлөлийн байдлаар тэргүүлэх таван өвчлөл:
    - 1-т амьсгалын замын өвчлөл
    - 2-т хоол боловсруулах замын өвчлөл
    - 3-т зүрх судасны өвчлөл
    - 4-т осол гэмтэл
    - 5-т хорт хавдар.
- Жил бүр амьсгалын замын өвчлөл, хоол боловсруулах өвчлөл тэргүүлж байдаг. Сумын хэмжээнд амьсгалын замын өвчлөл тэргүүлж байна. Зүрх судасны өвчлөл 2-т ордог байсан бол 3-т ордог болсон. Хоол боловсруулах замын өвчлөл нэмэгдсэн.
- Эрт илрүүлэгийн үзлэг (ЭХО, дотор, ходоод дурангаар харуулах гэх зэрэг) нэмэгдсэнтэй холбоотойгоор өвчлөл бүртгэгдэж байна. 4-5 жилийн өмнө тийм үзлэг хийлгэх боломжгүй байсан.
- Осол гэмтэл, хорт хавдар сүүлийн 4-5 жилд нэмэгдсэн.
    - Осол гэмтэл нь машин, мотоциклтэй холбоотой,
    - Явганаас тодорхой шалтгаангүй уналт

- Түлэгдэх

- Үүнээс гадна эрүүл мэндийн салбарын бүртэлийн төрлийг шинэчилсэнтэй холбоотой. Сүүлийн үед осол гэмтэл болгоныг бүртгэдэг. Сүүлийн 4 жил уул уурхай нэмэгдсэнтэй холбоотой мөн нэмэгдэж байна. Ажлын байранд гэмтсэн, бөөнөөрөө автобус осолд орох зэрэг ачаалал их нэмдэг.
- Уурхайд хариуцсан эмч байдаггүй тул Мандах сумын эмнэлэгт их ирж үзүүлдэг. Сүүлийн 2 жилд нэлээд нэмэгдсэн. 2024 оны байдлаар 8900 үзлэгээс 1677 орчим нь гадны харьяатын хүн байсан. Даатгалаар санхүүждэг.
- Даатгал төлөөгүй ч гэсэн аль болох эмнэлгийн тусламж үзүүлдэг.

Эрүүл мэндийн үйлчилгээний бэрхшээл

- Хүн хүч их дутагддаг. Эмнэлэгт ганцаараа 10 гаруй жил болсон. Гурван сувилагч, нэг их эмч, туслах ажилчидтай.
- Нийт 4 багтай. Багийн эмч байдаг боловч эмч байхгүй.
- Ар гэрээ орхиод өдөр шөнөгүй ажилладаг, ачаалал өндөр.
- Хүний нөөц 60-70 хувийн дутагдалтай байдаг.
- Эмнэлгийн салбарын хариуцлага өндөр байдаг. Сумын эмч аймаг руу хүнд өвчтөн авч явсан хойгуур хэвлийн өвдөлттэй хүн ирж байсан. Тухайн хүн аймагт хүнд байдалтай очсон сураг гарсан. Эмч өөр өвчтөнг хариуцаад явж байх хооронд өөр өвчтөн ирэх магадлалтай байдаг.
- Өөр аймгийн сумдаас өвчтөн ирж их үзүүлдэг. Мандах сумын эмнэлэгт дотор ЭХО, оношлогоо, эмчилгээ сайн хийгддэг. Тэр талын тоног төхөөрөмжөөр сайн хангагдаж байна.

Даатгалаас өөр гадны хүмүүс гэнэтийн осолд ороод сумын эмнэлэгт эмчилгээ үзлэгт орсны дараа нэмэлт төлбөр авдаг уу?

- Осол нь гэнэтийн байдаг тул урьдчилан төлөвлөлт байдаггүй. Гаднаас олон хүн ирэхэд үзлэг тусламж үзүүлдэг.

Эрүүл мэндийн үйлчилгээ, байгууллагын хүртээмж

- 1933 онд анх сумын эмнэлэг нээгдэж, үүсгэн байгуулагсан. Эмнэлгийн барилга 1983 онд баригдсан. Дотор засвар 2019 онд, гадна засвар 2024 онд тус тус хийгдсэн тул тохижилт сайна. 2019 оны дотоод засвар сэтгэл ханахаар өөрчлөлт хийж чадаагүй.
- Сумын иргэд заавал аймаг, хот орж шинжилгээ өгөх шаардлагагүй, сумын эмнэлэгт үзүүлж оношлуулах боломжтой нөхцлөөр хангагдаж байна.
- Цэвэр, бохир ус холбуулахаар төлөвлөж байна.
- Уурын зуухаар халдаг.

Цахилгаан эрчим хүчний хүчин чадал ба дэд бүтэц

- 2010 онд ирж байхад лааны гэрэлд оёдол тавьж байсан. 2016 онд тогтой болсон.
- Түүнээс өмнө байнга моторoор, шаардлагатай бол бичиг цаас хийдэг. Харанхуй шөнө хэцүү.
- Сумын тог үе үе тасардаг. Цахилгаанаас үүдэн 3 жилийн өмнө олон тоног төхөөрөмж эвдэрсэн.
- Одоо эмнэлэгт тог баригч авсан тул тоног төхөөрөмж эвдрэх нь багассан.

- Хүчин чадал багатай, хуучин барилга (1983):
  - цахилгаан монтаж нь огт солигдоогүй.
  - 2019 онд дотор засал хийхэд цахилгаан утсыг ханан дотор суурилуулсан байдаг болохоор эвдэж гаргаад шинээр хийх боломжгүй.
- Хүн бүр тогны хэрэглээ эрэлттэй байна.
  - Өвчтөн утсаа залгах, ус буцалгах гэх мэт.
  - Тухайлбал хоёр ортой өрөөнд хаалганы хажууд ганц разеткатай.
  - Уртасгагч залгаад давхар эмчилгээний тоног төхөөрөмж, интернет, утас гэх мэт олон зүйл залгахад эрсдэлтэй байдаг.
- Одоо байгаа хүчин чадлын сайжруулах шаардлагатай.
- Сумын цахилгааны хүчин чадал маш бага байх. Суманд айл өрх нэмэгдээд хүмүүсийн цахилгаан хэрэглээ эрс нэмэгдсэн.

Хүн амын амьдралын нөхцөлд гарсан өөрчлөлт эрүүл мэндэд (ялангуяа ариун цэврийн, тэжээлийн дутагдал гэх мэт) нөлөөлж байна уу?

- Иргэдэд эрүүл зан үйл, дадал хэвшил байхгүй. Сургууль, цэцэрлэгт байхаас гараа угаа, шүдээ угаах зэргийг хэвшсэн байх ёстой байдаг ч хэвшээгүй хүмүүс байдаг.
- Говийн нөхцөлд усны эрүүл ахуйн асуудал түгээмэл. Хоол боловсруулах замын өвчлөл буурдаггүй, хорт хавдар их байгаа нь усны эрүүл ахуйтай холбоотой. Бүх төрлийн хавдрын өвчлөлийн тохиолдол байдаг.
  - Уушгины хорт хавдар
  - Зүрхний хорт хавдар
  - Ходоодны хорт хавдар
  - Нойр булчирхайн хорт хавдар
- Сүүлийн 3-4 жилд осол гэмтэл, хавдраар нас баралтын тоо нэмэгдсэн.

Усны ариун цэврийн үйлчилгээ ба Олон нийтийн эрүүл мэнд

- Усаа шинжлүүлье гэж ярьдаггүй.
- Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт аюулгүй байдлыг хангахтай холбоотой заалт орсон байдаг.
- Анх ажилд орж байхад усны аюулгүй байдлыг эмнэлэг хариуцна гэдэг байсан. Гэтэл эмнэлэг усны аюулгүй байдлыг хангаж чадахгүй. 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт усны эрүүл ахуйг эрүүл мэндийн байгууллага хариуцуулахаар оруулсан байсан. Эмнэлэг өвчтэй хүнийг үзэх төдий байдаг.
- Усны эрүүл ахуйн өөрийн хөтөлбөр хийгээд бодитой шинэчлэлт хийх шаардлагатай гэж үздэг.
- Усны асуудал их тулгамддаг. Ус хийсэн сав тунадас ихтэй болдог. Ус буцалгахад үйрсэн цагаан зүйл бужигнадаг. Түүнийг хэрэглэж буй иргэд бөөрний чулуужилт, элэгний шохойжилт зэрэг хүмүүсийн эд эрхтэнд шохойжилт их үүсдэг.

Амьсгалын замын өвчин

- Амьсгалын замын өвчлөл залуу насныханд буюу 0-18 насныханд хамгийн их элбэг тохиолддог.

- Дараах шалтгаантай:
    - эцэг эхийн хүүхдээ асран хамгаалах, нар салхинд гаргах, дулаан байлгах,
    - улиралд тааруулж хувцаслах зэрэг суурь биеийн дархлаа,
    - нэг том хүн өвдөхөд нэг гэр бүлийн хүмүүс бүгд өвчилдөг.

Малчинд нийтлэг тохиолддог өвчнүүд / малчингийн онцлог шинж чанар

- Малчдын түгээмэл өвчлөл:
    - Даралт ихсэх
    - Хоол боловсруулах замын өвчлөл элбэг байдаг.
    - Нүдний өвчлөл бага, хараа сайтай байдаг.

Ариун цэврийн байгууламж

- Эмнэлэгийн орчинд гадна, дотор нойлтой.
- Сүүлийн 4 жилд сумд айлуудад 100 модон нүхэн жорлон барих төсөл хэрэгжсэн. Айл өрхүүд өөрсдөө халдваргүйжүүлддэг.
- Хөрсний бохирдлоос сэргийлэхтэй холбоотойгоор эмнэлэг, мал эмнэлэг нарыг хариуцуулах гээд байдаг. Айлуудын нойлыг эмнэлгийн байгууллага халдваргүйжүүлэхгүй, айлууд өөрсдөө хариуцах ёстой. Шохойны төлбөр авж байсан.
- Сумын эмнэлгийн ажилтангууд айлын нойлыг халдваргүйжүүлэхээр зуу, зуугаар нь хуваж аваад хийдэг байсан.
- Нутгийн удирдлагын байгууллага дотроо нойлгүй, гадаа байдаг.
- Сүүлийн 4 жилд цэцэрлэг дотроо нойлтой, 2024 онд сургуульд 1-р ангийн хүүхэд дотроо нойл байдаг.
- 2022 онд сумын эмнэлэг уул уурхайн дэмжлэгтэйгээр дотроо нойлтой болсон. Дүүш, угаалгын үйл ажиллагааг дотроо хийх боломжтой. Усгүй үед ашиглах боломжгүй болдог. Дотор нойлыг гадны хүн ашигладаггүй, эмнэлэгийн өвчтөн, үйлчилгээ авч байгаа хүмүүс ашигладаг. Хэвтэж байгаа хүмүүс хавар, намар аль ч үед гадаа гарахгүй.

Сумын хүнсний аюулгүй байдал

- Сумын хэмжээнд хүнсний аюулгүй байдал хүндрэлтэй байдаг.
- Холоос хүнс, бараагаа авчирч байгаа боловч тээвэр, хадгалалтын горим хангасан эсэх нь баталгаагүй, эргэлзээтэй, стандартгүй. Тэндээс сумын иргэд авч хэрэглэдэг.
- Иймд дэлгүүрийн хүнсэнд хяналт байдаггүй. Савтай ундаа гадаа наранд өдөржин байж байдаг. Эсвэл өвлийн хүйтэнд гадаа эсвэл коридорт байрлуулдаг.
- Хоолны хордлого их гардаггүй. Хүмүүс ямар нэг хоол боловсруулах эрхтний өвчлөл хүндэрсэн болсон хойно эмнэлэгт их ирж үзүүлдэг.

Бэлгийн замын халдварт өвчин

- Суманд харьцангүй бага бүртгэгддэг. 18- 60 хүртэлх насныхан байдаг. Сүүлийн 1-2 жилд нэмэгдэх хандлагатай болсон. 10,000-д харьцуулахад маш бага тохиолдол бүртгэгддэг.
- Аймагт бэлгийн замын халдварт өвчлөл өндөр байдаг. Үүнд тавих хяналт сул байдаг. Өвдсний дараа эмнэлэгт ирж үзүүлсэн тохиолдлыг л бүртгэж авдаг. Давтамжтай урьдчилан сэргийлэх

үзлэг хийвэл олон тохиолдол бүртгэгдэх магадлалтай. Тэдгээр хүмүүс нь үзүүлчхээд алга болчихдог. Иймд эмнэлэгт өвчлөлийн тохиолдол бүртгэгдэх нь цөөн, ард иргэд урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдахгүй хүндрэлтэй байдаг. Үзлэгт хамрагдахын тулд даатгалаа бүрэн төлсөн байх шаардлагатай. Даатгалгүй хүнийг үзлэгт авахаар санхүүжилтгүй, эмнэлгийн байгууллага эрсдэлд ордог.

- Он гараад 500 гаруй шинжилгээ нутгийн иргэдэд хийсэн. Шинэ тохиолдол илрээгүй. Оношлох, илрүүлэх явц сул байдаг тул өвчлөл ил гарч ирдэггүй.

Төрөлт

- Жирэмсэн эхүүдийг хянадаг. Өндөр эрсдэлтэй нөхцөлд суманд төрүүлдэг. Жилд 5 төрөлт гардаг.
- Эмнэлэгт 5 төрөлт гардаг. Жилд 30 жирэмсэн эмэгтэй сумын эмнэлэгт хяналтад байдаг.
- Хожуу насны жирэмслэлт байдаг. Харин охидын буюу 20 нас хүртэлх насны эмэгтэйчүүдийн жирэмслэлт буурдаггүй. Ихэнх нь гэр бүлтэй болсон байдаг.
- Аймгийн хэмжээнд төрөлт багассан.

Хүчирхийлэл

- Ямаа самнадаг хүмүүс хүчирхийлэл их үйлддэг. Мандах сум мал олонтой. Айл бүр 1000 орчим малтай байдаг. Малаа өөрсдөө самнадаггүй. Машин дүүрэн самнаач залуучууд ирдэг. 4 жилийн өмнө бага насны хүчирхийлсэн хэрэг гарсан.

Осол ба нас баралт

- Осол гэмтлийн нас баралт нэмэгдээд 4 жилийн өмнө эмнэлгийн моргтой болсон.
- Жилд 20-д хүн нас барахад 3-4 нь ажлын байранд тог цахилгаанаар нас барсан хүн байдаг. Гэнэт зүрхний шигдээсээс нас барсан тохиолдол гарч байсан. Голдуу гадны хүмүүст гардаг тохиолддог. Тухайлбал:
    - ажлын байранд гарах осол,
    - зам тээврийн осол,
    - нүхэнд унах гэх мэт.
- Орон нутгаас хоёр цогцос хадгалах хөргүүр авсан.

Нийтийн усанд орох ба ажлын орчин

- Нийтийн халуун усны газар ажилладаг.
- Сумын орчин нөхцөл өөр байдаг тул эмчид 3 саяын цалин амласан ч удаагүй явчихдаг.
- Гэр бүлээрээ ажиллах нөхцөл, ажлын байр бүрдээгүй.

Шилжилт хөдөлгөөн

- Гадны харьяаллын хүн цөөхөн ирдэг. Суманд байх хугацаанд шижлүүллэг хийдэггүй. Хүний тоо багасахгүй байгаа нь дагаад хөгжих боломжтой.

Төсөлтэй холбоотой эрүүл мэнд,сайн сайхан байдлын тал дээрх хүлээлт, болгоомжлол:

- Холбогдох ажил хийхээр ирж байгаа ажилчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулсан байх, урьдчилан сэргийлэх үзлэгт багадаа хамруулсан шаардлагатай.
- Сумын эмчид ачаалал нэмэхгүйн үүднээс анхан шатны тусламж, үзлэг хийх эмчтэй болох. Анхан шатны эм тариа хийх нөхцлөөр хангах.

- Хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартыг мөрдөж ажиллах.
- Цахилгаан эх үүсвэр сайжирч байгаа бол: дагаад иргэн, хувь хүмүүсийн амьдрал ахуйд нэмэртэй болно.
    - Тог цахилгааны гэнэтийн тасалдал үүсэхгүй.
    - Цахилгаан хангамж сайн болбол иргэн, аж ахуйн нэгж дулааны асуудлыг цахилгаанаар шийдэх боломжтой болно.
- Үр ашиг ба зардал бууруулах
- Эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд гарах урсгал зардал багасана.
    - Тог тасрахаас сэргийлэх мотор худалдан авах давтамж багасана.
    - Эмнэлэг зардлаа илүү үр дүнтэй гаргах боломжтой болно.

МАНДАХ СУМ НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН НАРАНТУЯА	2025 оны 6-р сарын 26

Орон нутгийн нийгмийн чиглэлийн байгууллагын мэдээлэл, өөрчлөлт гарсан эсэх талаар?

- Сумын төвд төсвийн 5 байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Үүнд: Засаг даргын тамгийн газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төв. Нийт 90 албан хаагч ажиллаж байна.
- Аж ахуйн нэгж, дэлгүүр, хоршоо, худалдаа, үйлчилгээний 6-7 байгууллага үйл ажиллагаа явуулдаг.
- Цаг уур, хоёр банктай.

Танай суманд ямар боловсролын байгууллагууд байдаг вэ? Эдгээрийн хүртээмж хэр байна вэ?

- Цэцэрлэгт нийт 14-15 албан хаагч ажилладаг. 2-5 насны 60 хүүхэд суралцдаг. Цэцэрлэг нь 60 хүүхдийн багтаамжтай.
- Цэцэрлэгт орж чадаагүй хүүхэд байхгүй. Төрийн албан хаагчийн 1.5 настай хүүхдийг авдаг. Тогтмол 45-50 хүүхэд ирдэг. Хүртээмж хангалттай байдаг.
- Цэцэрлэгийн барилга нь одоогоос 4-5 жилийн өмнө буюу 2019 онд баригдаж байсан. 2025 онд халаагуурын доголдол, цууралтаас зэргийг одоо засахаар засварт орсон.
- Цэцэрлэгийн мэргэжлийн боловсон хүчин дутмаг байдаг. Мэргэжлийн нэг багш гаднаас ирж ажилладаг.
- Нийгмийн баталгаа хангах үүднээс урамшуулал яригдаж байгаа ч гэсэн сайн олгож чаддаггүй.
- Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууц эрүүл мэндийн төвийн хажууд байдаг. Тэнд мөн багш нарын байр байдаг. Сард цахилгааны төлбөр 40,000-50,000 төгрөг. Гаднаа нойлтой.
- Сургууль нийт 35 албан хаагчтай. 220 хүүхэд тогтмол суралцдаг. Сургууль 220-230 хүүхдийн багтаамжтай. 9 жилийн сургалттай. Төгсөөд аймаг руу явж сурдаг.

- Сургуулийн боловсон хүчин дутагдалтай байдаг. Чухал мэргэжлийн багш буюу англи хэлний багш, дуу хөгжмийн багш байхгүй олон жил болсон. Гаднаас багш ирдэг ч тогтвор суурьшилтай байдаггүй. Иймд хүүхдүүд шилжин суурьших сонирхол ихтэй.
- Эхнэр нь хүүхдээ аваад аймаг руу шилждэг. Заавал хүүхэдтэй хамт шилжих шаардлага тавьдаг. Нөхөр нь өрх толгойлсон эцэг болж үлддэг. Өрх толгойлсон эцэг эхийн тоо ихтэй байдаг. Тусдаа амьдарч байгаа боловч салаагүй гэр бүл.
- Дотуур байр 60 хүүхдийн багтаамжтай, 2 давхар. Дотуур байранд хавар хүүхдүүд орох сонирхолтой хүүхдүүд нэмэгддэг. Малчид отроор нүүдэллээд хүүхдээ дотуур байранд үлдээдэг. Ах дүү хоёрыг нэг оронд унтуулах зэргээр олон хүүхдийг шахаж оруулдаг.
- Өвөл, намрын улиралд багтаамж нь хүртээмжтэй байдаг.
- Дотуур байр дотроо нойлтой ч гэсэн гаднаа бие засдаг. Ус хангамж асуудалтай, хүрэлцээгүй байдаг.
- 2024 оны хавар аймгийн газраас хяналт үнэлгээ хийхээр ирсэн. Дотуур байрны агааржуулалт муу, хөнжил, гудас муу, матрасгүй, шинэчлэлт муу хийсэн.

Боловсрол болон сургалтын чиглэлээр тулгарч буй гол бэрхшээл

- Боловсон хүчин гол асуудал болж байна.
- Хүүхдүүдийн секц дугуйлан хомсдолтой байдаг.
- Мэргэжлийн багш, сургалтын төв байдаггүй. Хүүхэд хөгжүүлэх тал дээр дутагдалтай, ховор.
- Боловсрол, соёлын чиглэлээр ирж ажиллаж байгаа боловсон хүчнийг дэмжих орон нутгийн бодлого, баталгаа гаргах шаардлагатай гэж үзэж байна.

Орон нутгийн гол зам, тээврийн холбоосууд (хатуу хучилттай, шороон, сумын төвийн доторх, УБ хот, аймгийн төвтэй холбосон гэх мэт) юу байна вэ?

- Дэд бүтэц сайжруулах шаардлагатай. Аймаг руу 170 км шороон замаар явахад хүндрэлтэй байдаг. Хатуу, элс хайргатай зам байдаг. Явахад 5 цаг зарцуулдаг. Боловсон хүчин хэдхэн сар болсны дараа аймгийн алслагдсан сумд удаан байж чаддаггүй.
- 2024 онд Мандах сум хамгийн их осол аваарын тохиолдол гарсан сум болсон. Уурхайтай холбоотой осол их гардаг.
- Том машин явахыг хориглосон.
- Сумын төвд хатуу хучилттай зам тавих шаардлагатай байна. Уурхайгаас зам тавихаар хайрга асгасан байдаг боловч машины дугуй их хагардаг гомдол их ирдэг. Сумын тоос их болсон. Суманд хатуу хучилттай зам тавина гэж ярьдаг ч хийдэггүй. Иргэдээс их санал ирдэг.

Дотуур байранд байлгахгүйгээр малчид хөдөөнөөс сумын төв рүү сургуулийн хичээлд нь машинаар хүргэж өгдөг үү?

- Хөдөөнөөс сургуульд хүргэж өгдөг тохиолдол байдаггүй. Байранд орхих эсвэл таньдаг хүнд хүүхдээ үлдээдэг.

Танай суманд ундны усны хангамж, бохир ус цэвэршүүлэх байгууламж байдаг уу, Хэр хүчин чадалтай вэ?

- Бохир усны шугамын ажил хийгдэж байна. Салбар зөвлөлөөр бохир усны байгууламж бий болгохоор яригдаж байгаа боловч хэзээ, хэн барих нь тодорхойгүй.

- Хогоо төвлөрсөн хогийн цэгт хаядаг. Улирал тутамд шуугаад наана овоорсон хогийг татдаг. Уурхайн байгууллага тэнд мөн хог хаядаг.
- Ундны ус аймгийн хэмжээнд гайгүйд ордог. Сүүлд ухаалаг худагтай болсон. Картаа уншуулаад ус авдаг.
- Ухаалаг худаг руу гүний усаас машинаар зөөж дүүргэдэг.
- 2 худаг нь цэвэршүүлэгчтэй.
- Сумын галч худгийн усыг зөөдөг. Ганцаараа хогоо зөөх, аж ахуйн ажил хийх зэрэг тэр бүр байнга худгийн ус зөөж амждаггүй. Улиралд нэг удаа ариутгал хийдэг.

Эрчим хүчний хангамж, хүчин чадал, найдвартай байдал ямар вэ?

- Цагаан суваргаас эрчим хүчинд холбогдсон. Хүчин чадлын хүрэлцээ муу. Соёлын төвийн дэлгэцийн тал нь асдаггүй. Төвийн шугамд нэмж шугам тавихаар төлөвлөж байгаа сураг гарсан.
- 2015 онд тоггүй байсан. 2016 онд тогтой болсон.

Дэд бүтцийн байгууламжуудын хүчин чадал, үйлчилгээний, чанарт гарч буй өөрчлөлтүүдийг орон нутаг хэрхэн удирдаж байна вэ?

- **Дэд бүтцийн хүчин чадал ба орон нутгийн хяналт**
- Сүүлийн хэдэн жилд ахицтай дэвшил гарахгүй байгаа. Жишээ нь ангийн уулзалт сумын төвд болоход яг хэвээрээ байна гэж их яригддаг.
- Уул уурхайн хөгжил, төвлөрөл нэмэгдвэл үзвэр, үйлчилгээ, боловсон хүчин сайжирна гэж үзэж байна.

Хүнсний хангамж ба хүртээмжийн сорилтууд

- Сумын алслагдсан байрлалын улмаас хүнсний хангамж олон асуудалтай тулгардаг:
  - Тээвэрлэл, хадгалах нөхцөл ихэвчлэн алдагддаг.
  - Олон бараа муудсан эсвэл муудсан байдлаар ирдэг.
  - Өргөн хэрэглээний барааны үнэ өндөр байна.
  - Хэрэглээний барааны чанарыг идэвхтэй хянахгүй.

Аюулгүй байдал ба гэмт хэрэг

Олон нийтийн аюулгүй байдал ба гэмт хэргийн эрсдэл

- Уул уурхай нэмэгдсэнтэй холбоотойгоор аюулгүй байдал хангагдаагүй, эрсдэлтэй байдаг. Тухайлбал: цүнх үүрсэн хүн хадны цаанаас гэнэт гараад ирдэг.
- Суманд буудал цөөхөн, уурхайн зарим ажилчид яваагүй, замын унаанд суухаар үлдчихдэг.
- Мандах сум хад ихтэй тул дулааны улиралд зарим хүмүүс хонодог.
- Хүн алга болох тохиолдол их гарсан. Тухайлбал 11 настай Дорноговь аймгийн хүүхэд хүүхэд алга болоход 300 хүн дайчлагдаж хайгаад Мандах сумаас олж байсан.
- 11 настай охин амиа хорлосон тохиолдол гарсан.
- Сүүлийн үед хүүхдийн эрсдэл нэмэгдэж байна.
- Сумд камержуулалт тааруухан байдаг.
  - Гудамжны гэрэлтүүлэг нэмсэн боловч заримдаа ажилладаггүй.

- Гэмт хэрэг бүртгэгдснээс хойш 3 цэг дээр гэрэл, 6 ширхэг камер нэмсэн.
- Заримдаа камер шүүхээр ажилладаггүй. Тайлан мэдээнд камер нэмсэн тухай тусгасан байдаг ч ажиллагаа нь муу байдаг.
- Камержуулалт, гэрэлтүүлэг нэмэх шаардлагатай талаар санал иргэдээс их ирдэг.
- Бага насны хүүхдийн хүчирхийллийн тохиолдол их гардаг.
  - 2014 оноос хойш бага насны хүүхдийн бэлгийн хүчирхийлэл 3 тохиолдол гарсан.
  - Ямаа самнаач, туслах малчид хүчирхийлэл үйлдсэн тохиолдол 2 гарсан.
- Хүүхдийн эрсдэл өндөр байдаг.
- Нийгмийн баталгаа байдаггүй. Түр хамгаалах байргүй.
- Нийгмийн ажилтан байсан боловч тусгай үзүүлэх байр байхгүй, цалин бага учир ажиллах боломжгүй гээд удаагүй ажлаас гарсан. Иймд төрийн албан хаагчдыг дэмжих нийгмийн баталгааг сайжруулах шаардлагатай тулгардаг.

Ажлын үүрэг ба олон нийтийн оролцоо:

Ажлын хүрээ ба үүрэг чиглэл

- Дараах олон салбарт хариуцлага хүлээдэг:
  - Боловсрол
  - Эрүүл мэнд
  - Соёл ба урлаг
  - Спорт
  - Ахмад настнуудын асрах үйлчилгээ
  - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
  - Залуучууд
  - Жендер
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хариуцаад аймагт тэмцээнд ороод сумд ирсний маргааш гэр бүл, хүүхдийн чиглэлийн яаралтай тайлан бичих гэх зэрэг ачаалал их ирдэг.
- Ажлын ачаалал их байдаг тул ар гэрт тавих анхаарал сулардаг, стрэсс ихтэй болдог.
- Хүүхдүүддээ анхаарал тавьж чаддаггүй.
- Энэ жил нэг хүүхэд 9-р ангиа төгсөж байгаа тул дагаад аймаг руу шилжихээр бэлдэж байна.
- Халамжийн мэргэжилтэн байдаггүй тул давхар хариуцдаг. Бүх салбар зөвлөлийн нарийн бичиг хийдэг. Хүн ам цөөтэй боловч хийх салбар тус бүрийн ажил ихтэй.

Залуучуудын оролцооны бэрхшээл

- Залуучуудыг дэмжих ажил хомсдолтой байна. Сумын залуучуудын холбооны тэргүүнийг сонгож чадаагүй.
- Залуучуудын идэвх оролцоо сул болсон.
- Ямар нэг нөлөөллийн арга хэмжээ, лекц сургалт явуулахад залуучууд ирдэггүй.
- Нийгмийн оролцоо сул болсон.

- Настай хүмүүс идэвхтэй байдаг. Нэг ботгонд 20,000 төгрөгийн урамшуулал олгодог. Настай хүмүүс урамшуулалд хамрагдахын тулд идэвхитэй байдаг.

Нийгмийн дэд бүтцийн хувьд энэ төсөлд тавих таны хүлээлт, болгоомжлол

Дэд бүтцийн хүлээлтүүд

- Сумын дэд бүтэц сайжирна гэж үзэж байна. Үүнийг дагаад боловсон хүчин нэмэгдэнэ. Хүүхдийн аюулгүй байдалд анхаарах, аваар ослоос урьчилан сэргийлэх.

Нэмэлт нийгмийн болон байгаль орчны асуудлууд

- Сумаас зүүн хойшоо 30 гаруй км-т Үхэр чулуут гэх газарт хувь хүмүүс албан бусаар алт олборлосон хэрэг 2 жилийн өмнө гарч байсан.
- Аймгаас ажлын хэсэг ирж ажилласан. Тухайн хэргийг шийдвэрлээд нөхөн сэргээлт хийгээд үлдээсэн байсан.
- Тус газарт 2025 оны хавраас дахин хууль бус олборлолтын хэрэг гарсан тул сумын цагдаа, хэсгийн төлөөлөгч уг хэрэг дээр ажиллахаар явсан.
- Малын хулгайн хэрэг их гардаг. Ойр хавийн айлаар хайгаад олдохгүй бол орхидог.
- Тоос тоосонцор, агаарын бохирдол ихтэй. 2025 оноос нүүрс уурхайгаас авч түлдэг боловч хүхэр ихтэй байдаг.
- Муухай үнэр ихтэй. Угаартах тохиолдол цөөнгүй гарсан. Түүхий нүүрс түлэхэд эрсдэл, хор уршиг ихтэй байдаг.
- 2024 оноос өмнө Өмнөговиос сайжруулж угаасан Тавантолгойн нүүрс авч хэрэглэдэг байсан.
- Нүүрс угаах төв 100 км-т барих талаар яригдаж байгаа.

Ариун цэврийн болон хог хаягдлын менежментийн хэрэгцээ

- Хогийн төвлөрсөн цэг байхгүй, төвлөрсөн бие засах газар мөн байдаггүй. Уул уурхайн том автобус явдаг. Тэдгээр хүмүүс сумын төвд энд тэнд замбараагүй бие засдаг гэх иргэдийн гомдол их гардаг. Иймд төвлөрсөн бие засах газар, хог хаях төвлөрсөн цэг шаардлагатай.

Нийтийн аюулгүй байдал

- Уурхайн хүмүүс алга болох тохиолдол их гардаг.
- Сумын цагдаа ачаалал их үүрдэг, төлөөлөгч тогтдоггүй. Уурхайн ажилчид байнга алга болдог нь аюулгүй байдлын асуудал үүсгэдэг.

Сайхандулаан сумын ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл

САЙХАНДУЛААН СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ЭНХ-АМГАЛАН	2025 оны 6-р сарын 27

Танай орон нутгийн захиргааны үндсэн бүтэц, үүрэг, үүрэг юу вэ?

- Засаг Даргын тамгын газар 21 орон тоогоор батлагдсан. Иргэдийн төлөөлөгчдийн хурал бас хамт байдаг. Иргэдийн төлөөлөгчдийн хурал 3 орон тоо. Ингээд нийт 24 ажилтан нутгийн удирдлагын байгууллагад ажиллаж байна. Одоогоор 21 хүнээс 18 хүн ажиллаж байна. 3 орон тоо сул. Дэргэдэх байгууллагууд маань бүгд хангагдсан болохоор бусад сумдыг бодвол өндөр ирцтэй байдаг. Манай сум 1500 орчим иргэнтэй, 420 орчим өрхтэй. Суманд ажилгүй гэж бүртгэгдсэн иргэн байхгүй.

Танай засаг захиргааны бүсэд орших гол суурин газрууд юу вэ?

- Сумын төв дээр дунд сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байр (60 хүүхдийн багтаамжтай), соёлын төв, музей, номын сантай, ахмадын өргөөтэй. Сумын төв дээр 3 дэлгүүр, 1 зочид буудал байна.

Одоогийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлого, сүүлийн үеийн ямар төсөл хөтөлбөр байна?

- Өнгөрсөн 2 жилд малын тоо буурсан. Тэмээ өссөн. Бусад малын тоо буурсан. Сумын гол аж ахуй мал аж ахуй буюу дийлэнх өрх нь малчин. Зургаан өрх жил бүр 1 га талбайд тарвас, хүнсний ногоо тарьдаг. Хоёр нь сум төвд, дөрөв нь хөдөө орон нутагт байрладаг. Нэг хүн арьс боловсруулдаг, нөгөө нь ноос боловсруулдаг, зарим нь гэрийн оёдол хийдэг. Сүү цагаан идээгээ зарж борлуулалтаараа тэргүүлдэг. Манай сум аймагтаа тэмээгээрээ гуравт орно. Тэмээн аж ахуйн бодлого дээр төвлөрдөг. Манай сумын гол онцлог Тэмээн поло спорт. Тэмээчин, аварга спортын мастертай гэх зэрэг. Улсын 5 удаагийн аварга, хүрэл медал гэх мэт. Тэмээ өсгөх талаас нь тэмээнээс тоо толгойн татвар авдаггүй. Сайншандаас Сайхандулаан явах замд байдаг тэмээтэй холбоотой ингэн ферм байна. Хутагтийн говийн тэмээчин хоршоо 10 гаруй жил үйл ажиллагаа явуулж байна. Манай суманд хоршооны үйл явц удаан байгаа. Одоогоор 4 хоршоотой. 3 хоршоо нь зээл авсан. 3 хоршооны үндсэн чиглэл нь махны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тэмээ талаас хоршоодууд ажиллаж өгөхгүй байна. Уул уурхайн хувьд 24-25 хайгуул, ашиглалтын 6 лиценз байна. Ашиглалтын 6 лицензнээс цагаан чулууны чиглэлээр 1 нь маш бага хэмжээгээр үйл ажиллагаа явуулж байгаа. Цагаан чулуу олборлоод шууд Япон улс руу экспортоор гаргадаг. Олон шалгаанаас үүдээд үйл ажиллагаа тогтворгүй байна. Үлдсэн 5 лиценз нь үйл ажиллагаа явуулдаггүй нүүрсний уурхай. Ард иргэдийн эсэргүүцэл гайгүй. Манай сум алтны нөөц ихтэй. Явуулын нинжа нар олон. Сумын сургуульд 130 хүүхэд хамрагдаж байгаа боловч 250 хүүхдийн багтаамжтай. Сайншандын ойролцоо байрладаг өрхүүд төв рүү явж хүүхдээ сургадаг. Компьютерын сургалт, англи хэлний сургалтыг сумандаа хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүн амын тоо бүтцэд гарсан гол өөрчлөлтүүд?

- Сумын хүн ам залуучууд илүү давамгайлж байна. 20-39 насныхан хамгийн их, дараа нь 0-19 насныхан, хамгийн сүүлд нь ахмад настангууд. Хүйсийн харьцаа улсын дундаж үзүүлэлттэй адилхан. 20 жилийн өмнө залуучууд бага, ахмад настан их байсан.

Эдгээр өөрчлөлт нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой юу?

- Сайншандын 1-р баг болон 6-р баг руу 600 гаруй хүн шилжиж очсон байдаг. Хүүхдүүдээ сургахын тулд ээжүүд нь аймгийн төв рүү хаягаа шилжүүлээд хөдөө өрх толгойлсон аавууд үлддэг. Шилжиж ирж байгаа өрх тун ховор. Жилдээ 5-10 өрх шилжиж ирдэг. Хүн ам хэвэндээ байгаа. Иргэд Сайншанд-Сайхандулаан хоёрын хооронд явж байгаа.

Эдгээр өөрчлөлтүүд нийгмийн үйлчилгээ эсвэл байгалийн нөөцөд нөлөөлсөн үү?

- Нийгмийн үйлчилгээ үзүүлэхэд төвөгтэй байдлыг үүсгэж байгаа. Үйлчилгээ үзүүлэх гэвч очиход өрх гэрийн нэг гишүүнд л үзүүлэх боломжтой байдаг. Ийм өрхүүд аймагт ачаалал үүсгэдэг. Монгол улсын бодлого аймагт тохирохгүй байгаа. Зөвхөн Улаанбаатар хотод тохирсон.

Ирэх таван жилд томоохон хөгжүүлэлтийн төслүүд төлөвлөгдсөн үү?

- Дараа жил Хүүхэд хөгжлийн төв барихаар төлөвлөж байна. Хүүхэд хөгжлийн төвд дугуйлангууд хичээллэнэ. Төсөв нь орон нутгийн сан, аймгийн төсөв, улсын төсвөөс орж ирнэ. Хоёрдугаарт нь сумын нэгдсэн өвс тэжээлийн бонд. Гуравдугаарт нь сумын соёл спортын ордон.

Танай сумд палеонтологийн бүртгэл байдаг уу?

- Нарийн бүртгэл байхгүй. Би өөрөө археологич мэргэжилтэй. Тодорхой хэмжээнд булш, дурсгалуудыг бүртгэж авсан. Өмнөговь, Дорноговийг холбож байгаа төв зам дагуу 50 орчим булшийг илрүүлж зургаар баримтжуулсан. Палеонтологийн хүрээлэн үнэтэй байдаг тул Монгол улсын их сургуульд малтаж судлах, дадлага хэлбэрээр хийлгэх хүсэлт өгсөн. Суманд Монголын хад гэвч 4000-5000 орчим хадны зурагтай, 500мх800м орчим радиус дотор байдаг. Эрүүн хар, Их жавхлант гэвч газруудад эртний палеонтологийн дурсгалууд байгаа. Палеонтлогийн хүрээлэн жил болгон ирж судалдаг. Сумын хэмжээнд тахилгатай 5 овоо байна. Буурал овоо, Их өлзийт, Их дулаан, Бага дулаан, Баян овоо эдгээр 5 овоог жил болгон заавал тахидаг. 5 сарын 20-ноос 6 сарын 10-ны хооронд тахиж дуусдаг.

Төслийн хэрэгжилтийн явцад оролцогч талуудыг оролцуулах хамгийн тохиромжтой ямар арга барил байна гэж та үзэж байна вэ?

- Шугам сүлжээ баригдах үед түр ажлын байр гаргаж өгөх. (Туслах ажлын байрууд болон тогооч)

САЙХАНДУЛАН СУМ НИЙГМИЙН АСУУДЛЫН МЭРГЭЖИЛТЭН Б. АРИУНТУНГАЛАГ	2025 оны 6-р сарын 27

Тэрээр 2025 оны 5-р сарын 15-нд энэ албан тушаалд томилогдсон бөгөөд өмнө нь олон нийттэй харилцах албан тушаалтан байсан.

Танай сумд ямар боловсролын байгууллагууд байдаг вэ?

- Нэг сургууль, нэг цэцэрлэг бий. Цэцэрлэгт 70 хүүхэд багтаамжтай бөгөөд хоёр бүлэгтэй. Сургууль нь 130 сурагчийн багтаамжтай. Сургууль нь багш нарын гүйцэтгэлийн үнэлгээгээр өндөр үнэлгээ авдаг. Бүх сургуулийн багш нар мэргэшсэн бөгөөд ажлын байр бүрэн бүрэлдэхүүнтэй байдаг. Нэг цэцэрлэгийн багш мэргэшээгүй. Сургууль болон цэцэрлэгт хүрээлэн аль аль нь хяналтын камер суурилуулсан. Гэрийн цэцэрлэгүүд байхгүй. Цэцэрлэг зуны амралтаар хаагдсаны дараа хоньчдын таван настай хүүхдүүдийг хоёр долоо хоногийн турш ердийн цэцэрлэгийн хуваарийн дагуу сургаж байв.

Эдгээр байгууллагууд хэр хандах боломжтой вэ?

- Сургууль болон цэцэрлэгт багтаамж хэт их байх асуудал байхгүй.

Боловсрол, сургалтын гол сорилтууд юу вэ?

- Сургууль, дотуур байр, цэцэрлэг бүгд гадаа жорлонтой. Усыг автомашинаар байгууламж руу тээвэрлэдэг.

Танай бүс нутагт гол зам, тээврийн холбоо ямар байдаг вэ?

- Сумын төв Мандах сум руу чиглэсэн замууд болон нийслэл рүү хүргэх 33-р төмөр замын буудлын замтай холбогддог. 33-р төмөр замын буудал руу хүрэх зам нь 110 км шороон зам юм. Мөн хойд зүгт Бадрах, Зүүнбаян, Өндөршил руу чиглэсэн замууд бий.

Ундны усны хангамж болон бохир ус цэвэрлэх байгууламжийн байдал ямар байна вэ?

- Сум төвд авто худаг бий. Шүүлтүүрийг тогтмол сольдог ч ус буцалахад цагаан тунадас үүсгэдэг. Ихэнх өрхүүд энэ худагнаас ундны ус авдаг. Зарим гэр бүлүүд автохудагны усыг хэт хатуу гэж үзэж, 7 км-ийн зайтай худагнаас ус авдаг. Сум төвд дөрвөн худаг бий: хоёр нь ногооны талбайд, хоёр нь гэр ахуйн зориулалттай. Нэг нь гүн худаг (үнэгүй), нөгөө нь автомат худаг (картаар литр тутамд 5 MNT). Бохир ус цэвэрлэх байгууламж эсвэл нийтийн усан сангийн газар байхгүй. Хувийн хүмүүс улирлын усан онгоцны байр ажиллуулдаг. Ус худагнаас дамжуулдаг боловч гаралт бага.

Цахилгаан хангамж, хүчин чадал, найдвартай байдлын байдал ямар байна?

- Сум нь төв сүлжээнд холбогдсон. Гэсэн хэдий ч шуурганы үед цахилгаан тасардаг нь ихэвчлэн гардаг. Цахилгаан ихэвчлэн цагдаагийн цагтаа ирдэггүй бөгөөд 24 цаг хүртэл тасалж болно.

Төслийн хүрээнд нийгмийн дэд бүтцийн талаар таны хүлээлт, санаа зовнил юу вэ?

Үгүй.

САЙХАНДУЛААН СУМЫН ХЭСГИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ТӨГӨЛДӨР	2025 оны 6-р сар

Сүүлийн 3 жил Сайхандулаан сумд ажиллаж байна. Мандах сумд 2 жилийн хугацаанд хариуцаж ажиллаж байсан.

Гэмт хэрэг:

Сайхандулан сум

- Иргэдийн өмчийн хулгай их гардаг. Хөдөөд малын хулгай ихтэй.
- Орон байрны хулгай гардаг. Нүүдэл суудал хийгээд өвөлжөөгөөгөө үлдээгээд явдаг. Өөр газрын хүмүүс ирээд орон байранд хулгай хийдэг.
- Сайхандулаан суманд үндсэн уул уурхай байдаггүй болохоор иргэд олноороо цуглахад гарах гэмт хэрэг цөөн. Сумын төвд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг гарсан тохиолдол бий.
- Сайхандулаан суманд хүн амины гэмт хэрэг гарч байгаагүй.
- Амиа хорлолт 2025 онд нэг тохиолдол гарсан. 2023 онд 4 тохиолдол гарч байсан. 40-45 насны хүн байсан.
- Хүн амын тоо олон байх тусам архидалт ихэсдэг. Сайхандулаан сумын хувьд архидалт бага байдаг.
- Идэвхитэй уул уурхай, олон нийтээр зорчих тээвэрлэлт байхгүй. Голдуу иргэд хувийн ажлаар явдаг тул зам тээврийн осол багатай байдаг. Хөдөө орон нутагт мотоциклтэй зам тээврийн осол гардаг. Энэ нь голдуу согтуурсан, хариуцлагагүй байдалтай холбоотой осол байдаг.
- Гэр бүлийн хүчирхийлэл жил 2-3 тохиолдол гардаг. Голдуу архидан согтуурснаас шалтгаалдаг.

Мандах сум:

- Мандах суманд иргэд олноороо цугларсан, уул уурхайтай холбоотой хүний хөл хөдөлгөөн ихтэй газар хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг их гардаг.
- Мандах суманд уул уурхай баригдаад ажлын байр нэмэгдэхээр гэмт хэрэг үйлдэгдэх тохиолдол их гардаг.
- Мандах суманд хүн амины гэмт хэрэг гарч байсан.

Сүүлийн жилүүдийн өөрчлөлт:

- Сүүлийн 3 жил иргэний өмчийн хулгай ихсэж байна. Орон байр, өвөлжөө, хаваржаа, малын хулгай зэрэг.
- Гэмт хэргийн шалтгаан нь хүний зан чанар муудаж байна. Хуучин цагт юм хумаа орхиж явдаг байсан ч одоо бол цоож зүүгээд ч нэмэргүй болж байна.
- Орон нутгийн зам, Өндөршил рүү чиглэсэн төв зам дагуу ямаа самнаач буюу явуулын хүмүүс гэмт хэрэгт холбогдсон байдаг.
- Цагдаагийн газраас гэмт хэрэг илрүүлэх чиглэлээр тогтсон мөрдөн шалгах ажиллагаа байдаг. Гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө иргэдтэй уулзалт хийдэг.

Орон нутгийн цагдаагийн байгууллагад гарч байгаа хүндрэл, саад бэрхшээл:

- Бензин, машины тосыг тамгын газраас олгодог боловч албаны тээврийн хэрэгсэл байдаггүй. Иргэдийн машин, тамгын газрын машин ашиглах шаардлагатай тулгардаг. Үүнээс үүдэн мөрдөн шалгах ажиллагааны нууц алдагддаг.
- Тээврийн хэрэгсэлттэй болбол байн байн эргэлт хийх, уулзах боломжоор хангана. Иргэний дуудлагын мэдээлэлд цаг алдалгүй очих боломжтой болно.
- Иргэний машинаар явах гэхээр цагдаатай явахаас дургүйцдэг. Цаг хугацаа алдаж дараагийн асуудал үүсэх магадлал ихэсдэг.

Орон нутгийн цагдаа нар дутагдаж байна уу?

- Хэсгийн төлөөлөгчийг ерөнхий газраас томилдог. Хэсгийн цагдааг орон нутгийн байгууллага өөрсдөө дадлагажуулж авдаг. Цагдаагийн орон тоо дутмаг байх асуудал бага. Хэсгийн төлөөлөгчийн орон тоо дутмаг байдаг учраас ерөнхий газраас томилдог тул орон нутагт хамааралгүй.
- Хэсгийн төлөөлөгчийг томилсон бол тухайн газарт ажиллах үүрэг хүлээдэг.

Эрчим хүч:

- Сайхандулаан сум цахилгаан, эрчим хүчээ Сайншандаас авдаг. Сайншандад тог тасарвал адилхан тоггүй болох тохиолдол гардаг.

Төслийн болгоомжлол, хүлээлт:

- Төслийн шугам Сайхандулаан сумын төвөөс холуур явж байна.
- Хариуцаж ажиллах хүмүүсийн бүртгэл судалгаатай байх. Ямар нэг асуудал гарахад бүртгэл судалгааны мэдээлэлтэй байх. Сумын тамгын газарт ажиллах хүмүүсийн талаар мэдээлэл өгч хамтарч ажиллах нь зүйтэй.
- Өмнө нь ял шийтгэл эдэлж байсан талаар тодорхойлолттой байх.
- Багийн урд хэсгээр эзэнгүй айл ихтэй, орон байр, малын хулгай үйлдэгдэх магадлал ихсэх хандлагатай болно.
- Гэмт хэргээс сэргийлэх үүднээс хяналтад байлгах.

САЙХАНДУЛААН СУМЫН ЭМНЭЛГИЙН ДАРГА Ө.ӨЛЗИЙЖАРГАЛ	2025 оны 6-р сарын 27

Төрөлт, нас баралт, дундаж наслалт, нүд ба амьсгалын замын халдвар, ходоодны өвчлөл, сэтгэцийн өвчин, халдварт өвчин, бэлгийн замын халдварт өвчин, зам тээвэр болон бусад ослын үзүүлэлт ямар байна вэ?

- 2024 оны 8 сараас эхлээд томилогдоод 2 дах жилдээ ажиллаж байна. Манай сум хөдөө аж ахуйгаа түшиглэж байгаа сум гэж дүгнэж хэлье. Өвчлөл бөөр, нуруу, зүрх судас талаасаа илүү зонхил өвддөг. Улирлын чанартай намрын улиралд ханиад томуу, зундаа гэдэсний гүйлгэлт, суулгалт хордлого гэх мэт өвчлөлүүд байдаг. Зундаа гүйлгэлт, суулгалт нь хүмүүсийн өөрёдийн идэж байгаа хоол хүнснээс хамааралтай. Манай сум харьцангуй тайван зам тээврийн осол гэж бараг гарахгүй. Зам тээврийн осолтой холбоотой жилдээ 2-3 дуудлага бүртгэгддэг. 2024 оноос хойш халдварт өвчлөл салхин цэцэг 2 хүүхэд, гэдэсний суулгалт 1 хүүхэд, улаанбурхан бүртгэгдээгүй байна. Сэтгэцийн өвчин архины солиогоор 1 хүнийг эмчлээд дараагийн шатанд нь хүлээлгэж өгсөн. Бэлгийн замын халдварт өвчлөлөөр ихэвчлэн залуучууд халдваэр авдаг. (Тэмбүү, заг хүйтэн гэх мэт) Энэ үзүүлэлт зөвхөн байгууллагууд дундаас авч байгаа шинжилгээний үр дүн. Бусад энгийн иргэдээс авахад хүндрэлтэй. Малчид дунд харьцангуй гайгүй. Нас баралт харьцангуй гайгүй. Амиа хорлолт энэ жил 1 бүртгэгдсэн. Эмнэлгийн нас баралт байхгүй. Амьсгалын замын халдварт өвчлөл астматай 10 хүн байгаа. Манай эмнэлгийн хяналтанд байдаг. Сумын хэмжээний дундаж наслалт 65-70 нас. Зам тээврийн осол улиралдаа 1 удаа бүртгэгддэг.

Эрүүл мэндийн үйлчилгээ, байгууллагын хүртээмж ямар байна вэ?

- Манай эмнэлэг 3 их эмчтэй, 4 сувилагчтай. Байгууллагын хувьд бүтэц, орон тооны хувьд дутмаг байдаг. 24.5-аар жилийн эхэнд бүтэц орон тоогоо батлуулсан. Одоо нийт 16 ажилчин ажиллаж байна. Үүнээс 3 нь гэрээт ажилтан. Манайх төвийн шугамд холбогдоогүй болохоор нам даралтын зуухтай галлагаагаа хийдэг. Манай улирлын чанартай 10 сараас 5 сар хүртэл ажиллаад чөлөө авдаг. Туслан гүйцэтгэх вакцинатар дан вакцинатараар орж ирэхгүй 0.5-аар батлагдаад бүргэх боломжтой. 2 их эмч, 2 сувилагч, эм зүйч, лаборант, баг дээр 1 эмч, эмчлэгч эмч дутуу. Орон тоо дутуу болохоор бүгдээрээ ажил хавсарч ажилладаг.

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд ямар гол бэрхшээл тулгарч байна вэ?

- Манай эмнэлэг лабораторийн тоног төхөөрөмж байхгүйгээс шалтгаалаад 2-р шатлалдаа давхар ачаалал өгч явдаг. Зарим нэг онош тавихын тулд шинжилгээний хариу хэрэгтэй байдаг. Тэр шинжилгээг энд авах боломжгүй бол аймаг явж шинжилгээгээ авчраад, шинжилгээ дээрээс нь эмч нар дүгнэлтээ бичдэг. Дотрын эмгэгүүд шинжилгээний хариутай холбоотой байдаг.

Хүн амын амьдралын нөхцөлд гарч буй өөрчлөлт эрүүл мэндэд (тусгайлан ариун цэвэр, хоол тэжээлийн дутагдал гэх мэт) нөлөөлж байна уу?

- Нийгмийн давхаргаас хамаарч байгаа зүйл харьцангуй гайгүй. Тоотой хэдэн хүн байгаа. Эхийн эндэгдэл, нярайн эндэгдэл сүүлийн 2 жилд бүртгэгдээгүй. Жингийн дутагдалтай хүүхэд байхгүй. Жилд дунджаар төрөлт 10 бүртгэгддэг.

Төсөлтэй холбоотой эрүүл мэнд, сайн сайхан байдлын тал дээрх хүлээлт, болгоомжлол юу байна вэ?

- Болгоомжлол байхгүй. Тухайн байгууллага хариуцлагатай байвал болно.

САЙХАНДУЛААН СУМЫН ТӨСӨВ ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТЭН ЛХАМСҮРЭН	2025 оны 6-р сарын 27

- Нийтдээ 18 жил ажил эрхэлж байна. Энэ сумын иргэн. Өмнө нь нягтлан байсан. 2015 оноос хойш төсөв төрийн сангийн мэргэжилтэн хийж байна.

Танай сумын эдийн засгийн шинж чанарууд юу вэ? Орон нутгийн эдийн засгийн гол салбар, бизнесүүд юу вэ?

- Мал аж ахуй гол хөгжил болно. Сумад ашиглалтын лицензтэй уул уурхай гэх мэт байдаг ч үйл ажиллагаа явуулж байгаа уурхай байхгүй. Өөрөөр голлоод хөгжсөн бизнесийн салбар байхгүй.

Сүүлийн арван жилд орон нутаг\сумын эдийн засагт гарсан гол өөрчлөлтүүд юу байсан бэ?

- Орон нутгийн хөгжлийн сан бий болсноос хойш барилга байгууламжууд баригдсан. Тухайлбал, ёслол хүндэтгэлийн өргөө, багийн төвүүд баригдсан. Орон нутгийн хөгжлийн сан нь хүн ам багатай гэдгээр хуваарилалт бага байдаг. Манай суманд жилд 500 сая төгрөгт багтааж бүтээн байгуулалт хийх ёстой. Дорноговь аймгийн хэмжээнд хамгийн бага хүн амтай сум. Хөрөнгө оруулалт нь хүн амын тооноос хамаардаг.

Орон нутгийн эдийн засгийн салбаруудад ажил эрхэлж буй хүмүүсийн харьцаа ямар байна вэ?

- Голчлон мал аж ахуй, малчид байдаг. Сумын төвд төрийн албан хаагчид болон жижиг дэлгүүр байдаг. Сумын харъяатай хэрнээ өөр газар ажиллаж байгаа хүмүүс олон байдаг тэднийг бид бүртгэж чадахгүй.

Хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувь нь ажилгүй байна вэ?

- Ажилгүйдэл бага, бүртгэлтэй ажил хайж байгаа иргэн 14 орчим байдаг.

Сумд ямар нэгэн томоохон төлөвлөгдсөн эдийн засгийн хөгжлийн төсөл бий юу?

- Цэвэр бохир ус холбох, спортын ордон барих гэх мэт ажлууд байна. Сумандаа бүхэлд нь цэвэр бохир усанд холбогдох ажил аймгийн төсвөөр хийгдэхээр зураг төсөл нь явж байгаа. Ёслолын гэрт 40 сая төгрөгийн тавилга авч өгсөн компани байгаа. Компанийн нэр тодорхойгүй.

Орон нутгийн эдийн засаг эсвэл ажлын байр нэмэгдэх зэргээр энэ төсөлтэй холбоотой таны хүлээлт, болгоомжлол юу вэ?

- Эдийн засгийн хувьд ажлын байр гарвал ажиллах хүн олон байна. Ямар мэргэжил шаардахыг хэлж мэдэхгүй. Ажиллах хүчин бол хангалттай байгаа, сум орон нутагт тун хэрэгтэй. Анхаарах болгоомжлох зүйлийг мэдэхгүй байна. мэдээлэл бага байгаа учраас мэдэхгүй. Хамтарч ажиллах бол боломжтой.

САЙХАНДУЛААН СУМЫН ХӨДӨӨ АЖ АХУЙ, БЭЛЧЭЭРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ж. ӨЛЗИЙДАВАА	2025 оны 6-р сарын 27

Газрын ашиглалт (тариалан, мал аж ахуй, холимог)?

- Мал аж ахуй ихэнх хувийг эзэлдэг. Газар тариалан нийт газар нутгийн 4 га газарт тариалдаг. Малын тэжээлийн ургамал 1 га газарт тариалдаг. Үлдсэн хувь нь малчид, бэлчээрийн газар.

Газар өмчлөл, эзэмшлийн байдал ямар байдаг вэ? (Богино болон урт хугацааны түрээс, хамтын ашиглалт, хэрэглэгчийн нөхцөлд хамаарах аливаа татаас, хязгаарлалт байгаа эсэх)

- Сумын газар нутаг өмчлөлтэй. Гэхдээ сүүлийн 2 жил өмчилсөн газар олгоогүй байгаа. Бүх малчид өвөлжөөгөө эзэмшсэн байгаа. Сумын төвийн айлууд өмчилсөн. Өвөлжөө хаваржааны эзэмшил сайн.

Малын бэлчээр ашиглалт, эрхийн байдал ямар байдаг вэ?

- Газар нутгийн 98 хувь нь бэлчээрийн газар нутаг. Бэлчээр ашиглалтын хувьд асуудалгүй. Ган, зудтай үед отрын малчид орж ирдэг. Маргаан гардаггүй. Бэлчээр эзэмшинэ гэсэн ойлголт байхгүй.

Одоогоор өөр ямар байгалийн нөөц ашиглагдаж байна вэ?

- Нүүрсний уурхайн зөвшөөрөл байгаа гэхдээ одоо үйл ажиллагаа нь зогсчихсон. Ургамал талаасаа таана, хөмүүл ихэвчлэн ургадаг.

Газрын болон бусад байгалийн нөөцийн чанар цаг хугацааны явцад сайжирсан уу, муудсан уу?

- Нилээн хэдэн жилийн өмнө судалж байсан. Хайгуулын хэдэн компани байгаа. Таана, хөмүүлийн гарц сайн. Муудсан юм байхгүй.

Сүүлийн арван жилд газар болон байгалийн нөөцийн хүртээмж, чанар буурсан уу?

- Би энд ирээд 4 жил болж байна. Намайг ирснээс хойш тодорхой хэмжээнд бэлчээрийн доройтол байгаа. Сумын урд хэсгээрээ. Ургамлын гарцаас хамаарч явдаг.

Газар, нөөцийн алдагдал эсвэл хүртээмж буурснаар амьжиргаанд хэрхэн нөлөөлсөн бэ?

- Бэлчээр доройтоод ирвэл нүүдлээр явчихдаг. Бэлчээрийг сэргээх тал дээр хамтарч ажилладаггүй.

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авч байна вэ?

- Малчдадаа бэлчээр ашиглалтын журам гэж гаргаад, малчидтайгаа гэрээ байгуулж , өвөлжөө хаваржааныхаа газар зун нь тэжээлийн үргамал тариалах зөвлөмж өгдөг. Малчид үүнийг хэрэгжүүлдэггүй.

Төслийн хүрээнд газрын ашиглалт болон байгалийн нөөцийн талаар таны хүлээлт, болгоомжлол юу вэ?

- Нөлөөлөлд өртөж болзошгүй усны худагны байршилд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.

Монголын Алт (МАК) ХХК ярилцлагын тэмдэглэл

БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ХУУЛИЙН НИЙЦЭЛ ХАРИУЦСАН АХАХ МЭРГЭЖИЛТЭН САНЖМАА	2025 оны 7-р сарын 7

Та Сайншандаас Цагаансуварга руу тавих ЦДАШ-ын төслийн талаар сонссон уу? Мэдээлэл авсан уу?

- Сонсоогүй, ямар нэг мэдээлэл аваагүй байна

Одоогоор уурхайд хэдэн хүн ажиллаж байна? Ойролцоогоор хэдэн хүн өдөр бүр газар дээр ажилладаг вэ?

- Уурхай дээр биечлэн очиж ажилладаггүй учраас сайн мэдэхгүй. Ойролцоо тоогоор хэлье. Цагаансуваргын уурхайд одоогоор барилга угсралтын ажил явагдаж байна. Барилган угсралтын ажил 60 орчим хувьтай явж байгаа гэж мэдээлж байсан. Нийт 200 орчим монгол хүн үндсэн ажилтнаар ажиллаж байгаа. Харин туслан гүйцэтгэгч компаний 500 гаруй ажилчид ажиллаж байна. Энэ уурхай ашиглалтад бүрэн орсноор 1000-аас дээш тооны ажлын байрыг бий болгож улсын төсөвт нэлээд хэмжээний орлого оруулна

Уурхайд өөр цахилгаан холболт байна уу?

- Оюутолгойгоос татсан цахилгааны холболт л байгаа. Өөр холболт байгаа эсэхийг би мэдэхгүй байна.

Энэ төслийн талаар таны хүлээлт, санаа зовнил юу вэ?

- Бид байгаль орчны үнэлгээг 2 удаа хийсэн. 2025 онд байгаль орчны үнэлгээнд тодотгол хийхээр ажиллаж байна. Үнэлгээний үр дүнгээс харахад орон нутгийн иргэдтэй маш сайн холбогдож мэдээлэл өгч ажиллах ёстой юм байна харагдаж байсан.

Орон нутгийн иргэд болон оролцогч талуудтай хамтрах арга хэмжээг танай уурхай хэрхэн зохион байгуулдаг вэ? Шинээр тус бүс нутагт үйл ажиллагаа эхлүүлэх гэж буй операторууд, эсвэл төсөл хэрэгжүүлэгчдэд өгөх таны зөвлөмж, хуваалцах туршлага юу вэ?

- Ажлыг гүйцэтгэгч компани иргэдтэй уулзаж ажлын явц болон бусад мэдээллийг өгөх хэрэгтэй. Орон нутгийн иргэдэд танилцуулгаа зөв өгөөд, мэдээллийг сайн өгөөд байвал харьцангуйгаар эсэргүүцэл бага байна. Гол нь иргэдэд ямар үр ашиг өгөх вэ гэдгийг тодорхой хэлэх нь зөв байх.

Аж үйлдвэр, ашигт малтмалын нөөцийн яам ярилцлагын тэмдэглэл

АЖ ҮЙЛДВЭР ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ, ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС, АХЛАХ ШИНЖЭЭЧ ӨНӨРНАСАН	2025 оны 7-р сар

2025.07.08

Сайншандаас Цагаан Суварга хүртэлх 220 кВ-ын дээвэр дамжуулах шугамын төслийн талаар сонсож эсвэл ямар нэгэн мэдээлэл авсан уу?

- Би үүнийг сонсоогүй, мэдээлэл аваагүй.

Дамжуулах шугамын дагуу тусгай зөвшөөрөл (хайгуулын лиценз) эзэмшигчид олборлолт эхлүүлэх эсвэл өөрсдийн газруудыг ашиглах төлөвлөгөөтэй юу?

Төлөвлөсөн цахилгаан дамжуулах агаарын шугамын дагуу тусгай зөвшөөрөл (хайгуулын лиценз эзэмшигчид) эзэмшигчид олборлолтоо эхлүүлэх, ашиглах ямар нэгэн төлөвлөгөө байна уу?

- Компаниуд хэзээ олборлолтоо эхлүүлэхийг бид шууд мэдэх боломжгүй. Лицензийн талбай ашиглах тухайд ашигт малтмал газрын тосны газар л илүү нарийн мэднэ.

Агаарын угамын трассын дагуу өртөх газруудыг тусгах үүднээс тусгай зөвшөөрлийн хилийн заагийг шинэчлэх үү?

- Хил зааг өөрчлөгдөхгүй.

Энэ төсөлтэй холбоотой таны хүлээлт, болгоомжлол юу вэ?

- Төсөл хэрэгжүүлэх үедээ шугам сүлжээ инженерингийн байгууламжийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө анхаарч хамгаалах хэрэгтэй.

Орон нутгийн иргэд болон оролцогч талуудтай хамтрах арга хэмжээг танай уурхай хэрхэн зохион байгуулдаг вэ? Шинээр тус бүс нутагт үйл ажиллагаа эхлүүлэх гэж буй операторууд, эсвэл төсөл хэрэгжүүлэгчдэд өгөх таны зөвлөмж, хуваалцах туршлага юу вэ?

- Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын төслүүд хэрэгжихэд цахилгаан эрчим хүч хэрэгтэй учир компаниуд ихэнх нь дэд станц барьж өөртөө ашиглана гэдгээр дуртай байх болов уу гэж бодож байна. Харин нөөц нь бодогдсон талбайд цахилгааны шугам явж таарч байгаа тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч нөөц эзэмшигч компанитай тохиролцох хэрэгтэй болно
- ***Тэмдэглэл:*** *Уртнасан Ашигт малтмал газрын тосны газрын хайгуул ашиглалтын газрын дарга Ган-Очиртой ярилцлагад холбож өгөв.*

С. Ган-Очир*: Ашигт малтмал газрын тосны газар, Хайгуул ашиглалтын газрын дарга*

- Энэ асуудлыг хүрээнд нөөц бодогдсон газарт шугам тавих тухайд тохиолдол бүрт асуудлыг тус тусад нь шийднэ. Өөрөөр хэлбэл, нөөц бодогдсон газрын эзэмшигч компаниудтай төсөл хэрэгжүүлэгч уулзаж тохиролцон асуудлыг шийднэ. Лицен эзэмшигч болон ашигллат олборлолтыг эхлүүлэх гэж байгаа тухай мэдээллийг бид шууд өгч чадахгүй. Харин танай төслийн шугамын дагуу байрлаж байгаа лицензүүдийн мэдээллийн зургийг гаргаж өгч болно.
- Уул уурхайн компаниудын хувьд энэ цахилгаан дамжуулах шугамын ажлыг 2 талтай хүлээж авах байх. Танай төсөл энэ тал дээр анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Цахилгааны шугам явснаар дэд станц байгуулан ажлаа хурдлуулах болмжтой боллоо гэсэн нэг хэсэг компаний гарна
- Тэсэлгээ хийх шаардлагатай компаниудын хувьд шугамыг суурилуулах талбай таарвал асуудал үүснэ.

- Мөн тэсэлгээ хийх үед шугамд нөлөөлөхгүй байх талаас бодолцох ёстой байх. Нөөц байгаа газарт шугам суурилуулж таарах бол тэр газрын эзэмшигч компани бүртэй уулзах хэрэгтэй, үнэлгээ хийх хэрэгтэй. Уурхайн кэмп, агуулах тэсэлгээ хийх талбай зэргийг заавал бодолцож ажлаа эхлүүлэх хэрэгтэйг сануулъя.

Монголын төмөр замын төрийн өмчит хувьцаат компани ярилцлагын тэмдэглэл

Дохиолол холбоо, эрчим хүчний асуудал хариуцсан хэлтсийн дарга Хатанзориг	**2025 оны 7-р сарын 8**

Огноо: 2025.07.08

Сайншандаас Цагаан Суварга хүртэлх 220 кВ-ын дээвэр дамжуулах шугамын төслийн талаар сонсож байсан уу? Ямар нэгэн мэдээлэл авсан уу?

- Үгүй, одоо л сонсож байна.

Төмөр замын үйл ажиллагааны хуваарь ямар вэ?

- Төмөр замын ашиглалт тогтмол бус. Ачаалал хэр их байхаас хамаарч олон эсвэл цөөн удаагийн тээвэрлэлт хийдэг. Танай төсөл хэрэгжээд эхлэхэд дахиад л өөрчлөгдсөн байна байх.

Өргөтгөх төлөвлөгөөтэй юу? Хэрэв тийм бол, хэзээ, хаана (дэлгэрэнгүй)?

- Одоогоор манай төмөр зам 6 зөрлөгтэй бөгөөд 12 зөрлөгтэй болгох өргөтгөсөн төлөвлөгөө бий. Хэрэгжүүлж эхлээгүй. Гэхдээ төлөвлөсөн байгаа тул танай төслийхөн бидэнтэй ярилцах хэрэгтэй.

Энэ төсөлтэй холбоотой таны хүлээлт, болгоомжлол юу вэ? Шинээр тус бүс нутагт үйл ажиллагаа эхлүүлэх гэж буй операторууд, эсвэл төсөл хэрэгжүүлэгчдэд өгөх таны зөвлөмж, хуваалцах туршлага юу вэ?

- Төсөл гүйцэтгэгч ажлыг эхлэхээс өмнө манай байгууллагаас техникийн нөхцөл авах хүсэлт гаргах хэрэгтэй. Техникийн нөхцөлийг авч түүнд тохируулан ажлаа явуулах, бидэнтэй ярилцаж зөвшилцөх хэрэгтэй.
- Төмөр зам дээгүүр хөндлөн гарахдаа Монголын төмөр зам ТӨХК-д мэдээлж, холбогдох инженер техникийн ажилтнуудтай хамтрах ёстой. Мөн манай төмөр замыг дагаад 35квт цахилгаан шугам явж байгаа, түүнийг бас огтлох юм байна. Цахилгааны шугам болон төмөр зам дээгүүр давуулах тухайд техникийн нөхцөл хүсэх хэрэгтэй юм байна.
- Хамгийн гол нь манайхаас техникийн нөхцөл авах чухал гэдгийг дахин сануулъя.
-
- Ажил эхлэхээс өмнө төслийн хөгжүүлэгч манай байгууллагаас албан ёсоор техникийн үзүүлэлтүүдийг хүсэх ёстой. Ажил тухайн техникийн нөхцөлд нийцүүлэн явагдана, багуудын хооронд зохицуулалт байх ёстой.
- Төмөр замыг гатлах үед Монголын Төмөр Замын Сурталчилгааны Төвд мэдэгдэж, инженер, техникийн ажилтнуудтай хамтран ажиллах нь зайлшгүй шаардлагатай. Мөн төмөр замын дагуу 35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам байрлаж, энэ шугамыг огтлолцох болно. Хөгжүүлэгч нь цахилгаан дамжуулах шугам болон төмөр замын гарцын техникийн үзүүлэлтүүдийг хүсэх ёстой.
- Би дахин хэлэхийг хүссэн гол мессеж бол: техникийн үзүүлэлтүүдийг авах нь зайлшгүй чухал.

Үндэсний Цахилгаан Дамжуулах Сүлжээ ярилцлагын тэмдэглэл

CIS-ийн захирал ***Чулуунбаатар***	**2025 оны 7-р сарын 8**

Огноо: 2025.07.08

Үгүй.	Асуулт	Хариулт
1	Компанийн бүтэц, зохион байгуулалтын схем/	Шинэчлэгдсэн. Имэйлээр явуулна.
2	Хэлтэс, нэгж тус бүрийн чиг үүрэг? Тус бүр хэдэн хүнтэй. /	Нийт 5 салбар, 13 хэлтэстэй. ЗГ-аас сүүлд гаргасан шийдвэрийн дагуу 5 салбар 7 болж болзошгүй./ Нийт 1400 хүнтэй. 60% эрэгтэй, 40% эмэгтэй.
3	БОН асуудал хариуцсан аливаа нэгж эсвэл мэргэжилтэн байдаг эсэх?	Хариуцсан ажилтнаас тодруулна.
4	Төсөл хэрэгжүүлэх нэгж байдаг гэж веб хуудас дээр мэдээлэл байсан. Байдаг бол ямар төсөл хариуцдаг вэ?	Хариулаагүй.
5	Нийт ажилчдын тоо, үүнээс эмэгтэй ажилчид, 2024 оны эцсээр, шинэ шугамын ашиглалтын шатанд ажилчдын тоо нэмэглэх үү? Хэрэв тийм бол, хэдэн хүн, аль салбарт?	Нийт 1400 хүн байна. 60% нь эрэгтэй, 40% нь эмэгтэй.
6	Салбарын ажилчдын тоо, үүнд мөн адил эмэгтэйчүүдийн тоо, салбар тус бүрээр	Хариуцсан ажилтнаас тодруулна.
7	БОНЭМАА-ны бодлого, журмууд бий юу?	Хариуцсан ажилтнаас тодруулна.
8	Байгаль Орчин Нийгмийн Менежментийн Систем бий юу?	Хариуцсан ажилтнаас тодруулна.
9	Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн бодлого эсхүл журам бий юу?	Хууль, журам баримтлан ажилладаг.
10	Аюулгүй ажиллагаа хариуцсан газар, хэлтэс бий юу?	Хяналт, мониторингийн хэлтэс
11	Дотоод мониторинг хийдэг эсэх, журам байдаг эсэх?	Журам, дүрэмтэй, тодорхой хуваарьтай, шалгах хуудсын дагуу шалгадаг.
12	Гомдол барагдуулах GRM байдаг эсэх? www.11-11.mn-ээс гадна. 2024 онд хэдэн гомдол хүлээн авсан, хэрхэн шийдвэрлэсэн бэ?	Дотоод ёсзүйн хороотой. Аваарь, саатлыг судлан бүртгэх комисс ажилладаг.
13	Хүний нөөцийн бодлого байгаа эсэх, ямар бодлого баримталдаг вэ?	Бодлого бий. Бэлтгэх, чадавхжуулах гээд бий.

14	Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр эрхлэлтийн эсрэг ямар арга хэмжээ авдаг вэ?	18-оос доош насны хүн ажиллахыг хориглодог.
15	Ажлын байран дээрх дарамт, бэлгийн дарамтын эсрэг бодлого байдан эсэх?	Жендер хариуцсан ажилтантай. Сургалт явуулдаг. Жишээ нь өнөөдөр сургалт явагдаж байна.
16	Шүүхэд нэхэмжлэлтэй эсэх, өөрөөр хэлбэл шүүхийн шатанд байгаа хэргийн тоо?	Хуульч хариуцдаг.
17	Хөдөлмөрийн АА-тай холбоотой ямар журмуудтай вэ, ХАБ-ын хороо, хүний тоо гэх мэт, ямар Хувийн Хамгаалах Хэрэгсэл ашигладаг?	Компанийн хувьд #1 асуудал гэж онцгой анхаардаг. Бүх мэргэжлийн чиглэлээр журам, зааврууудтай, хэрэглэгчидтэй харилцдаг харилцааны загвартай. Хяналт Мониторингийн хэлтэс бодлого эрсдэл, үнэлгээ, хэрэгжилт, чанар, хэрэглэгч хариуцдаг. ҮЭХ-оор ажилчдын асуудал яригддаг. ҮЭХ-ны байнгын оролцоотой./OHS нь компанийн #1 тэргүүлэх зорилт юм.
18	Дасгал, сургуулалт хийдэг эсэх? Хийдэг бол хэрхэн яаж, давтамжийн тоо Дасгал уу? Давтамж?	Аюулгүй ажиллагаа, галтай холбоотой сургалт, гамшиг, аваарийн дасгал дааврын дагуу хийгддэг. Эрсдэлийн үнэлгээ жил болгон хийдэг, шинэчилж батлуулдаг.
19	Жендерийн тэнцвэртэй байдал хэр хангагдсан бэ?	40% эмэгтэй, 60% эрэгтэй
20	ЦТҮС компани гэрээт гүйцэтгэгчиддээ хэрхэн хяналт тавьдаг вэ?	Барилга гэх мэт өөр төрлийн гэрээгээр хийлгүүлдэг ажлууд бий. Гэрээндээ холбогдох заалтуудаа тусгаад, чиглэл чиглэлээр нь хариуцсан ажилтнууд хянаад, явдаг. Худалдан авалтын хууль, журмын дагуу явж байгаа.
21	Судалгааны үр дүнд үндэслэн, төлөвлөгдөж буй өндөр хүчдэлийн дамжуулах шугам (ӨХДШ) нь төв шугамаас 20 метр доторх бүсэд хязгаарлагдан байрлаж, ажилчид өдөрт 4 цагаас дээш хугацаагаар тухайн бүсэд ажиллах тохиолдолд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл байж болзошгүй. Мөн ашиглалт ба засвар үйлчилгээний (А&З) ажлуудын явцад дээрх хугацаанаас давж үргэлжлэх боломжтой юу?	Нөлөөллийн бүсэд ажиллах хугацааг заасан байдаг. Нөлөөлөл болон халхавчлах гэж байдаг. Нөлөөлөл, хүчиллэг үүсээд байгаа нөхцлийг тодорхойлдог. Үүний үндсэн дээр ажилладаг. Зарим онцгой тохиолдолд ГЗ-ын тусгай тушаал гарч, гүйцэтгэх ажлыг нарийвчлан зааж өгдөг.
22	Дараах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг ашиглалтын үе шатанд хэрэгжүүлэх шаардлагатай:	Ажил мэргэжлийн стандартуудыг шинэчлээд явж байгаа. ҮЭХ-г мөн үүнд оролцуулдаг. Хүчдэлээс хамгаалах. ISO45001 нэвтрүүлсэн, хэрэгжилтийг хангаж ажилладаг.

Хавсралт Е Фокус бүлгийн ярилцлагын арга барил, асуултууд

Фокус бүлгийн ярилцлага (FGD)

Төслөөс шууд болон шууд бусаар нөлөөлөлд өртөх боломжтой орон нутгийн бүлгүүдийг хамруулан Фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулсан болно. Фокус бүлгүүдэд:

- Одоогийн шороон замын хоёр талд газар эзэмшдэг тариалан эрхлэгчид
- Замын ойролцоо мал бэлчээрлэдэг малчин өрхүүд (хээрийн судалгаагаар баталгаажуулах)
- Эмзэг бүлгийн хүмүүс/өрх
- Нөлөө бүхий хүн (сумын ахмадын холбоо, эмэгтэйчүүдийн холбоог хамруулах)
- Жижиг бизнес эрхлэгчид

Нэг Фокус бүлгийн ярилцлага нь дараах бүлгийн оролцоотойгоор зохион байгуулав:

- Хөдөө аж ахуйн мэргэжилтэн (тариаланчид) болон бизнес эрхлэгчид;
- Сумын оршин суугч, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн (боломжтой бол), иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл (байгаа бол), болон малчид.

Бүлгийн хэлэлцүүлгээр дараах сэдвийг голлон хамруулав:

- Дэд бүтцийн хөгжил, тэр дундаа хатуу хучилттай замын талаарх орон нутгийн иргэдийн ойлголт, хандлага
- Байгаль орчин, нийтийн аюулгүй байдал, газар ашиглалт, эдийн засгийн боломжуудтай холбоотой (эерэг, сөрөг) хөгжлийн тулгамдсан гол асуудал, анхаарах зүйл
- Эдгээр асуудлыг төслийн хүрээнд хэрхэн зохицуулах
- Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, ажлын байр бий болгох, орон нутгийн хангамж бий болгох боломжийн талаарх оролцогчдын үзэл бодол
- Ирээдүйн оролцогч талуудын үйл ажиллагаанд хандуулсан төслийн санал, зөвлөмж

Фокус бүлгийн ярилцлага бүр 6-8 хүнийг хамруулахыг зорьсон болно. БОНиНҮ-ийн багийн нэг гишүүн ярилцлагыг удирдаж, хоёр гишүүн тэмдэглэл хийнэ. Бүлгийн ярилцлага 2 цагаас ихгүй хугацаагаар үргэлжилнэ.

Бүлгийн ярилцлага нь дараах дүрмийг баримтална:

- Судалгааны багийг танилцуулах;
- Төлөвлөсөн төслийг танилцуулах;
- Хэлэлцүүллгийн үеэр үндсэн дүрмийг баримтална (харилцан хүндэтгэлтэй байх, бусдын үзэл бодлыг хүндлэх, илт сөрөг байр суурь илэрхийлэхээс зайлсхийх, яриан дундуур чанга ярихгүй байх, утсаар ярихгүй байх, яаралтай нөхцөлд өрөөнөөс гарч ярих);
- Ярилцлагад оролцогчдод тайланд оруулахгүй болохыг тайлбарлах;
- Илэрхий итгэхгүй байх, сөрөг үйлдэл, зан авир гарсан тохиолдолд судалгааны баг дүрмийг дахин сануулна.

Бүлгийн ярилцлагад ашигласан асуултуудыг дараах байдлаар ашиглав:

Танилцуулга

Бие даасан зөвлөх үйлчилгээний компани ЕСБХБ-аас төлөвлөсөн төслийн нийгэм эдийн засгийн эерэг, сөрөг нөлөөллийг судлах, үнэлгээ хийх үүрэг авсан. Энэ хүрээнд та бүхний төслийн талаарх санал бодол, болгоомжлолыг авч үзэх шаардлагатай. Тус санал бодол, болгоомжлолыг хэн нэгэнтэй холбохгүйгээр нууцлах болно.

Бүлгийн ярилцлагаар нэмэлт газрын зураг, схем, зураглалын хамт товч танилцуулах бөгөөд нөлөөллийг бууруулах арга хэмжээг судална.

Ярилцлагад оролцогчдын хүйс, ажил/үүрэг:

(1) Төслийн талаар асуух зүйл байна уу? (Тухайн асуултыг тодорхойлох шаардлагатай бол тэмдэглэж, тодруулсны үндсэн дээр хариулах)

(2) Төслөөс ямар хүлээлттэй байна вэ?

(3) Тодруулбал, энэ төсөл таны болон олон нийтийн ...

… Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлөх вэ?

… Эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх вэ?

… Нийгмийн байгууламж, дэд бүтэцэд хэрхэн нөлөөлөх вэ?

… Газар, амьтан, орон сууцад хэрхэн нөлөөлөх вэ?

… Дуу чимээ, тоосжилт, үзэгдэх орчинд хэрхэн нөлөөлөх вэ?

… Сэтгэл зүй, биеийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлөх вэ?

… Нийтийн эв нэгдэл, соёл, чөлөөт цагт хэрхэн нөлөөлөх вэ?

Тухайлбал, танай нийгэмд ямар соёлын болон оюуны биет бус өв байгаа вэ? Үүнд хэрхэн нөлөөлж болох вэ?

Судалгааны бүсэд замын төсөлд хамгаалалт шаардлагатай гэж үзэж буй ямар нэгэн соёлын өв эсвэл дурсгалын газрууд бий юу? (хаана/яагаад)?

… засаг захиргаа, гэмт хэрэгт хэрхэн нөлөөлөх вэ?

(4) Төслийн гол эерэг хувь нэмрийн талаар та хэрхэн бодож байна вэ?

(5) Танд болон олон нийтэд төслийн талаарх болгоомжлол, асуудал юу вэ?

(6) Эдгээр асуудлыг хамгийн сайнаар шийдвэрлэж болох санал байна уу?

(7) Төслийн талаар онцгой, тухайлсан эсвэл өөр байр суурьтай хүмүүст төслийн талаар ятгаж чадах уу?

(8) Баярлалаа, нэмэлт асуулт эсвэл санал байна уу?

Хавсралт F Бүлгийн ярилцлагын хурал (FGD)

Сайншанд сумын бүлгийн ярилцлагын бүртгэл



БҮЛГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА - ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ТӨСӨЛ

Аймаг/Сум/Баг: Дорноговь Сайншанд

Огноо: 2025.06.23

No	Овог нэр	Холбоо барих утас	Хүйс/нас	Эрхэлж байгаа ажил (хувиараа бизнес эрхэлдэг, тэтгэвэрт, гэрийн эзэгтэй гэх мэт)	Гарын үсэг
1	Рэнцэнхаяа Наранцэцэг	86203739	эм 66	Тэтгэвэр 1-р 80 айлын 1 өрх 35	
2	Жаргал Жаргалсайхан	85915115	эр 60	Групп-д	
3	Өлзийсүрэн Эрдэнэчимэг	96325088	эм 58	Тэтгэвэр	
4	Сайхан Гүнжаа	86090633	эм 46	Малчин	
5	Мөнгөнчимэг	96630726	эм 35	6-р баг хүнсний дэлгүүр	
6	Нинжин Оюунцэцэг	99291767	эм/58	6р баг хөдөлгөгч	
7	Ц. Арсланбаяр	90908868	Ер/ эр	Нөөцлөгч оператор	
8	Л Энхцэцэг	94901010	эм/29	6р баг Найзжин ажилтан	
9					
10					
11					
12					
13					
14					
15					

Сайншанд сумын бүлгийн ярилцлагын тэмдэглэл

Төслийн талаар мэдээлэл авсан уу?

- Төслийн талаар мэдээлэл хараахан аваагүй.

Төслөөс ямар хүлээлттэй байна вэ?

- Цахилгаан эрчим хүч учир ард иргэдийн амьдрал дээшилнэ

Энэ төсөл таны болон орон нутгийн орон нутгийн амьдралд хэрхэн нөлөөлөх гэж бодож байна?

- Санхүүжилтийн эх үүсвэртэй холбоотой санаа зовнил: төсвийг хэн гаргадаг вэ? Иргэдийн амьжиргаа, орон нутгийн хөгжилд маш чухал. Төсөл нь хувийн өмч эсвэл төрийн өмчит уу? Тодруулах хэрэгтэй байна.

Эдийн засаг болон ажил эрхлэлтийн нөлөө:

- Иргэд ажилд орох боломжтой. Ажилд авах нь ихэвчлэн боловсрол, ур чадварын түвшинд тулгуурладаг.
- Олон хүн туслах ажилтнаар ажиллах боломжтой. Хамгийн чухал зүйл бол цалин найдвартай байх
- Улирлын ажлууд оюутан, хүүхдүүдэд хэрэгтэй.

Цахилгаан хэрэглээ, баталгаат байдал

- Өмнө нь Мандах сумд цахилгаан байгаагүй. Гэвч Цагаан Суварга Оюу Толгой төслөөс цахилгаан авахыг эхлүүлэхэд Мандах сум цахилгаан авсан. Сумын иргэд болон амьжиргалтын хувьд сайн нөхцөлтэй.
- Эрчим хүч их тасардаг, төлбөр нь их гардаг. Төлбөр 20-нд төлөөгүй тохиолдолд цахилгаан хязгаарладаг.
- Цахилгаан тасарсан тухай мэдээлэхдээ цахилгаанчин голдуу товлосон цагтаа ирдэггүй. Дуудлагын утас байгаа ч дуудлага авдаггүй, баталгаагүй.

Дэд бүтэц ба нийгмийн үйлчилгээ

- Дэд бүтцэд эерэг нөлөө үзүүлнэ.

Эрүүл мэнд:

- Эмнэлгийн үйлчилгээний чанар муу.
- Ажилтны хандлага тааруу, өндөр төлбөртэй.
- Урт дараалал үүссэн байдаг.

Боловсрол:

- Сургуулийн хүртээмж сайн, 6 сургуультай.
- Сургуулийн ачаалал нэмэгдэж байна.
- Нэг сургуульд (6-р сургууль) шинэхэн төгссөн залуу багш нарын хандлага тааруу байдаг.
- Шинэ сургуулийн үйлчилгээ, сургалтын чанарт болон багш, ажилчдын ёс зүйд анхаарал хандуулах шаардлагатай.

Цэцэрлэг:

- Нийт 11 цэцэрлэг бий. Чанар, хүртээмж сайн.

Газар:

- Газрын албатай харьцахад хүндрэлтэй байдаг.
- Эзэмшил, өмчлөл авч чаддаггүй.
- Зөвхөн нэг хүн 0.07 га газар эзэмшсэн. (Оролцогчдоос)

Орон сууц:

- Олон хүн орон сууц төлж чадахгүй.
- Түрээсийн орон сууцнууд маш үнэтэй

Танай орон нутагт ямар төрлийн соёлын болон оюуны биет бус өв байдаг вэ? Мөн эдгээр нь уг төсөл (замын бүтээн байгуулалт)-ийн нөлөөнд хэрхэн өртөж болзошгүй гэж та бодож байна вэ?

- Цагаан цав хөгжих боломжтой. Цахилгаан эрчим хүч оччихвол рашаан сувилал гэх мэт хөгжих боломжтой.
- Хийморийн овоо - Уяачдын Босгосон овоо
- Хамрын хийд,
- Чойлонгийн хайрхан жил бүр 5-6 сард тахидаг.
- Өдөр судар харж байгаад бөх барилдах, морь уралдах зэрэг

Орон нутгийн хөгжилд болон гэмт хэргийн нөхцөл байдалд?

- Хулгай түгээмэл тохиолддог, ялангуяа түр зуурын хүмүүс.
- Архины хэтрүүлэг болон гэр бүлийн хүчирхийлэл өргөн тархсан.
- Далд хүчирхийлэл асуудал болдог.

Төслийн талаарх мэдээллийг хэрхэн, хэзээ авахыг хүсэж байна вэ? Мөн зохион байгуулагдах уулзалт, хэлэлцүүлэгт оролцох сонирхолтой байна уу?

- Мэдээлэл Facebook дээр тавих.
- Багийн хэсгээр дамжуулан цахимаар мэдээлэл тараах
- Байгууллага дунд Telegram болон Viber-аар хүргэх
- Facebook болон телевизийг олон нийтэд хүрэхэд ашиглах
- Баг эсвэл сумын хурлаар мэдээлэл хүргэх

Сайжруулах зөвлөмж

- Гэрэлтүүлэг хийх, цамхагт гэрэл суулгах
- Олон нийтийн аюулгүй байдлын үүднээс хяналтын камерыг нэмэгдүүлэх

Сайншанд сумын бүлгийн ярилцлагын зураг

Улаанбадрах сумын бүлгийн ярилцлагын бүртгэл

БҮЛГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА - ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ТӨСӨЛ

Аймаг/Сум/Баг: Улаанбадрах

Огноо: 2025-06-25

No	Овог нэр	Холбоо барих утас	Хүйс	Эрхэлж байгаа ажил (хувиараа бизнес эрхэлдэг, тэтгэвэрт, гэрийн эзэгтэй гэх мэт)
1	Ч. Отгонцэцэг	95848397	эм	Нийтийн ажлын ажилтан
2	Б. Цэрэнчимэг (26)	80829878	эм	Хүүхдийн багш наац
3	Ц. Баяр 54	88837047	эр	Мал аж ахуйн ажилтан
4	Г. Ганзориг (44)	99142620	эр	2-р багийн засаг дарга
5	0		эм	
6	Б. Наранцэцэг	99227771		Оюутан бэлтгэгч
7	Г. Энхтүшиг	99595213	эм	Ур бие эндэр малтан
8	Б. Чимэд	99975086	эм	Монха
9				
10				
11				
12				
13				
14				
15				

Улаанбадрах сумын бүлгийн ярилцлагын тэмдэглэл

Төслийн талаар ямар нэгэн мэдээлэл байна уу?

- Сонсож байгаагүй.

Төслийн хүлээлтүүд

- Малчид ашиглах боломж олгох
- Багийн иргэдийн нийтийн хуралд төслийн мэдээллийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг хүсэж байна.
- Нөлөөлөлд өртөх айлуудыг оролцуулах

Одоогийн эрчим хүчний байдал

- Одоогийн эрчим хүч хэвийн байдаг. Зарим тохилдолд хүчин чадал муу байдаг.

Эдийн засаг ба хөдөлмөрийн нөлөө

- Эдийн засгийн үр өгөөж Улаанбадрах суманд бага гэж үзэж байна. Улсын хэмжээнд эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

Орон нутгийн газар ашиглалт, мал аж ахуй, агаарын тоосжилт үүснэ гэж үзэж байна уу?

- Төслийн бүтээн байгуулалтын явцад тоос шороо их босно. Цахилгаан дамжуулах агаарын шугам тавих явцад зам хусах эрсдэлтэй, улмаар малчдын бэлчээрт нөлөөлнө. Тодорхой болгох шаардлагатай:
  - Газар ашиглалтын төлбөрийг хэрхэн төлөх,
  - Хэн хариуцахыг тодорхойлох.
  - Улаанбадрах сум руу холбох боломжтой эсэхийг мэдээллэх.

Цахилгаан дамжуулах агаарын шугамаас шалтгаалан шувуу, мал, амьтан үрэгдсэн тохиолдол гарч байсан уу?

- Улаанбадрах суманд анх цахилгаан шугам тавьсны дараа шувуу, хэрээ үхсэн тохиолдол гарч байсан. Шувуу үргээгч тухайн үед байхгүй байсан.

Соёлын болон оюуны биет бус өв

- Тусгай хамгаалалттай газар орж байгаа эсэхийг тодорхойлох.
- Улаанбадрах сумын нутгаас үлэг гүрвэлийн яс олдож байсан.

Нэмэлт сэтгэгдэл, санал

- Сумын иргэдээс цахимаар санал авах шаардлагатай.
- Отрын бүс нутгаар дайран гарч байна. Отрын бүс нутгийг хамгаалах
- Олон зам гаргахгүй байх.
- Өндөр хүчдэлийн шугам дуу чимээтэй байдаг. Тавьж байх явцад л тоосжилт гарна.
- Бүтээн байгуулалтын хугацаа 2 жил бол орон нутгаас ажиллах хүч оролцуулах.

Улаанбадрахын сумын бүлгийн ярилцлагын зураг

Мандах сумын бүлгийн ярилцлагын бүртгэл

БҮЛГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА - ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ТӨСӨЛ

Аймаг/Сум/Баг: Мандах

Огноо: 2025-06-26

No	Овог нэр	Холбоо барих утас	Хүйс	Эрхэлж байгаа ажил (хувиараа бизнес эрхэлдэг, тэтгэвэрт, гэрийн эзэнтэй гэх мэт)
1	Н. Отгонцэцэг	9936 9108	эм	Сүүгээ шууд борлуулдаг ирээ ярьдаг
2	Ш. Ковалевский	91668288	эр	Фермер
3	М. Жаргалсайхан	88935006	эр	Хувиараа бизнес эрхлэдэг
4	Б. Ганбаяр	99794524	эр	4-р багийн даргын
5	Х. Эрдэнэбаяр	99170558	эр	2-р багийн Багийн Чиглэгч.
6	Ц. Цэнд-Аюуш	80309907	эр	4-р багийн Сонгуулийн О.Н.С.Т.А.
7				
8				
9				
10				
11				
12				
13				
14				
15				

Мандах сумын бүлгийн ярилцлагын тэмдэглэл

Төслийн талаар ямар нэгэн мэдээлэл байна уу?

- Үгүй, энэ төслийн талаар анх удаа сонсож байна

Төслийн хүлээлт, болгоомжлол

- Эрчим хүчний хүчин чадал нэмэгдэж байж тухайн хүний амьдрал ахуй дээшлэх боломжтой болно. Эрчим хүчийг хаанаас авч байна гэдэг нь чухал.
- Бор хошууны зөрлөг: Терминалын талбай байгаа. 50 МВт-ын шинэ цахилгаан станц барихаар Аймаг тендерээр батлагдсан. Аймаг тусгай хэрэгцээнд авсан. Төсөлтэй холбогдох боломжтой эсэх талаар тодруулах.
- Сум, орон нутагт өгөөжтэй байна гэж үзэж байна.
- Цагаан цав руу цахилгаан татах
- Аюулгүй байдал, стандартаа сайн мөрдөж ажиллах шаардлагатай.
- Төсөл хийхэд хүмүүс тодорхой хэмжээгээр ирж явна. Гадны хүмүүс ирж явахад гайгүй, хийх ажлаа хийгээд явж байхад асуудал үүсгэхгүй гэж үзэж байна.
- Цахилгаан сайжруулбал тоног төхөөрөмж эвдрэхгүй байх, зардал буурах боломжтой.
- Ачаалалтай байдаг, цахилгааны эрэлт хэрэгцээ их байдаг.

Одоогийн эрчим хүчний сорилтууд:

- Эцсийн хоёрдогч дамжуулалтын шугамд байдаг тул дутагдалтай тал их байдаг.
- Цагаан суваргаас тогоо татдаг тул шөнийн тогны хөнгөлөлт Мандах суманд үйлчилдэггүй. Оросоос ирж буй тогтой огт хамааралгүй тул үйлчлэхгүй.
- Зарим айл, иргэд арьс шир боловсруулах, хөнгөн үйлдвэрлэл хийхэд тогны төлбөр өндөр гардаг. Үүнээс гадна тогны хүчдэл унахад техник төхөөрөмжүүдээ эвдэх тохиолдол цөөнгүй байдаг.

- Малын тэжээл үйлдвэрлэхэд ашиглах тээрмийн төхөөрөмж ашигладаг. Төхөөрөмж нь 1-2 жил ажиллаад эсвэл суманд дөнгөж авчраад байж байхад цахилгаан доголдлоос болоод эвдэрчихдэг.
- Сумын айл өрхүүдэд овъёос тээрэмдэх машин байсан ч эвдэрчихсэн.
- Цахилгаан нь тогтмол тогтвортой байж чаддаггүй.
- Тогоо сайжруулбал амьдрал ахуйд эерэг нөлөөтэй. Дуу чимээ багасгах, тогоо хэмнэх үүднээс салгадаг. Тогны төлбөр нэмэгдснээс хойш сардаа 80,000 төгрөг гардаг болсон. Хуучин 2024 онд 20-40 мянга орчим байдаг байсан.
- Тогны хүчин чадал нэмэгдүүлэх хүсэлтэй байна.
- Эрчим хүч тасралтгүй найдвартай болсон нөхцөлд иргэд үйлдвэр үйлчилгээгээ сайжруулна. Талх нарийн боовны үйлдвэртэй болох эрэлт хэрэгцээтэй байдаг.

Жижиг болон дунд бизнесүүд

- **Кофе шоп:**
  - 10 гаруй жил үйл ажиллагаа явуулж байна.
  - Гаазан плитка ашигладаг; цахилгаан тасарснаас шалтгаалан хэрэглэгчид ихэвчлэн хоол идэхээр ирдэг
  - Өдөрт 20 хүн, оройн цагаар илүү олон хүнд үйлчилнэ
  - Малчнаас мах худалдаж авдаг; газар дээр гурил бэлтгэдэг; Өдөр бүр шинэ хоол
  - Гурил, будаа олж авахад хүндрэлтэй; Өртөг нь 200,000 төгрөг болдог.
- **Дугуй засвар:**
  - Хувиараа 3 жил ажилуулсан
  - Мандах суманд өөр хэд хэдэн дугуй засварын газар ажилладаг тул хүн ирж үйлчлүүлэх нь цөөн.
- **Талх, нарийн боов:**
  - Гэрийн нөхцөлд талх, боов хийж зардаг иргэн бий.
  - Мандах сумын иргэд авч хэрэглэдэг. Хийсэн бүтээгдэхүүнээ заримдаа дэлгүүрт цөөн тоогоор байрлуулдаг.

Төслийн талаар олон нийтийн асуудал

- Охидын эцэг эхчүүд аюулгүй байдлын талаар онцгой санаа зовдог; гадны хүмүүс оролцсон гэмт хэрэг байнга гардаг. Сумд хяналтын камер идэвхтэй байдаг ч эцэг эхчүүд аюулгүй байдлын үүднээс хүүхдүүдээ байнга шалгадаг.
- Тээврийн тоосоор эрүүл мэндэд нөлөөлдөг. Бороо ховор байна.
- Мал эмнэлгийн үйлчилгээ үйлчлүүлэгчдийг дагадаг; Хөдөө орон нутгийн оршин суугчид ганцаардлыг мэдэрдэг.
- Боловсрол, нийгмийн сэтгэл зүйн асуудал хамгийн их тулгамдаж байна.
- Залуучуудын зан байдал заримдаа саад болдог. Дуу чимээ нь хүндрэлтэй.
- Залуучуудын нийгмийн идэвх илүү их шаардлагатай байна.

- Ахмад настнуудын холбоо нь маш идэвхтэй бөгөөд үндэсний удирдагчаар хүлээн зөвшөөрөгддөг. Ахмадууд ихэвчлэн уулзалт, олон нийтийн үйл ажиллагаанд оролцдог.
- Залуучуудын байгууллагуудыг идэвхгүй, дэмжлэг багатай гэж шүүмжилдэг.
- Боловсролын боломж дутмаг байсан тул залуучууд хөдөө орон нутагт буцаж ажиллах хандлага багатай байдаг.

Соёл биет ба биет бус өв

- Шинэ ус гэж археологи, палеонтологиор илэрсэн газар байдаг. Аймгийн тусгай хамгаалалтад орсон. Одоогоор тэмдэглэгээ хийгээгүй шинээр аймгийн тусгай хамгаалалтад орсон. Эртний ганц нэг шарил олдож байсан. Мандах, Улаанбадрах хоёрын заагт байдаг. Сумын хамгийн зүүн талын цэг.

Олон нийтийн санал

- Аюулгүй байдал, холбогдох стандартыг хангаж ажиллах.
- Ажлын байр нэмэгдэх боломж байгаа эсэхийг тодруулах. Сумаас хүн мэргэшүүлж, ажиллуулах саналтай байна.
- Сумд нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдэд боловсролоор хангах хэрэгтэй. Малчдаар явахад сэтгэл зүйгээр дэмждэг. Жилд нэг удаа малчдад сэтгэл зүйгээр дэмжих.
- Цахилгааныг дагаад хөгжил бий болно. Тодорхой хэмжээгээр газар хөндөж байгаа учраас төгөл мод тарьж орчны тохижуулалт хийх.
- Шувууны аюулгүй байдалд анхаарах.
- Багийн хурал дээр төслийн талаар малчид, иргэдэд дэлгэрэнгүй танилцуулах.

Мандах сумын бүлгийн ярилцлагын зураг

Сайхандулаан сумын бүлгийн ярилцлагын бүртгэл



БҮЛГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА - ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ТӨСӨЛ

Аймаг/Сум/баг: Дорноговь Сайхандулаан

Огноо: 2025.06.24

No	Овог нэр	Холбоо барих утас	Хүйс	Эрхэлж байгаа ажил (хувиараа бизнес эрхэлдэг, тэтгэвэрт, гэрийн эзэгтэй гэх мэт)	Гарын үсэг
1	Ж. Санжаа	96055755	эр	Тэтгэвэрт 1Г баг.	
2	Ц. Одончимэг	89510500	эм	Хүчхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан	
3	А. Энхтор	95837480	эр	4Р багийн засаг дарга	
4	Д. Хишигжаргал	94001131	эм	4-р багийн нягтлан бодогч	
5	М. Ганбаатар	9995 9978	эр	Ахмадын хорооны дарга	
6	Л. Отгонтуяа	90956252	ажилгүй	Засаг даргын ажлын	
7	Б. Цэцэгмаа	99932497	эм	МХБ-ын багш	
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					

Сайхандулаан сумын бүлгийн ярилцлагын тэмдэглэл

Төслийн талаар мэдээлэл авсан уу?

- Мэдээлэл авч амжаагүй.

Та төслөөс ямар хүлээлттэй байгаа вэ?

- Энэ агаарын шугам тавигдснаар бидэнд ямар үр өгөөж өгөх, сум орон нутгийн нийгэм эдийн засагт ямар ач холбогдолтой байх талаар төсөл хэрэгжүүлэх нэгжээс мэдээлэл өгөхийг хүсэж байна. Бид нар энэ талаар мэдээлэлгүй болохоор хэлж мэдэхгүй байна. Цагаан суварга яагаад Оюу Толгойгоос тогоо татсан хэвээрээ байж болохгүй гэж? Дорноговь аймаг тогны хүртээмжгүй. Дахиад ЦДШ татахаар энэ шугам Дорноговь аймагт ямар нөлөө үзүүлэх вэ? Манай нутагт ямар сөрөг нөлөө үзүүлэх вэ? Дорноговь аймгийн эрчим хүчийг нэмэгдүүлэх үү? Суурь судалгаатай нь танилцмаар байна. Төмөр зам шиг хэдэн км-т айл бууж болохгүй гэсэн заалт байгаа юу?

Орон нутгийн амьдралд хэрхэн нөлөөлж болзошгүй гэж та үзэж байна вэ? Энэ төсөл таны орон нутгийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж болох вэ? Эдийн засаг ба ажил эрхлэлт:

- Ажиллах байх. Манай сумын хувьд алслагдсан 3 багийн өрхүүд ихэнх нь малчид байдаг. Сумын төв дээр байгаа ажилгүй хэдэн хүн байгаа. Ажиллах хүчин хэрэгтэй гэвэл залуучууд бүртгүүлэх байх. Биеийн хүч шаардсан ажилд манай залуучууд сайн. Малчидтайгаа тохироод мах, сүү цагаан идээ авахад асуудал байхгүй. Барилгын ажил эхлээд орон нутагт кэмп байгуулахад үед хоол хүнсний түүхий эдээ тухайн орон нутгаас аваасай гэж хүсэж байна.
- Мөн барилгын явцад тээвэрлэлт их хийгддэг. Манай суманд тээвэрлэлт хийдэг жолооч нар байдаг. Тээвэрлэлт хийх хүмүүсийг тухайн орон нутгаас авч ажиллуулаасай. Цаг хүндрэх үед жолооч нар бид нарт тус болдог. Машин механизмаар төгссөн мэргэжилтэй хүмүүс байгаа. Эдгээр хүмүүсийг ажлын байраар хангаж өгөөрэй. Хуучин уурхайд явж байсан туршлагатай. Түр хугацааны ажлын байр гаргаж өгөөрэй.
- *Эрчим хүчний хангамж ба найдвартай байдал*: Эрчим хүч хангалттай биш. Манай шонгоос баруун тийшээ иргэний нисэх, зүүн хойшоо уурхай гэх мэтчилэн олон салаалсан. 3.80-ийн тог авъя гэхээр танай толгой дийлэхгүй гэдэг.
- *Дэд бүтэц ба олон нийтийн үйлчилгээ:* Цэцэрлэг, дотуур байр, сургууль цахилгаан халаагуур ашигладаг. Өмнө нь соёлын төв цахилгаанаар халдаг байсан. Манай сум инженерийн шугам сүлжээнд

холбогдоогүй. Цэцэрлэг том тогоонд хоолоо хийхээр тог нь дийлдэггүй гээд жижиг тогоонд хоолоо хийдэг.

- *Газар, мал, орон сууц:* Хоёр уурхай бий. Уурхайд 10 орчим хүн ажилладаг.

Танай орон нутагт ямар төрлийн соёлын болон оюуны биет бус өв байдаг вэ? Төслийн нөлөөлөлд хэрхэн өртөж болзошгүй гэж та бодож байна вэ?

- Тахилгатай уул овоо трассын шугамын дагуу байхгүй. Говьд үлэг гүрвэлийн олдворууд олдох магадлал өндөр. Дараах 5 тахилгатай уулыг жил бүр тахидаг:
    - Урд талд Өлзийт хайрхан
    - Баруун талд Загал
    - Хойшоо эргээд Баян овоо
    - Бага дулаан
    - Их дулаан

Та энэ төслийн хамгийн гол эерэг нөлөө нь юу байх болно гэж үзэж байна вэ?

- Улс орны бүтээн байгуулалт, эрчим хүч тавигдаж байхад татгалзах зүйл байхгүй.

Төслийн талаар та эсвэл танай орон нутгийн иргэдийн хамгийн их санаа зовж буй зүйл юу вэ?

- Говьд байгаа ховор ан амьтан. Хамгийн их байдаг амьтан шувуу. Өндөр хүчдэлээс болж хамгийн их үхдэг амьтан шувуу юм шиг байгаа.

Эдгээр асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авах вэ? Таны санал юу байна вэ?

- Байгаль орчны хамгаалалтыг сайн хийж иргэдэд тайлбарлах. Газардуулагч сайн хийх.

Төслийн мэдээллийг хэрхэн болон хэзээ авахыг хүсэж байна вэ? Та уулзалт эсвэл хэлэлцүүлэгт оролцох уу?

- Багийн иргэдийн нийтийн хурлаар мэдээллийг хүргэвэл иргэдэд хүртээмжтэй.

Нэмэлт санал хүсэлт байгаа эсэх:

- Санал хүсэлт байхгүй.

Сайхандулаан сумын бүлгийн ярилцлагын зураг

ECO TREND

ARCADIS

Хавсралт G Гомдол гаргах журам



Хавсралт Н Төслийн гомдлын маягт

Лавлах дугаар (Протоколын дугаар)	
Нэр/Овог *Тэмдэглэл: Та хувийн мэдээллээ гуравдагч этгээдэд задруулахгүйгээр нэрээ нууцалж болно.*	
Гомдлын огноо:	
Холбоо барих мэдээлэл Тантай хэрхэн холбогдох тухай тэмдэглэнэ үү.	○ Шуудан ○ Утас ○ И-мэйл
Болсон явдал, гомдлын тайлбар: Юу болсон бэ? Хаана болсон бэ? Хэнд тохиолдсон бэ? Энэ асуудлын үр дагавар?	
Болсон явдал, гомдлын огноо:	
	○ Нэг удаа ○ Нэг удаа биш ○ Үргэлжилж байна
Асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг хүсэж байна вэ?	

Хавсралт I Гомдол барагдуулах бүртгэлийн загвар

Нэр/Холбоо барих мэдээлэл	Гомдол шийдвэрлэх арга (ЭХЯ/ТХН рүү шууд, барилгын гүйцэтгэгч, сум, эсвэл багаар дамжуулан, Bagh эсвэл Сум-оор дамжин):	Лавлах дугаар	Хариуцах ашилтан (нэр, албан тушаал)	Хүлээн авсан огноо	Гомдол гарсан огноо	Гомдлын дэлгэрэнгүй мэдээлэл (асуудал, одоогийн авсан арга хэмжээ, эхэлсэн хугацаа – бүх дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай)	Үйл ажиллагаа (MoE/PIU-д асуудлыг шийдэх эсвэл гомдлыг дараагийн түвшинд шилжүүлэх дараагийн алхмууд)	Үйл ажиллагааны хариуцлага	Огноо шийдвэрлэх шаардлагатай	Огноо шийдэгдсэн	Дараагийн үйлдлүүд шаардлагатай ба огноо

Хавсралт J Оролцогчдын бүртгэлийн загвар

Нэр/Холбоо барих мэдээлэл	Хариуцах ЭХЯ/ТХН-ийн ажилтан (нэр, албан тушаал)	Албан тушаал Оролцооны арга	Холбоо барих мэдээлэл	Сэдэв	Асуудал	Шаардлагатай дараагийн арга хэмжээ

Хавсралт К Хурлын тэмдэглэлийн загвар

Хурлын тэмдэглэл	
Хэлэлцүүлгийн огноо	
Зөвлөгөөний төрөл	○ Нүүр тулсан ○ Хэлэлцүүлгийн бүлэг ○ Олон нийтийн хурал ○ Хэвлэлийн хурал ○ Бусад
Байршлын хаяг	
Хот/Тосгоны хаяг	
Оролцогч талын холбогдох хүн	
Оролцогч тал хувь хүн, эсвэл бүлэг	
Төлөөлөгчид	
Бусад оролцогчид	
Нууцлал	○ Тийм ○ Үгүй
Хэлэлцүүлэг	
Асуудал	
Гомдол, хүндрэл, санал гомдол	
Хавсралт	

Аркадис Консалтинг (Их Британи) Лимитед

80 Фенчёрч гудамж
Лондон EC3M 4BYU
Их Британи

Утас: +44 (0)20 7812 2000

arcadis.com